Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл 2012. 02 сар. №003 (013) www.mongolianeconomy.mn

Хөрөнгийн бирж хөрсөө шинэчилж байна

Монгол: Салаа замын уулзварт

Бид ажилгүйчүүдийн эгнээнээс гарч чадсан!

Ирээдүй маань харшилж, өвчилж, хордож байна



Шог зургийг А.Амарсайхан



Swiss Watch Shop Наран Пойнт Дэлгүүр, Хувьсгалчдын гудамж. Утас: 326435
SWS Shop Наран Молл, 2-р давхар, Сөүлийн гудамж. Утас: 328841

Shandong Equipment LLC

SEM

КАТЕРПИЛЛАРЫН 100% ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ БНХАУ –ИЙН SEM MACHINERY КОМПАНИЙН АЛБАН ЁСНЫ ДИЛЛЕР ШАНДОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХХК

ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН УЛИРАЛ АЙСУЙ!

ДУГУЙТ АЧИГЧ - ТАНЫ ХЭРЭГЦЭЭНД ТОХИРСОН ХҮЧИН ЧАДЛЫН ӨРГӨН СОНГОЛТ


SEM 616B/618C


SEM 630B/636B


SEM 639B/639C


SEM 658C/659C


SEM 650B/660B


SEM 668C/669C




SEM 919/921


SEM 922


SEM 6020


SEM 8218


SEM 8220


SEM 8222

МОТОР ГРЭЙДЕР - МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР **ЗАМЫН ИНДУУ**

КАТЕРПИЛЛАР –ийн албан ёсны диллер “Вагнер Ази Тоног Төхөөрөмж” ХХК нь БНХАУ дахь SEM Machinery компанийн бүтээгдэхүүнийг Монгол улсад төлөөлөх бүрэн эрхтэй болсон бөгөөд ШАНДОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХХК –ийг үүсгэн байгуулан ажиллаж байна. SEM Machinery компани нь зам, барилга, уул уурхайн машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, үйлчилгээгээр БНХАУ –даа тэргүүлэгчийн эгнээнд багтдаг бөгөөд КАТЕРИПИЛЛАР –ийн чанарыг бүтээгдэхүүндээ шингээсэн байдгаараа бусдаас ялгардаг.

Бид Монгол улсад ажилласан 15 жилийн туршлагадаа үндэслэн SEM брэндийн бүтээгдэхүүний сэлбэгийн хангамж, засвар үйлчилгээ, оператор сургалт болон борлуулалтын дараах өргөн хүрээний үйлчилгээг хүргэж байна.

Шандон Тоног Төхөөрөмж ХХК
Баянгол дүүрэг, Баруун Үйлдвэр-133, Ш/х-26, Улаанбаатар-16030, Монгол Улс
Утас: 976-687588 Факс: 976-11-687587
www.shandongequipment.com

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр 9999 4248

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал 8800 6228

Англи хэлний редактор:
Terrence Edwards

Сэтгүүлч:
Х.Хулан
Э.Зоригт
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Б.Уганбаяр

Дизайнер, Вэб мастер:
Ш.Оюундарь

Маркетингийн менежер:
Д.Барианжав 8880 0825
С.Жавхлан 99620780
Б.Энхцэцэг 9901 5476

Борлуулалтын менежер:
С.Цэнд-Аюуш

Хаяг:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23
Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Зиг заг" автосервис
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет "Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mal"

Эрхлэгчийн зурвас



Амар мэндээ мэдэлцэж, ахас дээдсээ хүндлэн дээдэлдэг Монголын цагаан сараар “Mongolian Economy” сэтгүүлийн шинэхэн дугаар гарч, уншигч, захиалагчидтайгаа учран золгож байгаад баяртай байна. Монгол ёсонд айл өрх идээний өнгө, буузны амтаараа шинэ айлчлах жилдээ ямар явах ноён нуруугаа шинждэг уламжлалтай. Харин Монгол Улсын хувьд ертөнцийг алмайруулсан эдийн засгийн өсөлт луу жилд улам хүчирхэгжин тогтворжихын ерөөлийг дэвшүүлье.

Цагаан сарын үеэр бараг долоо хоног нийтийн амралт таарч буй. Монголчууд зөвхөн дайлж цайлж, золгож бүтэн долоо хоногийг өнгөрөөнө. Энэ нь сайхан санагдах ч айл бүр байнгын хоол цай хийж, гал түлэх учраас агаарын бохирдлын хэмжээ энэ үеэр огцом нэмэгдэх нь мэдээж. Бодвол энэ дүр зураг нь утааг хэмждэг зориулалтын станцын багажинд “буудаг” биз ээ. Юу болоод Цагаан сарын үеэр утаа яриад байна гэж Та гайхаж магадгүй. “Mongolian Economy” сэтгүүл хавар болж өтгөн утаа замхархаас өмнө бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчдад агаарын бохирдлын бодит байдал ямар байна вэ, хүн бүрийн уушгийг сэвтүүлсэн хорт утаатай төр, засгийн тэмцэж байгаа арга зөв байна уу, зөвхөн төр, засаг биш, бүгдээрээ эрүүл мэндээ хамгаалж юу хийх ёстой вэ зэрэг асуудлыг цогцоор нь хөндөж хүргэлээ. Та ууцаа хөндөж, буузаа идэн сайхан шинэлэнгээ хотын утааг яавал дээр вэ гэдэг мэргэн ухааныг зочид гийчидтэйгээ уралдуулаарай.

Монголын ард түмэн сар шинэдээ сайхан шинэлэхийг ерөөлийг өргөе.

Орлогч эрхлэгч И.Отгонжаргал

Агуулга

Ирээдүй хойч маань харшилж, өвчилж, хордож байна



Дэнжийн мянгад агаар хэцүү л дээ. Гэхдээ энэ голомтот газрын дэргэд “Цэвэр агаартай” юм байна гэдэг бодол төрснийг нуух юун. ...9

Хүнийхээ эрүүл мэндэд анхаараачээ



...Эмч нар “Бид модон чагнуур бариад л бүх өвчнийг анагааж чадахгүй. Гэтэл утаатай холбоотой өвчлөлүүд гаарсаар байна...12

Нэг толгойд зуун жанжин



Нийслэлийн утааг багасгах ажил нь төр, засгийн байгууллагуудын хаана нь төвлөрч, зангидагдаж байгааг мэдэхэд тун бэрхтэй байна гэдэг яриа иргэдийн дунд гарч байна...17

Нийгэм

8 Уушиггүй Улаанбаатар

9 Ирээдүй хойч маань харшилж, өвчилж, хордож байна

11 Сүүдэр дайрсан ирээдүй

12 Хүнийхээ эрүүл мэндэд анхааараачээ

13 Уучлаарай, Улаанбаатарыг

15 Нүдэнд бус багажинд л мэдрэгдэнэ

16 Та утааг бууруулах ямар санал санаачилга гаргах вэ?

17 Нэг толгойд зуун жанжин

18 Өвчинтэй Улаанбаатар

20 Хотын утааг шингэрнэ гэж горьдохгүй л байхаас даа

22 Нялх хотын төрх

24 Манан дундах “Алуурчин”

26 Хоол олдоно, ходоод олдохгүй

28 Утаанаас эрүүл мэндээ хэрхэн хамгаалах вэ

Эдийн засаг

32 Аадар бороо ган тайлдаггүй

34 Нэгэн өсөлтөөс өөр нэг бууралт руу

38 АНУ яагаад Иракаас гарсан бэ?

40 Гэрэл зөөгч

45 IPO хийхэд таагүй болжээ

Бизнес

42 Зээлээ аваарай

44 Манай нийтлэлийн дараа

Өвчинтэй Улаанбаатар



Гандангийн хороолол нь хотын төвтэй хаяа нийлэн байрладагучраас Улаанбаатар хотын нүүр царай болдог гэхэд хилсдэхгүй.... 18

Манан дундах “Алуурчин”



...Өвлийн эхэн сарын 5-ны тэр өдөр гэнэт ер бусын зузаан манан хотыг бүрхээд авчээ....24

Зээлээ аваарай



Их хүлээлт тээсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг энэ сарын 9-нд УИХ-аар хэлэлцэж баталлаа.. 42

http://www.mongolianeconomy.mn

Эдийн засаг

Хөгжилд хамтдаа

"Монголын эдийн засгийн чуулган-2012"-ыг гурав дахь жилдээ зохион байгуулах гэж буйтай холбогдуулан Сангийн дэд сайд Ч.Ганхуяг, ҮХШХ-ны дарга Ч.Хашчулуун, Монголын Улсын Ерөнхийлөгчийн эдийн засгийн зөвлөх П.Цагаан, УИХ-ын гишүүн С.Оюун тэргүүтэй төлөөлөгчид хэвлэлийн хурал хийлээ. Өнөө жилийн эдийн засгийн бодлогын чуулганыг ирэх сарын 5, 6-нд Төрийн ордонд "Хөгжилд хамтдаа" уриатайгаар зохион байгуулах гэж байна. Чуулганы хүрээнд Эдийн засгийн хөгжил: Оролцоотой өсөлт, Нийгмийн бодлого: тэнцвэртэй өсөлт, Өрсөлдөх чадвар: Инноваци ба ногоон шийдэл гэсэн үндсэн гурван чиглэлээр салбар хуралдаан зохион байгуулах аж.

Хямд "бэлэг"

Жил бүрийн гуравдугаар сарын дундуур хаврын



махны үнэд интервенц хийх зориулалттайгаар нөөцийн махыг зах зээлд нийлүүлдэг уламжлалтай билээ. Харин энэ жил нөөцийн махыг графикт хугацаанаас нь бараг сарын өмнө худалдаанд гаргалаа. Энэ нь инфляци өндөр байгаатай холбоотойгоор иргэдэд харьцангуй хямд үнэтэй мах нийлүүлэх явдал юм. Түүнчлэн Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Монголын мах үйлдвэрлэгчдийн холбоо хамтран нийслэлийн зургаан дүүрэгт нөөцийн махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулав. Үхрийн махыг нэг кг нь 3700, хонины мах 3200, ямааны махыг 2600 төгрөгөөр тус тус борлуулжээ. Үүнийг зах зээлийн үнэтэй харьцуулахад бараг хоёр дахин хямд үнэтэй байгаа учраас нөөцийн маханд урт дараалал үүссэн байна. Ерөнхий сайд С.Батболд нөөцийн махны өргөтгөсөн худалдаатай танилцаж, Чингэлтэй дүүргийн Долоон буудлын мах худалдаалах төвд саатсан билээ.

Жижиг, дундынхан чуулаа

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарынхан, тэр дундаа Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын III зөвлөлгөөн энэ сард боллоо. Салбарын бодлого баригчид, эрдэмтэн судлаачид, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хот, хөдөөгийн төлөөлөл багтсан 1000 орчим хүн хуралд оролцсон. Энэ үеэр жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг тогтож, орон нутагт Сум хөгжүүлэх сан болоод ЖДҮ–ийг дэмжих сангийн зээл хэр үр дүнтэй байгаа талаар хэлэлцжээ.

Ногоон эдийн засаг

Салхин станц барина

Монгол Улсад уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн хүрээнд "Сэргээгдэх эрчим хүч-2012" форум болж өндөрлөлөө. "Сүүлийн 50 жил дэлхийн хүн ам 2.5 дахин өөрөөр хэлбэл, 2.5-аас долоон тэрбум хүртэл нэмэгдсэн байна. Энэ хугацаанд нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ тав дахин өссөн үзүүлэлттэй гарч, өөрөөр хэлбэл эрчим хүчний хэрэглээ 12 дахин нэмэгджээ. Тиймээс уламжлалт бус сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах шаардлагатай болж байна" хэмээн Монголын сэргээгдэх эрчим хүчний холбооны тэргүүн, доктор Б.Бат форумын үеэр тэмдэглэсэн юм. Энэ удаагийн форумд ус, нар, салхины цахилгаан станц, газрын гүний дулааныг ашиглах техник технологи, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг салбарын тулгамдсан асуудлыг хэлэлцэж, хэтийн хөгжлөө тодорхойллоо.

Уул уурхай

"Coal Mongolia-2012"

"Нүүрс-Монголын эдийн засгийн эрчимтэй хөгжлийн



хурдасгуур" уриатай "Coal Mongolia-2012" Олон улсын чуулга уулзалтад 300 гаруй уул уурхайн хайгуул, олборлолт, ханган нийлүүлэгч компанийн 750 гаруй төлөөлөгч оролцлоо. Тус чуулга уулзалт нь Монгол Улсад хэрэгжүүлж буй нүүрсний хайгуул, олборлолт, боловсруулалтын төслүүдэд хөрөнгө оруулалт татах, байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилт техник технологи нэвтрүүлэх, олон улсын харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой байв.

Бизнес

Баярт мэдээ

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн толгойны өвчин болдог барьцаа хөрөнгөгүйн улмаас зээл авч чаддаггүй асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэх Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль энэ сарын 9-нд УИХ-



аар батлагдлаа. Хуулийн хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтарсан Зээлийн батлан даалтын санг байгуулан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 20 сая хүртэлх төгрөгийн зээлийг 60 хүртэл хувийн батлан даалттайгаар авах боломжийг олгож байгаа аж. Тус сан 11 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөлтэй байх бөгөөд үйл ажиллагаанд нь Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавих аж. Зээлийн батлан даалтын сан нь үйл ажиллагаа явуулж эхэлснээр олон хүний амьдрал ахуйг өөд татаж, шинэ боломжийг олгоно гэдгийг хууль санаачлагчид онцлов.

"Торгоны зам-2012"

МҮХАҮТ-аас хоёр жил тутамд зохион байгуулдаг "Торгоны зам" ёслолын арга хэмжээ болж өнгөрлөө. Тус арга хэмжээ нь Монгол орны хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа олон улсын байгууллагууд, хоёр талын техник туслалцааны болон бусад гадаадын санхүүжилттэй хэрэгжиж байгаа төслүүд, дипломат төлөөлөгчийн газрууд, гадаадын хөрөнгө оруулагчид, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд болон гадаадын иргэдийг онцлон шалгаруулдаг юм.

http://www.mongolianeconomy.mn

Нийгэм

Жолооч минь хариуцлага

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль өнгөрсөн онд батлагдаж, энэ оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны мэргэжилтнүүд болон АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Бизнесийг дэмжих санаачилга төслийн зөвлөх хатагтай Кирстен Армстронг нар “Жолоочийн даатгалын тухай хууль ба олон улсын туршлага” сэдэвт дугуй ширээний уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Оюутнуудын “цалин” буулаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсны дагуу УИХ өнгөрсөн оны хавар их, дээд сургуульд суралцаж буй Оюутнуудад сар тутамд тэтгэлэг олгох тухай хуулийн төслийг баталсан юм. Тэгвэл хуулийн дагуу энэ сараас эхлэн магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн оюутнуудад 70 мянган төгрөгийг олгож эхэллээ. Тэтгэлгийг 10 сарын хугацаанд 152 мянган оюутанд нийт 106 тэрбум төгрөгийг олгох юм байна. Ингэхдээ оюутнуудад тодорхой хэмжээний шалгуур үзүүлэлтүүдийг тавьж тэтгэлгийг ялгавартайгаар олгох ажээ. Онц сурдаг, амжилттай сурч буй оюутнуудын авах тэтгэлгийн хэмжээ нэмэгдэнэ гэсэн үг.

Эрүүл мэнд

Биеэ үзүүлээрэй

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зургадугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу бүх иргэдийг заавал даатгалд хамруулах үүднээс одоо эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байгаа 344.4 мянган иргэний 4.5 жилийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөхөд улсаас 9.3 тэрбум төгрөг зарцуулахаар болсон. Энэ нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэн бүрийг жилд нэг удаа нэг сая төгрөгтэй дүйцэхүйц үзлэг, оношлогоо, төрөлжсөн эмчилгээнд үнэгүй хамрагдах нөхцөлийг бүрдүүлж байгаа гэдгийг Эрүүл мэндийн дэд сайд Ж.Цолмон “Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах нь” сэдэвт уулзалтын үеэр онцлон тэмдэглэв.

Дэлхий дахинд

Хятадад

Европын хямрал дордвол Хятадын эдийн засгийн үзүүлэлт одоо байгаагаасаа хоёр дахин буурах гэнэ. Олон улсын валютын сангаас дэлхийн эдийн засгийн “цаг агаарыг” тогтмол хянаж байдаг. Тэдний гаргасан урьдчилсан мэдээгээр манай урд хөршийн эдийн засгийн өсөлт энэ жил 8,2 хувь байна гэсэн хүлээлттэй байсан боловч дөрвөн хувиар буурах хандлага байгаа аж.

Хүнсний үнийн өсөлт

Өдөр ирэх тусам хүнсний бүтээгдэхүүний үнэ өсч байгаа нь хөгжиж буй орнуудад ихээхэн дарамт болж байна хэмээн ВВС агентлаг мэдээллээ. “Save the Children” тусламжийн байгууллагаас Энэтхэг, Бангладеш, Перу, Пакистан болон Нигер улсын айл өрхүүдэд амьжиргааны судалгаа хийсэн байна. Судалгаагаар дээрх орнуудын олон зуун хүүхэд өдөр тутмынхаа хоол хүнсийг залгуулахын тулд сургуулиа хаян ажил хийж, эцэг, эхдээ туслахыг илүүд үзэх болжээ. Зургаан айл тутмын нэгд ийм амьдрал бий болж буй аж.

Орост


Хойд хөршид мөнгө угаах явдал ихэссэн тухай Оросын РТ суваг мэдээллээ. Өнгөрсөн жилд нийт 66,7 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний мөнгө угаасан нь тус улсын ДНБ-ний дөрвөн хувьтай тэнцэхүйц үзүүлэлт



юм. Тэргүүн дэд сайд Виктор Зубков “ОХУ-ын эдийн засагт мөнгө хүүлэх асуудал нь аюулын харанга дэлдэж байгааганхааруулсаарирсэн билээ. 2011 онд бүртгэгдсэн гадагш чиглэх валютын урсгал болох 84 тэрбум ам.долларын 40 гаруй хувь нь ямар нэг байдлаар мөнгө угаах гэмт хэргийн шинжийг агуулж байна” гэж мэдэгдсэн байна. Тэрбээр одоогоор хууль бус санхүүгийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох Ажлын хэсгийг удирдаж байгаа аж.



http://www.mongolianeconomy.mn



Шог зургийг А.Амарсайхан

Сүүдэр дайрсан ирээдүй
Уучлаарай, Улаанбаатарыг
Нүдэнд бус багажинд л мэдрэгдэнэ
Нэг толгойд зуун жанжин
Өвчинтэй Улаанбаатар
Хотын утааг шингэрнэ гэж горьдохгүй л байхаас даа
Нялх хотын төрх
Хоол олдоно, ходоод олдохгүй

Онцлох сэдэв

Уушиггүй Улаанбаатар

Улаанбаатархотыгхүнтэйзүйрлэхюм бол амьсгалах эрхтэн болох уушиг нь хүнд өвчилж, эрчимт эмчилгээний тасагт хүргэгдэх хэмжээнд очсон гэж үзэж болно. Уушиг нь устсан хүн удаан амьдардаггүй. Тэгвэл Монголын нийслэлийн уушиг нь өвчлөөд ужгирч байна. Ужиг өвчин эмчилгээ авахдаа удаан, сэдрэх нь амархан байдаг. Тийм болохоор хотын утаа хэр баргийн салхинд хөөгдөхөө больж, дөрвөн уулынхаа дунд манантан тунараад л байдаг болж. Тэрбитгий хэл, "... энэ одоо утаа юу, манан уу" гэж мэл гайхахаар сонин үзэгдэл Улаанбаатар хотод энэ өвөл хоёр ч удаа болсныг хүмүүс мэдэж байгаа байх. Тухайн үедээ зарим сонин хэвлэлээр цочир хүйтэрсэнтэй холбоотой манан буусан тухай мэдээлээд өнгөрсөн. Гэтэл учир явдлыг утаа гэдэг бодит шалтгаантайгаа холбоод үзвэл үл тоосон байдалтай өнгөрөөж огт болохгүй байж. Өөрөөр хэлбэл, тэрхүү утаат манан нь Улаанбаатарын ужиг өвчин улам бүр хүндэрч аюулын харанга дэлдэж байгаагийн дохио байсан тухай яриа зарим эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн амнаас цухалзаад өнгөрсөн юм даг.

Хүн төрөлхтний түүхэнд утааны асуудал шинэ зүйл биш. Өөрөөр хэлбэл, дэлхийн томоохон хотуудын тойрч биш, дайрч гардаг асуудал. Гагцхүү аль орон асуудлыг хэрхэн зөв шийдэж, даван туулсан бэ гэдэгт л байгаа юм. Тиймээс "Mongolian Economy" сэтгүүл хавар болж утаа арилахаас өмнө Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудлыг хоёрдугаар сарын сүүлийн дугаартаа онцоллоо.

Агаарын бохирдлын тухай хэлэх ярих хүн олон байгаа ч хийж хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ нь хэр үр дүнтэй байна вэ гэдэг асуудал дээр нийтлэлийн бодлогыг чиглүүллээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд төр, засгийн зүгээс энэ чиглэлд анхаарал хандуулж, бүрэн шаталттай зуух, гэрийн дулаалга, гонх зэргийг хөнгөлөлттэй үнээр тарааж, нийслэлийн гэр хороололд хязгаарын бүс тогтоож, орон сууцжуулах хөтөлбөр баталж янз бүрээр тэмцэж эхлээд байна. Гэхдээ уудам Монголын нийслэл утааны голомт болчихно гэж хэзээ ч төсөөлж байгаагүй учраас төр, засгийн зүгээс багагүй зүйл хийж буй ч өргөн далайцтай, үр дүн гарах хэмжээнд зохион байгуулж чадаж байна уу гээд ажиглавал бас ч тиймгүй. Агаарын бохирдол монголчуудын хувьд шинэ зүйл учраас төр, засгийн хэмжээнд хийж хэрэгжүүлж байгаа ажилд хүч хөрөнгө, санал санаачилга, туршлага, сургамж дутаж байгаа юм. Тийм болохоор утааг багасгах нь зөвхөн төр, засгийнхны хар толгойгоороо хариуцах ажил биш, нийтийн эрүүл мэндийн төлөө нийгмээрээ хөдлөх ёстой юм шиг ээ.

Тараасан утаагүй зуух, түлш, нам даралтын зуухандаа найдаад суух биш, улс орон даяар гаазжуулах хөдөлгөөн өрнүүлж, гэр хорооллын 180 мянган яндангаа өнөөдрийн хэмжээнд нь тогтоон барих шаардлага байна. Тэгэхийн тулд хөдөө, орон нутгаас шилжин иргэсдийг нэг хэсэгтээ Улаанбаатар хотод хүлээн авахгүй байх, нийслэлд амьдрах бол өндөр татвар авдаг болох гээд шинэ санал санаачлагыг дэвшүүллээ. Гарц хайсан, магадгүй зарим ажил хариуцсан хүнд ташуур болох хэд хэдэн нийтлэлийг УИХ, Засгийн газар, Эрүүл мэндийн сайд нарт хаяглалаа.

Мөн www.mongolianeconomy.mn цахим хуудсаар төр, засгийн зүгээс утааг бууруулахаар хийж байгаа арга хэмжээнүүдээс алийг нь үр дүнтэй гэж бодож байна вэ гэсэн санал асуулгыг 14 хоногийн хугацаатай зарлалаа. Үр дүнг нь Та графикаас хараарай.

Утааг бууруулахаар төр, засгаас авч хэрэгжүүлж буй дараах аргуудаас аль нь илүү үр дүнтэй вэ?



http://www.mongolianeconomy.mn

Сурвалжлага

Ирээдүй хойч маань харшилж, өвчилж, хордож байна

Э.Зоригт

Бид утааны голомт газруудын нэг болох нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн IX дүгээр хороо буюу Баянхошууны эцсийн буудлаас хорт утаан дунд хүмүүс хэрхэн аж төрж байгааг сурвалжиллаа.

2012.02.14. 08.30 цаг. Хэдийнэ нар дээр хөөрсөн ч өтгөн утаа зам харанхуйлан тунарч, ажил албандаа яаран буй жолооч нар машины гэрлээ асаан явах аж. “Хороолол-гандан” гэж Баянхошууны эцсийн буудал дээр чанга дуугаар хашгирах микро автобусны мөнгө хураагч бөөн утаа залгин бөгшүүлэн ханиалгана. Утаа сорсоноо мэдэж “... пи муу хар утаа...” хэмээн амандаа хараан зүхэж, үргэлжлүүлэн хаа явах чиглэлээ өндөр дуугаар зарлана.

Дээрх утааны голомт нь манай сэтгүүлийн редакци УИХ, Засгийн газрын төлөөлөл болоод холбогдох албаныхныг авч явж, бодит байдалтай нь газар дээр нь танилцуулахаар товлосон газруудын нэг байсан юм. Хэрвээ УИХ-ын гишүүдийн төлөөлөл энд ирсэнсэн бол их л “сайхан” юм болох байж дээ гэж би дотроо бодож байлаа. Учир нь, төр, засгийн хүмүүсийн олонхынх нь амнаас “Улаанбаатар тэр аяараа утаатай байхад бодит байдал ямар байгааг өглөө, оройд биеэрээ л мэдэрч байна даг. Заавал гэр хороололд очиж үзэлтгүй л утаан дундуур явж байна” гэж бааварлах нь бий. Би ч гэсэн нийслэлийн хамгийн өтгөн утаатай хэсгүүдийн тоонд ордог Чингэлтэй дүүргийн Дэнжийн мянгад амьдардаг. Тийм болохоор утаан дунд амьдарч, эрүүл мэндээрээ хохирч яваа нэгэн гэж өөрийгөө бодож явлаа. Гэтэл дээрх сурвалжлага хийсэн есдүгээр хороонд ирээд бодол минь даруй өөрчлөгдлөө, бас өөртөө олзуурхав.

Дэнжийн мянгад агаар хэцүү л дээ. Гэхдээ энэ голомтот газрын дэргэд “Цэвэр агаартай” юм байна гэдэг бодол төрснийг нуух юун. Манай тэрүүгээр хэдий их утаатай ч машинууд арай ч гэрлээ асааж явдаггүй. Энд бол асаахаас аргагүй байдалтай байв. Зуун метрийн өмнөх юм бүдэг бадаг харагдаж байсан гээд бод доо. Гэвч хорооны жаалууд хээвнэг хичээлдээ гүйлдэж, бяцхан үрээ цэцэрлэгт нь хүргэхээр хөтөлсөн, тэвэрсэн аав, ээжүүд хажуугаар яаран зөрнө.

09.00 цаг. Хорооны байрыг зорихоосоо өмнө ойролцоох автобусны буудал дээр нь жаахан зогсож, утаан дундах саарал амьдралыг ажиглалаа.

Нийтийн тээврийн том оврын автобусны урд нүүрэн хэсгийн хамгийн дээр байрлуулсан шугамын чиглэлийг ч хүртэл утаан дунд харж уншина гэдэг нүдний хараа нэлээд шалгасан ажил байв. Гэхдээ эндхийн хүмүүс сурчихсан бололтой, аль шугамын автобус болохыг төвөггүйхэн танина.

09.15 цаг. IX хорооны Засаг дарга Л.Бямбадоржтой уулзлаа. 40 орчим насны намуухан дуутай Хорооны Засаг дарга найрсагаар угтаж “Утаа манай энд аймаар байгаа биз дээ” гээд бас л ханиалгав. Түүнээс утааг бууруулах талаар юу хийх ёстой гэж боддог вэ, Засаг даргын хувьд гэж сонирхоход төр, засгийхан л сайн ажиллах хэрэгтэй гэж баахан улстөржсөн чанартай зүйл ярив. Бид хоёр багагүй хугацаанд хөөрөлдсөн ч ихэнх яриа улс төртэй холбоотой байсан юм. Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай буюу 260 мянган өрхтэй Сонгинохайрхан дүүргийн есдүгээр хороонд 9000 орчим иргэн оршин суудаг бөгөөд нийт 1800 гаруй өрхтэй аж.

Хөх хүүхэд

09.45 цаг. Дараагийн утаат амьдралын ажиглалтаа хийхээр тус хорооны өрхийн эмнэлгийн хаалгыг татлаа. Эмнэлгийн содон үнэр хамар цоргиж, цагаан хана, хаа нэгтээ жаахан хүүхдийн зовиурлангуй уйлах дуу сонстоно. Хаалттай хаалга бүрийн өмнө хөгшид, хүүхэд ээлжээ хүлээн зогсоно. Хөл, хэлд ч ороогүй нялх хүүхдүүдийн ханиалгах, уйлах зэрэгцэж, зарим нь амьсгалж ч чадахгүй багтрах нь зүрх шимшрүүлэв. Агаарын дутмагшилтай хүүхдийнхээ тавгүйтэхийн “учрыг олоод сурчихсан” ээжүүд хамар руу нь үлээж, агаар өгч нялх үрээ амьсгалуулах ажээ. Харин хаалга нь хаалттай өрөөнд...

Есдүгээр хорооны Баруунбаян-Уул, 16 дугаар гудамжны 17 тоотод амьдардаг Н.Сарантуяа гэх 30 гаруй насны бүсгүй дөрвөн сартай нялх үрээ шаналангуй харцаар харж, эмчийн амнаас ямар үг унах бол хэмээн хүлээн зогсоно. Эмч “Танай хүү хатгалгаа тусчихсан байна. Түргэн эмнэлэгт хэвтэхгүй бол горигүй. Хүү чинь угаасаа дутуу төрсөн учраас эсэргүүцэл султай байна. Дээрээс нь агаар дутагдаад хөв хөх царайтай болчихож. Аль болох хүүгээ гадуур бага авч явж бай” хэмээн зөвлөлөө. Сарантуяа бүсгүй дөрвөн хүүхдийн эх аж. Бага хүүхдээ төрүүлэх үед ураг агаарын дутмагшилд орсны улмаас нэг килограмм 600 грамм буюу дутуу төржээ. Эх барьж авсан эмч нь түүнд “Энэ нь агаарын бохирдолтой шууд холбоотой. Одоо төрж байгаа ихэнх ураг бүтэлттэй аль эсвэл



http://www.mongolianeconomy.mn

дутуу төрж байгаа” гэжээ. Тиймээс түүний санаа бага зэрэг тайвширсан ажээ. Гэхдээ хүү нь төрснөөсөө хойш ханиаднаас салаагүй дөрвөн сарын хугацааг үджээ. Үүнийг нь эмч бас л агаартай холбоотой гэж тайлбарлажээ. Дөрөвхөн сартай нялх үр нь хоёр дахь удаагаа хатгалгаа тусаад буй нь энэ. Сарантуяа “Ханиад бол сална аа гэж байхгүй. Агаарын дутагдалд орсноос болоод хүүхдийн маань царай байнга хөх туяа татсан байдалтай байдаг болсон. Хүүхдээ салхилуулах гэхээр цэвэр агаар байхгүй юм чинь яах билээ. Хоёр хоногийн өмнө хүү бид хоёр такси олдохгүй гадаа жаахан зогссон юм. Тэгээд ханиалгаад байхаар нь ханиад хүрчихэж гэж бодсон чинь бүр хатгалгаа болчихож. Эмч нарын хэлж байгаагаар ийм байдал олон давтагдвал уушиггүй болно гэсэн. Тиймээс эмч нар ямар ч байсан хүүгээ хөлд ортол нь утаанаас хол эрүүл агаарт байлга гэх юм” хэмээн нүдэнд нь нулимс хурав.

Энэ талаар тус хорооны Өрхийн эмнэлгийн эрүүл ахуйч эмч Н.Тунгалагтуул “Манай эмнэлгийн дөрвөн эмч өдөр тус бүр 40 гаруй харшлын гаралтай ханиад, хатгалгаа арьс өнгөний өвчтэй хүн үзэж байна. Эдгээрийн дотроос дийлэнх нь тэгээс хоёр хүртэлх насны хүүхдүүд байгаа нь бүр ч эмгэнэлтэй. Тэдний ихэнх нь агаарын дутагдалд орж, хатгалгаа тусаж, улмаар даамжирч уушиг нь устахад хүрч байна шүү дээ. Ийм өвчин туссан хүүхэд маань ирээдүйд ямар ч биеийн эсэргүүцэлгүй сул дорой, хөдөлмөрийн чадваргүй хүн болж өснө гэсэн үг. Эдгээр өвчлөлийн гол шалтгаан нь ерөөсөө л агаарын бохирдолтой холбоотой” гэв.

Сарантуяа эмнэлгээс гарахдаа хүүгээ сайтар нь өлгийдөж, ам хамрыг нь битүүлээд гэрийн зүг гүйлээ. Хүү нь агаарын бохирдлоос болж дахиад ямар нэг өвчин тусах вий гэх айдаст автсан ээж гэр рүүгээ яарсан нь энэ.

Хүүхдийн мөрөөдөл

10.10 цаг. Утааны голомт зарим газарт аз болж бага, дунд сургууль байдаггүй юм билээ. Харин тус хороонд нийслэлийн 76 дугаар сургууль байрладаг. Хүүхэд бүрт мөрөөдөл бий. Тэр л мөрөөдлөөрөө жигүүрлэн амьдарч тэд ирээдүйдээ хүрнэ. Хэчнээн сайхан зүйл мөрөөднө төдий чинээ сайхан амьдардаг гээд л хүн бүр ярьдаг. Том, бүр илүү томоор мөрөөд гэж зөвлөдөг. Тийм болохоор сургуулийн барилгыг цуурайтуулсан



жаалууд утааны орчинд өсөх насаа өнгөрөөж байгаагаа ч анзаарах сөхөөгүй гэгээн амьдарч яваа. Нийслэлийн 76 дугаар сургуулийн 5А ангийн сурагч Н.Анхбаяр хөвгүүний мөрөөдөл утаагүй зуух хийдэг ямар ч хамаагүй газрын ажилтан болох гэнэ.

Тэрбээр “Манай энд утаа аймаар их ш дээ. Өглөө сургуульдаа явахад зам харагддаггүй. Хоолой зөндөө их хорсоно. Ер нь Монгол Улсад утаа их байгаа юм шиг байна билээ. Зурагтаар тэгж байсан. Харин манай энд бүүр их байгаа гэж ээж, аав хоёр ярьдаг. Эмээ, дүү хоёр маань дандаа л ханиалгаад байхаар нь би учрыг нь асуухад утаанаас болоод гэж эмээ хэлж байна билээ. Би бас ханиалгаад энэ өвөл ердөө ч зүгээр болоогүй. Уг нь зөндөө л эм уусан. Зурагтаар утаагүй зуухны тухай яриад байсан. Би том болоод тэр газарт ажилд ороод олон зуух хийж улсаа утаагүй болгоно. Тэгээд л ээж, аав, эмээ, багш гээд бүх хүн “Утаа хэцүү байна аа” гэж уурлахгүй, гоё болно” гэв.

Бөөгнөрөл ба ханиалга

10.40 цаг. Хэдийгээр хаврын урь орсон хэдий ч өглөөний жавар хөл, гар хөлдөөх шахан жиндүүлэх ажээ. Өтгөн утаа холдох болоогүй бололтой манан мэт хөшилдөнө. Сургуулийн ойролцоох нэгэн барилгын үүдэнд хүмүүс бөөгнөрсөн байхаар нь үгэнд дурлаад яваад очлоо. Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугчид 21 мянгаа авахаар “Хадгаламж” банкны үүдэнд урт дараалал үүсгэжээ. Өвлийн жавар, өтгөн утаан дундах урт дарааллын дотор таяг тулсан өндөр настан, өлгийтэй хүүхдээ тэвэрсэн эмэгтэй, “хар өглөөгүүр хаанаасаа архи олж уудаг байна аа” гэж бодохоор архичин гээд зүсэн зүйлийн хүмүүс байв. Тэд “Урдуур дайрахаа болио” хэмээн бухимдах нь их.

Ногоон дээл өмсөж, таяг тулсан бөгтөр эмээ утаан дундаас бага багаар тодрон бүртэлзсээр ирж, урт дарааллын хамгийн ард зогслоо. 11 дүгээр хорооны хоёрдугаар гудамжны 34 тоотод амьдардаг 70 гаруй настай Ц.Намжил эмээ гурван буудал хэртэй хол газраас алхаж иржээ. Тэрбээр 13-уулаа нэг байшинд амьдардаг гэнэ. Хүний хөгжлийнхөө мөнгийг авч хэдэн ач нартаа ханиадны эм авч өгөх гэж байгаа аж. Тэрбээр “Эмээ нь эхлээд одонгийн мөнгөө авна аа. Тэгээд хорооноос тодорхойлолт авч тамга даруулна. Дараа нь одонгийнхоо мөнгөнөөс 3000 төгрөг төлж нотариатаар иргэний үнэмлэхээ баталгаажуулаад, Хүний хөгжлийнхөө 21 мянгыг авахаар дахиад л дугаарлана. Утаатай л холбоотой юм байлгүй, манай гэрээр дүүрэн ханиад. Эмээ нь бас ханиалгаад л явж байна. Сар шинэдээ өвчин зовлонтой орвол тэр жилдээ өөдөлдөггүй гэдэг. Тийм болохоор эдгэрэх гээд л үзээд байна.

Амьдрал хэцүү байна аа. Тэр дундаа гэр хорооллын иргэдийн амьдрал. Хортой утаа, хоосон хонох өдрүүд ар араасаа хөвөрсөөр. Амьдралаа, амьжиргаагаа, эрүүл мэндээ, Цагаан сараа Хүний хөгжил сангийн 21 мянган төгрөгт даатгасан иргэд бөгшүүлсэн ханиалгатай бараан өдрүүдийг туулна.

Утаан дунд Монголын ирээдүй хойч үе болсон балчир үрс харшилж, өвчилж, хордож, өвчинтэй ирээдүйн хаалгыг тогшино.

“Мянга сонсохоор нэг үз” гэж ардын сайхан үг байдаг. Манай “Mongolian Economy” сэтгүүл, “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллагын зүгээс утаан дунд ард түмний аж амьдрал яажшуухан өрнөж байна вэ гэдгийг шийдвэр гаргаж, бодлого тодорхойлогчдод биеэр мэдрүүлэх зорилгоор “Утааны голомтод УИХ-ын гишүүдтэй хамт” гэсэн санал санаачилгыг гаргаад байсан боловч сонгууль дөхсөнтэй холбоотойгоор асуудал хэт улстөржих хандлагатай байсан тул уг арга хэмжээг дараа жилийн өвөл хийхээр хойшлуулсан болно. ■

http://www.mongolianeconomy.mn



Асуудал

Сүүдэр дайрсан ирээдүй

Ч.Зоёоноо

Хайр дурлал, хурим найр тэгээд хүүхэд. Энэ бол хүн бүрийн мөрөөдөл бас аз жаргалтай хамтын амьдралын эхлэл. Үр хүүхэд гэдэг өөрийн минь үргэлжлэл болохоор ч тэр үү өөгүй сайн л байх ёстой хэмээн сэтгэж түүнийхээ төлөө амь хайргүй зүтгэдэг нь хорвоогийн жам. Гэхдээ энэ агаарын бохирдол . . .

Клиникийн I амаржих газрын Хоёрдугаар тасгийн зөвлөх эмч М.Энхтуяа “Өнөөдөр нийт төрөлтийн 80-90 орчим хувь нь бүтэлттэй буюу агаарын дутмагшилтай байна. Хүүхэд нь ямар нэгэн эндэгдэл, тархины даралттай төрчихөөр эцэг эхчүүд эмч нарт л уурлаж, та нар л муу эх барьж авлаа гээд буруутгадаг. Гэхдээ эндэгдэлтэй төрөлтийн 80 орчим хувь нь эх ураг тээх явцад агаарын бохирдлын улмаас хүчил төрөгчийн дутмагшилд орсноос шууд хамаардаг гэдгийг огт мэддэггүй” гэж учирласан юм.

Ээжүүдэд зугатах газар үгүй

Өдгөө нийт ургийн эндэгдлийн 70-80 орчим хувь нь агаарын дутмагшилтай холбоотой байгаа гэсэн зүрх өвтгөсөн мэдээллийг эх баригч эмч нар ярьж байна. Тухайлбал, хортой агаарын улмаас ураг бүрэлдэх явц буюу эхний хоёр долоо хоногтоо өсөлт нь зогсдог аж. Энэ нь эрхтэн дутуу хүүхэд төрөхөд нөлөөлдөг байна. Түүнчлэн дараагийн сэтгэл түгшээсэн таагүй мэдээг дуулгахаас аргагүй. Сүүлийн үеийн төрхийн хүндрэлүүдийн дотор ургийн бойжилтын дунд үе буюу таваас зургаан сартайд “эхэс түрүүлж хөгшрөх явц элбэг ажиглагддаг болсон гэнэ. Энэ талаар Энхтуяа эмч “Эхэс түрүүлж хөгшрөх үйл явц гэдэг нь эх хэвлийдээ ураг бойжуулах хэмжээний агаарыг орчноосоо авч чадахгүйн улмаас цусны эргэлт багасч шим тэжээл дутагдах үйл явц юм. Ингээд ирэхээр эхэс ургийг тэжээхийн тулд ачаалалтай ажиллаад эхэлдэг. Энэ нь эхэс хугацаанаасаа эрт шохойжих, судас өргөсөх, цусан хангамж буурах гээд олон сөрөг үр дагаварыг бий болгодог. Уг үйл явц даамжирах юм бол ураг сүүлийн саруудад ямар ч шим тэжээлээр хангагдахгүй гэсэн үг. Өнөөдөр бид жирэмсэн эхийг төрөх хүртэл нь эмчийн хяналтад байлгадаг. Төрөх хугацаа ойртсон сүүлийн саруудад эхчүүдийн олонход нь эхэс түрүүлж хөгшрөх явц ажиглагддаг болсон. Өөрөөр хэлбэл, шим тэжээлийн дутагдалтай хүүхэд төрж байна гэж ойлгож болно” хэмээн ярьсан.

Эндээс үзэхэд, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал Н.Сайжаа гуайн хэлсэнчлэн “Манай Монгол Улс муу Монгол болчихвий дээ” гэдэг үг орой руу орж байна. Үнэхээр ийм агаараар амьсгалж байгаа ураг хамгийн наад зах нь эрүүл мэнд дорой цаашлаад оюун санааны хомсдолтой, ажлын бүтээмж доогуур хүн болж өсөх нь мэдээж. Цэцгийг услахгүй хэд хоноход үхдэг шиг ураг ч мөн түүнтэй л адил. Бидний ирээдүй эхийнхээ хэвлийд байхдаа агаараар дутаж, гарангуутаа хорт утаагаар амьсгалж, бойждог гэж бодохоор элэг эмтрэм эмгэнэлтэй санагдана. Ялангуяа дөнгөж төрсөн болон төрөх эхчүүд энэ муу мэдээг дуулаад яах ёстой вэ.

Хөдөө, орон нутагт ах дүү хамаатан садан дээрээ төртлөө, ой хүртэл нь байж утаанаас зугатаж болох юм. Гэхдээ хамаг амьдрал нь их хотод бий учраас хүн болох гээд хорвоод мэндэлсэн нялх амьтдыг Улаанбаатарын хортой агаарт өсгөж бойжуулах л болж таараа. Сүүлийн үед аймгийн төвүүд ч утаатай болсон гэж яригдаад байгаа болохоор хот, суурин газрын “азгүй” иргэдийн хувьд утааны гамшгаас хаашаа ч зугатах аргагүй болжээ.

Хуучин цэнхэр торгон дээл өмсөж цүдгэр гэдэснийхээ дээгүүр дурдан бүс бүсэлсэн 27 настай эмэгтэйг Э.Туяа гэдэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны оршин суугч тэрбээр анхныхаа хүүхдийг тээж байгаа аж. Өдгөө найман сартай ураг тээсэн түүний хувьд хамгийн аз жаргалтай баярт мөч бол үрийнхээ зулайг үнэрлэх. Гэвч залуу ээжид айдас хургаастай. Эмч нар түүний эхэс тэжээлгүй болсон байж болох талтай талаар анхааруулж, эрүүл агаарт гарч, шим тэжээлтэй хоол унд идэхгүй бол урагт нөлөөлж болзошгүйг сануулжээ. Харин түүний хувьд амьдралын боломж тааруу учраас агаарт гарах, эмч нарын зөвлөсөн амин дэм зэргийг ууж чадахгүй байгаа тухайгаа ярьж байсан. Туяагийн сэтгэлийг зогоож буй бодол нь эрүүл хүүхэд төрөх байх гэсэн итгэл хийгээд бурхан гэгч биегүй орон зайд итгэсэн сохор аз.

Туяа “Манай хотын агаар аймаар байна. Хааяа хөдөө гарахаар миний хордлого гайгүй болчихдог хотод ирэхээр сэдэрч дээрээс нь ханиалга

http://www.mongolianeconomy.mn

нэмэгддэг. Эм уух гэхээр хүүхдэд нөлөөлөх учир эмч нар хориод байх юм. Агаарын бохирдлоос болоод эмэгтэйчүүд бид хүүхэд гаргах жам ёсны эрхээ хүртэл эдэлж чадахгүй баян хоосны ялгаан дунд амьдарч байна" гэж гомдоллов.

Нялх үрс ба ханиад биш ханиад

Саяхан хэвлэл мэдээллийн хэрэгслээр өндгөвчний хавдраас болоод ой долоохон сартай охины хөх ургаж, сарын тэмдэг нь үзэгдсэн. Хоёр нас хүрээгүй бяцхан хүүд шилжилтийн насны хүүхдийн шинж тэмдэг илэрсэн гээд аймшигт мэдээлэл цацагдсан. Энэ талаар холбогдох хүмүүсээс тодруулахад өвчтөний хувийн нууц учраас хэлж болохгүй гээд халгаасангүй. Ямартай ч эдгээр өвчлөлд орчны тэр дундаа агаарын бохирдол онцгой нөлөө үзүүлсэн гэдэгтэй эмч нар санал нэгтэй байсан юм.

Ээжүүд хүүхдээ тэврээд эмнэлгийн чимээгүй орчинд урт дараалалд зогсох ажээ. Тэд энэ мэт дугаарлан зогсох нь жирийн үзэгдэл. Анагаах ухааны доктор, профессор "Харшлалт" харшил судлалын эмнэлгийн ерөнхий эмч Ж.Соёл-Эрдэнэ ачаалал багатай үед өдөртөө 20-30 хүн үздэг. Тэдний ихэнх нь бага насны хүүхэд байдаг бөгөөд амьсгалын замын өвчин туссан байдаг байна.

Тэрбээр "Гурваас дөрвөн сартай бага насны хүүхдүүд амьсгалын замын цочмог үрэвсэл тусах нь элбэг. Энэ нь утаатай шууд холбоотой. Бага насны хүүхдийн дархлаа үл мэдэг сулрахад л утаанд агуулагдаж байдаг хортой бодис амьсгалын замаар биед шингэж, эсэргүүцэл суларсан эс дээр очиж өрөвслүүлдэг. Нян, вирусын гаралтай бидний мэддэг "ханиад" биш. Үүнийг мэдэхгүй эцэг, эхчүүд антибиотек уулгадаг. Энэ нь өөр гаралтай амьсгалын замын өвчин учраас улам даамжирч тухайн өрөвсөл өөрчлөлтөд ороход нөлөөлнө. Антибиотек гэдэг чинь нэг ёсны нян шүү дээ.

Ямар нэгэн өөр бодис, нян зэрэгтэй нэгдвэл үхэлд ч хүргэх аюултай. Эм ч гэсэн хор болж болно. Өнөөдөр манай эмнэлэгт ирж байгаа хүүхдүүд ихэнхдээ антибиотек хэрэглэчихсэн байдаг. Тэгэхээр эмчлэгдэх явц улам л удааширна гэсэн үг. Мөн хэчнээн сайн эмчиллээ ч гадна орчны нөлөөгөөр амьсгалын замын ямар нэгэн өвчин дахиад л тусчихдаг. Энэ нь ирээдүйд хүүхдийн дархлааг сулруулж, бие султай болгодог" гэсэн юм. ■



Эрүүл мэндийн сайдын хаягаар

Хүнийхээ эрүүл мэндэд анхааараачээ

Б.Санжааханд

Хэдийгээр өнөөдөр утаа гамшгийн хэмжээнд хүрсэн гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярьж, бичиж, дарга нар ажил төлөвлөж түүндээ мөнгө төсөвлөж байгаа ч хүний тэр дундаа хүүхдийн амь насанд аюул учруулж байгаа гэдгийг анхаарч байгаа нь хэд билээ. Эмч нар "Бид модон чагнуур бариад л бүх өвчнийг анагааж чадахгүй. Гэтэл утаатай холбоотой өвчлөлүүд гаарсаар байна. Эцэст нь өвчнийг эмчилж чадсангүй гээд эмч нарыг л зэмлэдэг. Гэхдээ өнөөдөр энэ талаар судалдаг нь байтугай, санаа тавьдаг нь ховор байна шүү дээ" хэмээн учирлаж байна.

Үнэхээр өнөөдөр манайд агаарын бохирдол хүний эрүүл мэндэд ингэж нөлөөлж байна гэсэн тодорхой судалгаа, тоо баримт цаасан дээр нэгтгэж гаргасан юм огт алга. Тиймээс бид бодит байдал ямар байгааг эмнэлгүүдээр явж эмч, жирэмсэн эмэгтэйчүүдтэй уулзаж сурвалжиллаа. Эхчүүд хүүхэд олсон цагаасаа төрөн төртлөө байнга эмчийн хяналтад байдаг учраас төрөх эмнэлгийн эмч нар агаараас болж гарч буй эх, үрийн хүндрэлийн талаар ийн барин тавин ярих юмтай сууна. Гэтэл монголчууд улаан хоолой, элэгний хорт хавдраар сүүлийн хэдхэн жилийн дотор дэлхийд тэргүүлэх байр суурин дээр цойлон гарч ирсэн тухай Дэлхийн хавдар судлалын олон улсын сангаас гаргасан судалгаа бийг дуулгахад агаарын бохирдол монгол хүний эрүүл мэндэд аюулын харанга хэдийнэ дэлдсэн нь тодорхой харагдах биз ээ. Энэ тухай Та манай "Хоол олдоно, ходоод олдохгүй" гэсэн гарчигтай нийтлэлээс уншиж сонирхоорой. Гэтэл холбогдох эмч мэргэжлтнүүд, Эрүүл мэндийн яам, судалгааны байгууллагууд дуугүй дүмбийж суугааг юу гэж ойлгох вэ.


Төр, засгаас агаарын бохирдол утаатай тэмцэхээр 30, 40, 100 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тавьж, ажил хийхээр зүтгэж байна. Өнгөрсөн хугацаанд утаат бууруулахаар авсан арга хэмжээнүүдийн жагсаалтыг ажиглахад бүрэн шаталтат зуух, гэрийн дулаалга, цонх, нам даралтат зуух, цахилгаан болон хийн халаагуур... гээд хөнгөлөлттэй үнээр өгсөн зүйлсийн жагсаалт үргэлжилнэ. Гэтэл эрүүл мэндийн салбарт утааны эсрэг оруулсан тусламж, хөрөнгө оруулалт байна уу. Огтхон ч байхгүй. Энэ бол эрүүл мэндийн сайдаасаа эхлээд салбарынхан тун муу ажилласан гэсэн үг. Өөрөөр хэлбэл, тэд

http://www.mongolianeconomy.mn

Улаанбаатар хотын агаарын бохирдол иргэдийн эрүүл мэндэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд, нярай, нялх хүүхдүүдэд ингэж заналхийлж байна гэсэн бодитой тоо баримт, судалгааг шийдвэр гаргаж, бодлого тодорхойлогчдын чихэнд дорвитой хүргээгүй асуудлын гадна орхигдуулжээ.

Агаарын бохирдлыг бууруулахад эрүүл мэндийн салбар хариуцсан хүмүүсийн зүгээс оруулах хувь нэмэр маш их. Мянганы сорилтын сангийн санхүүжилттэй "Цэвэр агаар" төсөл гээд утааны эсрэг багагүй зүйлийг хийхээр төлөвлөж суугаа том төсөл бий. Тэдний санхүүжүүлж хийх ажлын жагсаалтад хүүхэд, жирэмсэн эхчүүдэд хандсан зүйл бий юү. Уг нь бол утаатай бүрэн шаталттай зуух, гэрийн дулаалга тарааж тэмцэхийн сацуу хүний эрүүл мэндэд шууд хандсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлээсэй. Тухайлбал, жирэмсэн эхчүүдэд шаардлагатай эм, амин дэмийг нь бүрэн биш юмаа гэхэд тал хагасых нь үнийг төрөөс даадаг байвал ямар вэ. Хүний хөгжлийн сангийн 21000 төгрөг үнийн хөөстэй өнөөдрийн нийгэмд аманд ч үгүй хамарт ч үгүй зүйл болж буй. Ялангуяа нийгэмд ахиу жин дарах дунджаас доогуур амьдралтай иргэдийн хувьд. Тэдэнд хордлого тайлах сүү, зориулалтын амны хаалт өгч тусалж яагаад болохгүй гэж. Монголын ирээдүй хойчийг төрүүлж, хүнс нэмэх гэж байгаа хүмүүс шүү дээ.

Хүүхэд багачуудад ялангуяа дөнгөж төрсөн нярайгаас эхлээд хоёр ой хүртэлх насны бяцхан үрэст хүчилтөрөгч, ууралт, амин дэм өгөх хөтөлбөр хүртэл хэрэгтэй байна шүү дээ. Эмч, судлаачдад утаа хүний эрүүл мэндэд ямар аюул заналхийлэл учруулж байна вэ гэдгийг судалж гаргаад, утаанаас эрүүл мэндээ хэрхэн хамгаалах тэмцэх талаар бодлого зөвлөмж боловсруулахыг шаардаач ээ, төр, засгийнхан. Агаарын бохирдлын эсрэг арга хэмжээнийхээ нэг хэсгийг хүндээ чиглүүлбэл яасан юм бэ? ■




Парламентын хаягаар

Уучлаарай, Улаанбаатарыг

Б.Энхмарт

Цэвэр агаар төслийн зарим асуудлыг хэлэлцсэн Засгийн газрын саяхны өргөтгөсөн хуралдааны үеэр БСШУ-ы сайд Ё.Отгонбаяр "Жилдээ дунджаар нийслэлд 40-өөд мянган хүн шилжин ирдэг гэсэн тооцоо байдаг. Агаарын бохирдолтой тэмцэх ажлын хүрээнд цаашдаа шилжилт хөдөлгөөнд ямар бодлого барих вэ. Энэ чигээрээ ирснийг нь хүлээж аваад байх юм уу" хэмээн Нийслэлийн Засаг даргаас асуув. Г.Мөнхбаяр "Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсдийг хотод хүлээж авахыг хориглох цаг нь үнэхээр болчихоод байгаа. Би мэддэгсэн бол бүрмөсөн хориглочихмоор л байна. Одоо цаг нь болсон. Гэвч энэ нь УИХ-аар шийдэгддэг асуудал. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг УИХ-аар хэлэлцэж шийдэх байх" гэж товч тодорхой хариулав. Урин цаг ирж нүүгэлтсэн утаа замхрахаас өмнө агаарын бохирдолтой холбоотой асуудлуудыг тал бүрээс нь цогцоор нь хөндөж буй манай сэтгүүлийн хувьд Ё.Отгонбаяр сайдын асуулт, Г. Мөнхбаяр даргын хариултын аль аль нь тун дажгүй санагдлаа. Төр, засгийн зүгээс нэгэнт агаарын бохирдолтой дорвитой тэмцэхээр шийдэж, ихээхэн хөрөнгө мөнгө төсөвлөж, багагүй зүйл хийж байгаа учраас нийслэлийг чиглэсэн их нүүдлийг зогсоох чиглэлд төрийн төмөр нүүрийг үзүүлэх хэрэгтэй тухай "Mongolian Economy" сэтгүүл энэ сэдвээрээ түлхүү хөндөж байна.

Гэр хорооллын яндангийн тоог цөөлөхгүйгээр утаатай тэмцээд нэмэргүйг өнгөрсөн жилүүдийн туршлага ойлгуулсан. Дөрвөн уулыг даван алсрах нийслэлийн гэр хорооллын зах хязгаар нь "үл үзэгдэх" аж. Агаарын бохирдлыг бууруулах хамгийн шилдэг арга орон сууцжуулах боловч энэ ажил нь эцсийн үр дүн сайн байхтайгаа адил цаг хугацаа, хөрөнгө мөнгө ихээр шаардах зүйл. Ойрын дөрөв, таван жилдээ битгий хэл, 40, 50 жилээр үргэлжилж, үр дүнг нь хүлээх асуудал. Тийм болохоор Мөнхбаяр даргын хэлсэнчлэн ядаж гэр хорооллын өрхийнхөө тоог ■



http://www.mongolianeconomy.mn

одоогийн түвшинд нь хязгаарлах үүднээс энэ цаг мөчөөс эхлээд гэр хорооллын яндангийн тоог нэммээргүй байна. Тэгэхийн тулд Хотын мээрийн хэлсэн Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг даруй хэлэлцэж батлах асуудлыг шийдэхэд анхааралтай гэдэг үүндээс энэ нийтлэлээ Парламентад хаяглалаа. Утааны гол буруутан болох гэр хорооллыг тэлэхгүй, тогтоон барих чиглэлд зоригтой алхам хийх асуудал Улаанбаатар хотын Захирагч биш, УИХ-ын гишүүдийн мэдэх хэрэг гэсэн. Нэгэнт л агаарын бохирдолтой тэмцэхээр шийдсэн учраас зарим шаардлагатай асуудалд төрийн төмөр нүүрийг үзүүлж яагаад болохгүй гэж.

Хоёр жилийн өмнө Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийг чиглэсэн их нүүдлийг сааруулах, хэт төвлөрлийг багасгах болон бусад шаардлагатай зүйлийг багтаасан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байдаг ч одоо болтол таг чиг. Бүтэн хоёр жил хэлэлцээгүй төслийг эрхэм гишүүд хэзээ таалалдаа болгоохыг бид таашгүй. Түүнийг нь хүлээж суух хугацаа үнэндээ алга.

Татвар

Та нийслэлд оршин суух баян хүн мөн үү

Ийм асуултыг нийслэлд оршин суухаар шилжин ирэгсдэд тавьж байвал ямар вэ?

29027. Энэ бол зөвхөн өнгөрсөн онд орон нутгаас нийслэлд бүл нэмсэн иргэдийн албан ёсны тоо. Үүний цаана бүртгэлд хамрагдаагүй хэчнээн иргэн нийслэлд хөлсний өрөө түрээсэлж, айлын хашаанд гэр барьж, оюутны болон нийтийн байранд амьдарч буйг тооцоолох боломжгүй. Нийслэлд албан ёсны бүртгэлтэй нэг сая 270 гаруй мянган иргэн амьдардаг байна. Үүн дээр бүртгэлгүй иргэдээ нэмбэл 1.5 сая руу дөхөх нь. Мөн энэ онд нүүж ирэх, дараа жил, дараагийн тав, зургаан жилд их хотыг зоригсдыг нэмбэл ойрын 10 жилдээ Улаанбаатар хотын хүн амын тоо даруй 2.7 сая болох нь ээ.

Нийслэлд шилжин ирэгсдэд өндөр татвар тогтооё. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга О.Машбат Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд нийслэлийг таван бүсэд хуваж, бүс тус бүр зэргээсээ хамаарч, өөр татвартай байхаар тооцоолсон тухай ярьж байсан. Мэдээж А зэрэглэлийн бүсэд амьдрах хүсэлтэй иргэд, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж байгууллага хамгийн өндөр татвар төлдөг байх нь зах зээлийн өрсөлдөөн төдийгүй, хэт төвлөрөлийг сааруулах эдийн засгийн хөшүүргээс чухал юм.

Япон, Лондон, БНСУ гэх мэт дэлхийн хөгжилтэй цөөнгүй орон энэ аргаар агаарын бохирдол болон хүн амын төвлөрөлтэйгээ тэмцэж, асуудлаа шийдэж чадсан байдаг. Манайх ч энэ аргыг 2001-2003 онд хэрэгжүүлэхийг оролдсон удаатай. Энэ талаар Нийслэлийн бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр “2001-2003 онд хэрэгжүүлсэн нийслэлд шилжин ирэгсдээс авч байсан татварын арга хэмжээ үр дүнтэй байсан. Тухайлбал, 2002, 2003 онд орон нутгаас нийслэлд ирэгсдийн тоо 15 мянга байсан бол татвар авахаа больсон тухайн жилд гэхэд л 75 мянга гаруй болж суга өссөн байх жишээтэй. Татвартай байх нь хэт төвлөрөлийг сааруулахад чухал нөлөө үзүүлдгийг харуулсан” гэж ярьсан.

Тиймээс энэ нь төр, засгаас олон ажил хийж, хөрөнгө хүч, арга чарга нь дутаж хүчин мөхөстөж байгаа агаарын бохирдлыг бууруулахад том түлхэц, эдийн засгийн хөшүүрэг болох чухал арга хэмжээ болох юм. Нэн даруй бүр маргаашнаас эхлэн хэрэгжүүлэх ажил биш гэж үү. Та улсынхаа нийслэлд амьдарч байна шүү, агаар, хөрс, ус бохирдуулах ёсгүй гэдгийг нь мэдрүүлж, хотын иргэний үүрэг хариуцлагыг бага ч болтугай нь ухамсарлуулах хэрэг болов уу. Үүнд шаардлагатай хууль, журам, тогтоол захирамжийг цаг алдалгүй боловсруулаач, дарга нар аа. Хөдөөнөөс хотыг зорин ирж буй цөөн хүний төлөө бус нийслэлчүүдийн эрүүл мэнд, ая тухтай амьдрах орчин, амьд явах эрхийн төлөө хийх эрс шинэчлэл, санаачилга болохоор буруутгах хүн гарахгүй гэдэгт итгэлтэй байна.

Утаат хот руу бүү яар

Уучлаарай, Улаанбаатарт шилжин ирэх тухай бодлоо орон нутгийн иргэн Та яг одоо орхи. Шилжин ирэгсдийг хязгаарлах саналыг хэн нэгнийг илүү үзсэндээ хүсэж буй явдал биш юм. Учир нь, хүн амын хэт төвлөрлөөс үүдэлтэй орчны, хөрсний, агаарын бохирдол нийслэлийн иргэдийг амьсгалах аргагүй болтол хоолой боон бачуурууллж, нүд хорсгож байна. Аймшигт өвчин эмгэгүүдийг дагуулж байна. Мөн утаанаас болоод эмэгтэйчүүд ээж болох жам ёсны эрхээ ч эдэлж чадахгүй сэтгэлийн зовлонтой алхана. Түүнчлэн ургийн гаж хөгжил 2000 онд 100 ураг тутамд 2.3 байсан бол 2010 онд 12.7 хувь болж нэмэгджээ. Дөнгөж төрсөн нярай нэг, хоёрхон хоноод утаат агаараас болж эмнэлэгт хүргэгдэж байна. Нийслэлийн иргэдийн эрүүл мэндэд учирсан энэ их айдас хүүдэс, аюул заналхийллийг арилгахын төлөө шилжин ирэгсдийг Улаанбаатарт уруул дэвсэн хүлээж авдгаа болъё.

Агаарын бохирдлын асуудал хүн төрөлхтний түүхэнд шинэ зүйл биш. Дэлхийн томоохон хотуудын тойрч биш, дайрч гарсан асуудал учраас бид бусдын хэрхэн амжилттай даван туулсан бэ гэдэг асуудлыг анхааралтай авч үзэх ёстой. Өнөөдөр утаа гэдгийг мэдэхгүй цэвэр агаар цээж дүүрэн амьсгалж суугаа зарим хотын хувьд хэдэн мянган, зуун жилийн өмнө манайх шиг зовлонтой нүүр тулж, тэмцэж байсан юм билээ. Тэгэхдээ нийслэлд шилжин ирэхийг хүсэгчдийг хүлээн авахыг хэсэг хугацаанд хориглож, өндөр татвар ногдуулах зэрэг байдлаар хатуухан тэмцэл хийж байсан тухай сонин хэвлэлд бичсэн байдаг. Мэдээж ийм шийдвэр гаргасан тохиолдолд иргэд “Үндсэн хуулиар..... монгол хүн эх орныхоо газар нутгийн хаана нь ч шилжин суурьшиж амьдрах эрхтэй...” хэмээн бухимдана. Гэхдээ нэг хэсэг хүний амьдралын төлөө биш, нийслэлийн нийт иргэний болоод ирээдүй хойч үеийнхээ эрүүл, ая тухтай амьдрах эрхийн төлөө хийж байгаа төр, засгийн зангарагтай шийдвэр байх учраас шилжин ирэх гэж байгаа болон хотынхон хүлээн зөвшөөрч, эвлэрч л тараа. Ямар бүр тэр чигээр нь хотод шилжин ирэгсдийг хүлээж авахаа болих гэж байгаа юм биш, асуудлыг шийдвэрлэж, мэдэгдэхүйц үр дүн гартал

тодорхой хугацаанд хориглох боломжтой биш гэж үү. Багадаа тав, 10, 15 жилийн дараа харин Та цэвэр агаартай нийслэлд шилжин ирж суурьшвал ая тухтай амьдрах эрхээ эдлэх ёстой бус уу. Гэр хорооллын яндангийн болон хэрэн сүлжилдэх автомашины угаар толгой эргүүлж, дотор муухайруулсан утаат Улаанбаатар руу ирэх гэж энэ цаг мөчөөс бүү яараарай. Харин тэрний оронд бохир агаарт хордсон хотод амьдарч, ажилладаг үр хүүхэд, ах, дүү хамаатан саднаа өөрийн буй цэвэр цэнгэг агаарт нутагтаа урин дуудаж, гүн хордлогыг нь тайлж өгч туслахаа бод.

Тийм болохоор Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг яаралтай баталснаар Хотын мээр маань “Уучлаарай, манай Улаанбаатар хэсэг хугацаанд шилжин ирэгсдийг авахгүй байгаа шүү дээ. Бид бохир хортой агаараа бага ч болтугай нь цэвэршүүлэхийн тулд тэр шүү” гэсэн шиг ээ шалтгаан нь тодорхой эелдэгхэн хариулт хэлээд сууж байвал хаана хаанаа л зүгээр зүйл болох учиртай даг аа. ■



http://www.mongolianeconomy.mn

Агаарын бохирдол

Нүдэнд бус багажинд л мэдрэгдэнэ

Х.Ананд

Нийслэлийн агаарын бохирдол багассан гэв үү? Ерөнхийлөгчийн санаачилсан Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо болон холбогдох ажлын хэсгийнхэн утааг багасгахаар ажиллаж байгаа нь үнэн. Гэхдээ тэдний зарим нь “Нийслэлийн агаарын бохирдол өмнөх оны мөн үеийнхээс 30 гаруй хувиар багаслаа. Үүнийг та бүхэн хараад мэдрэх боломжгүй. Учир нь, зөвхөн агаарын бохирдлыг хэмждэг багажинд л мэдрэгдэнэ” хэмээн зурагт, радиогоор ярьж, сэтгүүлчдэд мэдээлэл хийсэн. Энэ үнэн гэж үү?

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны мэргэжилтэн Г.Баттүвшинтэй уулзлаа. Түүнээс дээрхийн адил тайлан сонсоод, “Тэгвэл яагаад өмнөх жилүүд шигээ утаан хөшиг татсаар байгаа юм бэ?” гэхэд “Бид агаарын бохирдлыг бууруулахаар шат дараатай арга хэмжээ авч байна. Үүний нэг нь хязгаарлалтын бүс тогтоосон явдал. Тогтоосон бүсүүдийн иргэдэд бүрэн шаталттай зуух, гэрийн дулаалга, гонх, коксжсон түлш зэргийг хөнгөлөлттэй үнээр өгсөн. Тус газруудад бохирдол хэрхэн буурч байгааг утааны байнгын харуул хэмжилт хийж гаргадаг. Өдөр бүрийн хэмжилтийн дүнг өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулан нэгдсэн дүнгээ гаргасан. Тэр дүнгээр хязгаарлалтын бүсүүдийн бохирдол 30 гаруй хувиар буурсан нь тогтоогдсон. Утаа багассан нь илт мэдрэгдэхгүй байгаа шалтгаан нь хязгаарлалтын бус бүсүүдийн утаа хязгаарлалтын бүсийн утаатай агаараар нийлж, улмаар нүдэнд харагдахгүй байгаа юм” гэж тайлбарлалаа.

Төр, засгаас сүүлийн нэг жил гаруйн хугацаанд утаатай тэмцэх ажлаа хэрэндээ л эрчимжүүлж, бохирдлыг бууруулахын тулд хууль дүрэм баталж, ажиллаж байгаа болохоор мэргэжилтнүүдийн ингэж ярих нь зөв. Гэхдээ дээрх тайлбарыг уншсан хэн бүхний хөх инээд хүрэхээр байгаа биз дээ. Агаарын бохирдол зөвхөн багажинд мэдрэгдэх хэмжээнд буурсан бол иргэдийн бухимдах нь аргагүй л юм. Хязгаарлалтын бус бүсийн утаа хязгаарлалтын бүсийнхтэй нийлэхгүй гээд ч яах билээ. Хэчнээн мөнгө хөрөнгө байгаад агаарт хязгаар тогтоож болохгүй юм даа. Тайлбар өгсөн мэргэжилтнийг буруутгах гэсэнгүй. Зүгээр л агаарын бохирдлыг бууруулах гээд тал бүрээс хичээн зүтгэж буй ч манайхны тэмцэж байгаа арга нь хэр зөв юм болдоо. Нэг үгээр хэлбэл, агаарын бохирдолтой үр дүнтэй тэмцэх туршлага, төрийн нэгдсэн бодлого дутагдах шиг. Хөнгөлөлттэй үнээр бүрэн шаталтат зуух, дулаалга, үүдний гонх зэргийг хязгаарын бүс тогтоож хэчнээнийг ч өгөөд нүдэнд харагдаж, гарт баригдахаар үр дүн гарахгүй байгаа тул өөрөөр ямар байдлаар хийж хэрэгжүүлэх вэ гэдэг дээрээ илүү төвлөрч бодох хэрэгтэй болов уу. Нийслэлийн зургаан дүүргийн 180 гаруй мянган өрхөд утаа бага гаргах төрөл бүрийн дэмжлэг үзүүлэхдээ хязгаарлалт тогтоох нь үр дүн хүлээх хөдөлшгүй суурь мөн үү. Хэчнээн хөрөнгө мөнгө байгаад агаарт хил хязгаар тогтоож болохгүй учраас бодит үр дүнг баллаад байгаа юм биш үү. ■

Бичил статистик

Тараасан уу, тараасан

Нийслэлийн агаарын чанарын албаны мэдээллээс бичил статистик хүргэе. 2011-2012 онд нийслэлийн гэр хорооллын иргэдийн түлэх байсан түүхий нүүрсний хэрэглээг зарим хэсэгт хязгаарлалтад /6500 өрх/-ийг хамруулжээ. Бүрэн шаталтат зуух (57128 өрх), гэрийн дулаалга (9411), гонх (1854 өрх), нам даралтат зуух (39 өрх), цахилгаан болон хийн халаагуур (614 өрх)-д хямдралтай үнээр өгчээ.

Үр дүн юу байсан бэ гэдэг дээр албаныхны хэлснээр гэр хорооллолд түлэх байсан 117892 тн түүхий нүүрсний хэрэглээг 16.5 хувиар бууруулсан. Энэ нь нүүрс шаталтаас агаарт хаягдах байсан 67.5 тн нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/, 725 тн хүхэрлэг хий /SO2/, 3018.04 тн үнс зэрэг нийт 3810.5 тн хорт бодисыг агаарт цацаагүй гэсэн үг. Тиймээс агаарын бохирдол тодорхой хэмжээгээр буурсан гэж үзэх үндэслэлтэй гэжээ.

http://www.mongolianeconomy.mn

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт

Та утааг бууруулах ямар санал санаачилга гаргах вэ?



Г.Баярсайхан/УИХ-ын гишүүн/:

Жилийн дөрвөн улирлын турш агаарын бохирдолтой байдаг боллоо. Орон сууцжуулах хөтөлбөрийг 100 мянган айлынхаар тогтохгүй гэр хорооллыг 100 хувь орон сууцжуулах хэрэгтэй. Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийг хийх нь оновчтой. Утаагүй зуух, утаагүй түлш бол цаг зуурын ажил. Цаана нь утаа гаргах, ахуйн болон нийгмийн үндсэн нөхцөл хэвээр байна шүү дээ. Гэр хороолол байж л байна. Хязгаарлалтын бүс бол хязгаарлагдмал орон зай. Байгаль орчинд тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх. Экологийн тасалбар бий болгох, сан, урамшуулал, засаглал, стандарт энэ тавыг хэрэгжүүлсэн тохиолдолд Улаанбаатар дэлхийн экологийн цэвэр хот болно.



Н.Батсуурь/БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга/:

Хагас коксжсон нүүрсийг модны үртэстэй хольж хийсэн боловсруулах түлшний асуудлыг 2016 он гэхэд шийдэх дунд хугацааны төлөвлөлт бий. Улаанбаатар хотын гэр хорооллын бүх өрхийг ийм түлшээр хангахын тулд 500 мянган тонн шаардлагатай гэсэн тооцоо гарсан. ТЭЦ –II-ийн боловсруулсан түлш хийх зориулалттай үйлдвэр бүрэн ашиглалтад орвол нийт хэрэгцээний бараг тал хувийг нь буюу 240 мянган тонныг үйлдвэрлэх боломжтой гэсэн тооцоо гарсан. Ирэх зургадугаар сард хоёр зуухны эхнийх нь ашиглалтад орохоор байгаа. Энэ нь 220 орчим мянган тонн боловсруулсан түлш гаргана. Ингэхээр манайд боловсруулсан түлш үйлдвэрлэх хангалттай хүчин чадалгүй гэдэг нь харагдаж байна.



Р.Содхүү /Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга/:

Бодит олон бэрхшээлүүд байгаа учраас утааны асуудлыг олон талаас бодож үзэх хэрэгтэй. Нийслэлийн агаар, хөрс, усны бохирдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоож чадаагүй байна. Сургаар л хортой гэсэн оношийг бид өөрсдөө тавьсан. Ус, агаар, хөрс нь хүн эрүүл орших орчин. Энэ гурван орчны эрүүл мэндийг тогтоох шаардлагатай. Улаанбаатарт дэгдэж байгаа утаа дөрвөн уулынхаа нөмөрт агаар мандал дээр тогтож байна. Утаа гаргадаг зуух, яндангаасаа салахын тулд шинэ хороолол байгуулах тухай хэлэлцэж байсан. Тиймээс цоо шинэ газар орон сууц бариад, тэнд эмнэлэг, сургууль бариад, дэд бүтцийг хотоос дутахгүй хөгжүүлэх хэрэгтэй.



Д.Зоригт /УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгийн хорооны дарга/:

Улаанбаатарын агаарын бохирдолд хамгийн их нөлөө үзүүлж байгаа нь гэр хорооллын 200 мянга орчим айлуудын асуудал юм. Тиймээс бүрэн шаталттай зуухыг гэр хороололд хэсэгчилж биш,бүгдэд нь өгөх хэрэгтэй. Нөгөө талаас нам даралтын зуухыг шинэчилж, бүрэн шаталттай болгох шаардлагатай байна. Түүнчлэн аль болох түүхий нүүрс биш боловсруулж, коксжуулсныг нь түлэх нь зүйтэй. Цаашдаа гэр хорооллыг дэд бүтэцтэй болгон, амины болон хувийн жижиг орон сууцуудыг барих нь эдийн засгийн хувьд ч эрүүл мэндийн хувьд ч ихээхэн тохиромжтой арга юм.



Г.Цогт-гэрэл/СХД-ийн VI хорооны иргэн/

-Манайх утаагүй зуухтай болж амжаагүй л байна. Хүмүүсийн ярьж байгаагаар гал түлэхэд төвөгтэй гэж байсан. Манай гэр ханын материалд байдаг. Утаа энэ жил өмнөх жилүүдээс ч их байх шиг л санагадах юм байна шүү дээ. Орон сууцэжжлах хөтөлбөрөө олигтойхон хийсээр байна, төр. Ярихаас цааш хэтрэхгүй байна шүү дээ. Тэр утаагүй зуухаа бүс тогтоож хязгаарлахгүйгээр нийслэлчүүдэд худалдан борлуулж болдоггүй юм болов уу.



Жон Вийдон/”Оюутолгой” ХХК-ийн Эрсдэлийн менежер/:

Аливаа асуудлыг нэг суурин дээр нь шийднэ гэдэг бараг боломжгүй. Боломжтой юм аа гэхэд маш их мөнгө шаардана. Ахиц дэвшил авчирч болох сонголтуудыг жагсааж тэдгээрт үнэлэлт өгөх замаар сонголт хийж, хамгийн үр дүнтэй хэсэгт төвлөрөх нь бохирдлыг бууруулах үр дүнтэй арга. Мөнгийг илүү боловсронгуй, алсыг харсан хийгээд эрсдэлийг тооцсон загварчлалд тулгуурлаж зарцуулах хэрэгтэй санагддаг. Ингэснээр ирээдүйд гарах байсан зарлага орлого болон хувирах учиртай.

http://www.mongolianeconomy.mn

Төсөл

Нэг толгойд зуун жанжин




Шог зургийг А.Амарсайхан

Нийслэлийн утааг багасгах ажил нь төр, засгийн байгууллагуудын хаана нь төвлөрч, зангидагдаж байгааг мэдэхэд тун бэрхтэй байна гэдэг яриа иргэдийн дунд гарч байна. “Агаарын бохирдлын хэдэн ч төсөл хөтөлбөр байгаа юм бэ дээ, хүү минь. Зураг, радиогоор сонсоход их л юм хийгээд байгаа бололтой байх юм. Миний охин сонин хэвлэлд ажилладаг хүн мэдэж байгаа байлгүй. Утаа тэгээд багасаж байгаа юм болов уу” хэмээн өндөр настай өвөөгийн маань надаас шалгааж байсан нь энэ мөчид санаанд зурсхийлээ. Тухайн үедээ нэг их тодорхой хариулт өгөөгүй өнгөрсөн юм байна. Хөгшин битгий хэл, ажил албатай залуучууд нь нээрээ сүүлийн үед агаарын бохирдлыг бууруулах талаар ярьж байгаа хөл толгойгүй мэдээллээс шүүн тунгааж, шүүрдэж авахад амаргүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч энэ чиглэлийн холбогдох мэдээллийг олдсоных нь зоргоор хамаа замбараагүй хүргэж, уншигч, үзэгчдийн толгойг эргүүтүүлж байгаа нь харагдаж буй. Яам болгон хажуудаа агаарын бохирдол бууруулах ажлын хэсэгтэй, хүн бүхэн утаатай холбоотой тайлан гаргаж, цээжээ дэлдээд байхаар арга ч үгүй биз. Тэгвэл үнэндээ агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр тодорхой зүйл хийж байгаа төсөл хөтөлбөр гэвэл АНУ-ын “Мянганы сорилтын сан”-гийн “Цэвэр агаар”, Японы ЖАЙКА олон улсын хамтын байгууллагын “Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх” гэсэн хоёр төсөл л буй юм.

Монголын талаас гэвэл холбогдох албаныхныг эс тооцвол утаатай тэмцэх 100 хувийн дотоодын санхүүжилттэй төсөл одоогоор байхгүй байгаа. Утаагүй түлш хэмээх коксон болон брикетэн түлш бэлтгэн нийлүүлдэг хэдэн аж ахуйн нэгжид дээрээс үүрэг даалгавар өгч байх шиг байна. Гэхдээ 11000 гаруй өрхийг өнгөрсөн өвөл утаагүй түлшээр хангах байсан ч тэд үүргээ биелүүлж чадаагүй билээ. Харин Ажлын хэсгийн хувьд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны гишүүд өөрсдийн салбар бүрт төлөвлөгөөний дагуу ажлаа үргэлжлүүлж буй аж. Түүнээс биш, агаарын бохирдлын эсрэг тоо толгойгоо алдтал олуулаа зүтгээд байгаа хэрэг биш ажээ.

Гэхдээ зөвхөн өнгөрсөн онд үртсэн болон шахмал түлш үйлдвэрлэхэд 3.1 тэрбум, цахилгаан халаагуурт 1.6 тэрбум, цахилгаан халаагуур хэрэглэх болон хуулийн нөхцөл шаардлагыг хангасан айл өрхөд өгөх хөнгөлөлтөд 4.5 тэрбум, түлш худалдаалах цэг байгуулах, мэдээлэл сурталчилгаа, тээврийн хэрэгслийн бохирдлыг бууруулахад 7.6 тэрбум, гэрийн дулаалгад 8.4 тэрбум, гэрийн зууханд 8.8 тэрбум гээд нийт 34 тэрбум төгрөгийг утаанд зарцуулсан байдаг. Энэ онд дээрх тоог бараг гурав дахин нэмэгдүүлж, “Нийслэлийн утааг 50 хувь бууруулна” гэсэн амлалттайгаар 105.5 тэрбум төгрөг төсөвлүүлж, 64.8 тэрбумаар нь санхүүжихээр болоод авсан.

Утаанд зарцуулсан төсөв /тэрбум төгрөгөөр/



Томчуудын гаргасан том төсөв ч маньд юуны хамаа байх вэ. Хамгийн чухал нь хэдэн арван сургууль, цэцэрлэг барих, хэчнээн зуун айлыг орон сууцжуулахад хүрэхүйц энэ их мөнгөний үр дүн багажинд бус нүдэнд харагдаж, биед мэдрэгдэх л хэрэгтэй байна.

Гаднын хөрөнгө оруулалттай төсвийн хүрээнд хийгдэх ажлыг өөрийн байгууллага болоод өөрсдөө хийсэн болж харагдах тоглолт явагдаж байгааг ч зарим эх сурвалжаас харагдаж байгаа. Сонгуулийн жил болоод ч тэр үү агаарын бохирдлын асуудал хэт идэвхжиж, бас улстөржиж байгаа нь нууц биш юм. Амтай бүхэн нь ярьж ёстой нөгөө нэг толгойд зуун жанжин болох шинжтэй байна.

http://www.mongolianeconomy.mn


Хөрсний бохирдол

Өвчинтэй Улаанбаатар

Б.Уганбаяр

Энхрийхэн үр тань хорвоод мэндлэх өдрөө хүлээн хэвлийд тань бойжино. Тэнд мэдээж дулаахан, тав тухтай, хамгийн сайхан эрүүл орчин бүрдсэн байгаа. Өдөр өдрөөр энэ орчлонд ирэх гэж тэмүүлэхдээ тэр хахаж, цацмаар бохир утаа, ус, хөрснөөс болж хүн төрөлхтөн үргэлж ямар нэг өвчнөөр өвддөг гэж төсөөлөөгүй нь лавтай. Цаашилбал хөршийнхөө эсвэл ээжийнхээ асгасан угаадас дээр мөлхөж, хог хөглөрсөн хашаа, гудамж тоглоомын талбайд тэнтэр тунтар гишгэлэн алхаж сурна гэдгийг ч мэдээгүй байгаа. Гэтэл эхийнхээ ариун хэвлийгээс цэврүү шиг цэвэрхэн төрсөн нялх үрс өвчинтэй Улаанбаатарт мэндлэнгүүтээ л тархины даралт, уушгины багтраа зэрэг өвчинтэй болж байгаа нь харамсалтай. Энд утааны тухай биш, харин хөрсний бохирдлын тухай өгүүлье.

Их хотын хүмүүс амьдрал, ажил төрөлдөө түүртээд хөрс бохирдож, эрүүл мэнд нь хохирсоор байгааг анзаарах сөхөөгүй өдөр хоног үргэлжилсээр. Хөрсний бохирдлын тухай мэргэжилтнүүдийн хэлж буй тодорхойлолтыг энгийнээр илэрхийлбэл, хүний үйл ажиллагааны улмаас хөрсөнд янз бүрийн органик болон органик биш бодис шингэж агууламж нь ургамал болон амьд организмд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд хүрч, хуримтлагдах явцыг хэлдэг аж.





Гандангийн дэнжийн гэр хороолол

Үерийн биш “бохирын” далан

Хөрсний бохирдлын тухай материал бичиж байгаа гэсэн чинь Зуун айлын гудамжинд өглөө угаадас асгаж, оройд үнс асгасаар угаадас-үнс-угаадас-үнс гэсэн зузаанаас зузаан үе давхарга үүсэж хүн байтугай машин явахад бэрх болсон тухай нэгэн танил маань сонирхуулав. Тэднийх Зуун айлын орчимд орон сууцанд амьдардаг ч гэр хорооллоор хүрээлэгдсэн их хөлийн газар гэнэ. Ийм дүр зургийг нийслэлийн гэр хорооллын хаанаас ч харсан болно. Үүнээс гадна хөрсний бохирдол үүсгэж буй нэг хүчин зүйл нь үерийн нэртэй бохирын далангууд. Олон нийтийн нүдэнд хамгийн ойр байдгаар нь Баянбүрдийн уулзвараас Гэсэр сүм хүртэл үргэлжилдэг үерийн даланг онцолъё. “Бөмбөгөр” захын эсрэг талаар 100 метр орчим газарт үргэлжлэх даланд тэр хавийн айлууд өдөр шөнө, өвөл зуныг ялгалгүй хог хаягдал, бохир усаа асгана. Олон жилийн хур хог, угаадас дулааны улиралд огиудас хүрэм эвгүй үнэр ялгаруулж, хөрснөөс гадна агаар бохирдуулна. Үерийн даланг үндсэн зориулалтаар нь яагаад ашиглахгүй байгааг БГД-ийн XVI хорооны Засаг дарга О.Цэндхорлоогоос асуухад “Гандангийн дэнжийн хөрс дагтаршсан цэвдэгтэй учир айлууд бохирын цооног, “00” ухах боломжгүй. Тиймээс үерийн далан руу бохир ус, зарим нь бохироо хийх нь ч бий. Дээр нь “Бөмбөгөр” худалдааны төвийн наймаачид хог хаягдлаа байнга асгадаг” хэмээв. Тэрбээр бохир, цэвэр усны шугаманд айл өрхүүдийг холбох нь хөрсний бохирдлыг бууруулах гарц гэдгийг онцолсон. Эмгэнэлтэй байгаа биз. Гандангийн хороолол нь хотын төвтэй хаяа нийлэн байрладаг учраас Улаанбаатар хотын нүүр царай болдог гэхэд хилсдэхгүй. Гэтэл энд хөрс цэвдэгтэй тул 00, муу усны нүх ухах боломжгүй гээд хэсэг хороогоо цэвэр цэмцгэр байлгахад айл өрхүүдийг шахаж, хариуцлага хүлээлгэх ёстой хорооны Засаг дарга нь хүртэл заваан байх хувь заяатайгаа эвлэрэн сууж таарах уу. Үнэхээр Гандангийн орчим бол нохойн хороо гэдэгтэй олон хүн санал нийлэх байх. Орон сууц, гэр хороололд амьдардаг олон мянган хүн хийморын сан тавиулж, хүрд эргүүлэхээр Гандантэгчилэн хийдийг зорьдог. Хийморио сэргээсэн иргэд Гандангийн гэр хорооллын бохир гудамжаар явна гэдэг үнэхээр хүнд. Засаг даргынх нь хэлж байгаагаар хөрс

Хүнд металлууд хүний биед ямар хор нөлөөтэй вэ?

Элементүүд	Элементүүдийн нөлөөллийн сөрөг үр дагавар	Эх үүсвэр
Мөнгөн ус /Ng/	Сэтгэхүйн хямрал /минаматын өвчин/, ходоод гэдэсний үйл ажиллагааны хямрал, бөөрний хямрал, хромосомын мутацид нөлөөлнө.	Бохирдсон хөрс, гадаргуугийн болон хөрсний ус
Мышяк /As/	Арьсны хорт хавдар, хордлого, захын мэдрэлийн үрэвсэл үүсгэнэ.	Бохирдсон хөрс, хордсон ур тариа
Хар тугалга /Fb/	Хүн ба амьтан ургамлын өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлдөг. Хэрэв хордсон тохиолдолд цус төлжих, мэдрэл оюун ухааныг дарангуйлах, бөөр, хоол боловсруулах эрхтний хэвийн үйл ажиллагаа хямарч, татах, саа тусах шинж тэмдэг илэрдэг байна.	Хөрс, гадаргуугийн болон хөрсөн доорх усны бохирдол
Зэс /Cu/	Эдийн органик өөрчлөлтүүд, ясны эдийн гэмтэл, элэгний үрэвсэл үүсгэнэ.	Хөрс, гадаргуугийн болон хөрсөн доорх усны бохирдол
Кадми /Cd/	Элэгний цироз, бөөрний үйл ажиллагааны дутагдал, протеинури үүсгэнэ.	Бохирдсон хөрс

http://www.mongolianeconomy.mn

нь цэвдэгтэй газар ухаж болдоггүй юм бол Гандангийн гэр хорооллыг нүүлгэн шилжүүлж болдогшүй юм уу гэж төр, засгийн холбогдох хүмүүсээс асуумаар байна.

Тос, тосолгооны материал эрүүл мэндийг дарангуйлдаг

"Да хүрээ", "Өгөөмөр" зэрэг төвлөрсөн авто захаас гадна "Дөлгөөн нуур"-аас Дэнжийн мянгын Цагаан байр, Таван шараас 22-ын товчоо чиглэлд байрласан авто сэлбэг, дугуй засвар, тос тосолгооны жижиг үйлчилгээний 600 орчим цэг бий. Эдгээр нь хөрсний бохирдлын өөр нэг том эх үүсвэр юм. Дээр нь хотын бага тойруугийн засмал замууд, Вагон депогийн засварын газар, зарим шатахуун нөөцлөх, түгээх станцууд ч орох аж. Учир нь, эдгээр газарт бензин, масло, тос зэргийг хөрсөнд их хэмжээгээр нэвчүүлэн, дагтаршуулж, хөрсийг үхжүүлэн хар тугалга болон бусад хорт бодисын хэмжээг ихэсгэдгийг судалгаагаар тогтоожээ. Ийнхүү ялгарсан хар тугалга хүний цус төлжилтийг саармагжуулж, мэдрэл оюун ухаанд нөлөөлж, бөөр, хоол боловсруулах эрхтний хэвийн үйл ажиллагааг хямраан, татах саажихад хүргэдэг байна. Мөн хөрс бохирдсоноор хүний эрүүл мэндэд ямар хөнөөлтэйг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал Н.Сайжаа "Хавар болохоор гэдэсний халдварт өвчин болох вируст гепатит, цусан суулгаар өвчлөгсдийн тоо эрс нэмэгддэг. Энэ нь хөрс, усны бохирдлоос шууд хамааралтай" гэв. Түүнчлэн хөрсний бохирдлоос үүдэж гэдэсний халдварт өвчин, балнад, цусан суулга, сүрьеэ, бурцеллез, халдварт шар, цагаан хорхой, боом, татран, амьсгалын замын өвчлөлүүд үүснэ. Амьдран буй орчныхоо хөрсийг бохирдлоос сэргийлэхгүй бол дээрх өвчлөлүүд танай хаалгыг тогшин буйг сануулъя.

Улаанбаатар хотын хөрсөнд хүнд металлууд ямар хэмжээтэй байна вэ?

Дээж авсан	Үзүүлэлт	Хар тугалга	Хром	Никель	Цайр	Кадми
Хөрс	Дундаж	47.3	71.3	9.9	194.9	0.88
	Хамгийн их	1512.5	1548.8	52.0	662.3	7.2
	Хамгийн бага	2.5	1.3	0.0	0.0	0.0
Гутлын шороо	Дундаж	46.8	138.6	10.1	75.6	0.37
	Хамгийн их	177.3	286.5	27.3	345.0	1.4
	Хамгийн бага	8.0	5.8	1.0	7.8	0.0
Тоос	Дундаж	254.2	76.1	76.1	253.9	1.29
	Хамгийн их	700.9	126.4	141.4	367.0	1.9
	Хамгийн бага	41.3	16.6	48.2	173.9	0.9
Голын ёроолын хурдас	Дундаж	40.2	35.3	4.9	177.8	0.25
	Хамгийн их	194.3	107.8	11.3	332.5	0.4
	Хамгийн бага	2.5	2.5	0.8	61.8	0.1
Дэвсгэр агууламж /Гачуурт, Хуандийн ам/		8.8	6.8	1.5	123	0.15
Стандарт д/MNS 5850:2008/		100	150	150	300	3

Гарц


Хамгийн түрүүнд ил жорлон, бохир усны асуудлыг шийдэж, цэвэр бохир усны шугаманд гэр хорооллыг холбох. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт, хяналтыг сайжруулах. Хог, хаягдлыг ангилдаг болох, хог тээвэрлэлтийн машины тоог нэмэх, шаардлага хангаагүй ил задгай авто засварын газруудыг хаах нь нэн тэргүүний асуудал гэдгийг мэргэжилтнүүд хэлсэн. Энэ талаар Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал Н.Сайжаа "Гэр хорооллын айлуудын нүхэн жорлонгийн 70 орчим хувь нь шаардлага хангахгүй, хөрсний бохирдлын гол эх үүсвэр болж байна. Тиймээс иргэд нүхэн жорлонгоо сайн битүүмжлэлтэй хийх хэрэгтэй" гэв. Бохирдлын өөр нэг эх үүсвэр болох авто засвар, үйлчилгээний газрууд ашигласан масло, тосоо зориулалтын саванд хадгалж, тусгай газарт устгах шаардлагатай. Түүнчлэн гаднах талбайгаа хатуу хучилттай болгож, ШТС-ууд нефтийн гаралтай болон ахуйн хог хаягдлаа ил задгай хаяхгүй байх нь чухал гэдгийг Авто тээврийн газрын техник, технологийн хэлтсийн дарга Н.Баттулга сануулсан.

Харин иргэн таны зүгээс бохир усаа ил асгахгүй, ойр орчноо цэвэр цэмцгэр байлгаж, зүлэгжүүлэх зэргээр хөрсөө бохирдуулахгүй байх нь өөрийнхөө болон үр хүүхдийнхээ эрүүл мэндэд оруулж буй үнэтэй хөрөнгө оруулалт юм. ■

Судалгаа

Өнгөрсөн онд БОАЖЯ, "Цэвэр агаар сан"-гийн захиалгаар Шинжлэх ухааны академийн Газар зүйн хүрээлэнгээс "Улаанбаатар хотын хөрсний бохирдол, экогеохимийн үнэлгээ"-г хийжээ. Судалгааны багийнхан нийслэлийн хүн ам ихээр төвлөрдөг СХД, БЗД, ХУД, ЧД, СБД болон томоохон захууд байрладаг газрын хөрснөөс нийт 219 дээж авч шинжлэхэд бохирдол байх ёстой хэмжээнээс хэт өндөр гарчээ. Тухайлбал, хүний биед хортой хүнд элементүүд болох хар тугалга, мышьяк, цагаан тугалга байх ёстой хэмжээнээс 2-42 дахин, цайр, хром, молибден 2-14 дахин ихэссэн байна. Мөн Улаанбаатар хотын хөрс нянгийн бохирдол, мөөгөнцөр ихтэй байгаа аж. Судалгаагаар нийслэлийн хөрсний бохирдол дундаж түвшинд байна гэж дүгнэсэн бөгөөд ирэх 10 жилд хар тугалга, хром, кадмий зэрэг хүнд металлын агууламж өсөх хандлагатай байгааг тогтоожээ.

Улаанбатар хот дахь голын ёроолын дээжний бохирдлын судалгаа /Хар тугалга (Fb) мг/кг/



http://www.mongolianeconomy.mn



Засгийн газрын хаягаар

Хотын утааг шингэрнэ гэж горьдохгүй л байхаас даа

Б.Баяртогтох

Улаанбаатар хот 20 жилийн дараа ямар байх бол гэж Та боддог вэ? Агаарын бохирдол, замын түгжрэл тэр үед одоогийнх шиг байх уу. Өдгөө Хан-Уул дүүргийн Зайсан орчимд шинэ хороолуудд шил шилээ даран сүндэрлэж байна. Харин Чингэлтэй, Баянхошуу, Толгойт, Дэнжийн 1000-ын гэр хорооллоос орон сууцад шилжсэн айл өчүүхнээс өчүүхэн байгаа юм. Гэтэл Улаанбаатар Туул голоо даган барилгажиж, Сонгинохайрхан, Баянхошууны гэр хороолол нь улам л нягтаршиж байгааг Та мэдэх биз ээ. Гэр хорооллолд хүүхдүүдэд хөл бөмбөг тоглох зай талбай ч алга. Тэнд дэндүү давчуу гудамж л бий. Туулын гүүрнээс нааш, цаашаа хоёр өөр амьдралын хэв маяг улам л тодорч, доройтсоор. Утаанаас нэг нь зугатаж байхад нөгөө нь утаатай бүсэд амьдрах гэж газар худалдан авч байна.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд 2010 он гэхэд нийслэлийн нийт өрхийн 60-70 хувийг инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд оруулахаар төлөвлөсөн байдаг. Өнөөдөр 2012 он. Нийслэлийн айл өрхийн хэд нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд шилжсэн билээ гэтэл хэлэх тоо байдаггүй. Давхар замтай, метротой, утаагүй, бас автомашины түгжрэлгүй, ногоон байгууламжтай орчин үеийн хотыг 2020 он хүртэлх Улаанбаатар хотын шинэ төлөвлөгөө цогцлооно шүү дээ. Гэтэл хотыг орон сууцжуулах ажил нэг л урагшгүй. 21 удаа нүүж суусан, Улаанбаатарыг хот төлөвлөлтийн хувьд улам гоё болгохоор төлөвлөсөн ажил нь ямар ч хэрэгжилтгүй байгааг Хотын удирдлагуудаас асуухад хөрөнгө мөнгөгүйн шалтгаан тоочдог. Нийслэлийн хүн амын тоо 2030 он гэхэд хоёр саяд хүрнэ. Тодруулбал, хүн амын өсөлтийг дагаад эрчим хүч, дулаан, ус, нийтийн тээвэр, орон байрны хэрэглээ одоогийнхоос хоёр дахин өсөж таарна. 600 мянган хүнд зориулагдсан хотын хэмнэл улам л бачуухан болох бололтой. Төвлөрөл хэдий чинээ их байна төдий чинээ агаарын болон орчны бохирдол ихэсдэг аж. Одоогоор нэг га талбайд нийслэлд 2362 хүн ногдож байна. Харин хүн амын нягтрал нэмэгдэхийн хэрээр эмх цэгцгүй гэр хорооллууд өрхөө татаж, бүл нэмсээр.

Уг нь хот төлөвлөлтийг шинээр авч үзэхдээ нийслэлээ нүүлгэх биш орон сууцжуулах бодлогыг нийслэлээс барьж байгаа юм билээ. Тиймээс хотын 2030 он хүртэлх төлөвлөгөөнд дагуул хотуудыг хөгжүүлэхээр Багануур, Налайх, Багахангай дүүргийг сонгожээ. Багахангай дүүрэг 2030 он гэхэд 20 мянган хүн амтай, хог хаягдал боловсруулах томоохон үйлдвэртэй байхаар төлөвлөөд байгаа аж.

Засгийн газрын баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг энэ онд эрчимжүүлнэ гэдгээ ЗТБХБ-ын сайд Ц.Дашдорж мэдэгдсэн. Тэгвэл уг “урт настай” хөтөлбөрт багтсан Дэнжийн 1000, Яармаг, Буянт-Ухаа, Зурагтын гэр хорооллын газар шорооны ажил эхэлж магадгүй нь. “Жэймс Ло Сайбертекчюр интернешнл” компанийн үүсгэн байгуулагч Жэймс Ло “Хот төлөвлөлтийг өнгөрсөнд бус, ирээдүйдээ зориулж гаргах хэрэгтэй. Тэгэхлээр Улаанбаатар хотын төлөвлөлтийг 10, 20, 50 жилээр бус, харин ирэх хэдэн зуун жилийг урьдчилан харж хийх шаардлагатай” гэжээ. Харин манайд 10, 20, 50 жилээр төлөвлөж хотоо хөгжүүлэх тодорхой бодлого байна уу. Тээр холын биш юмаа гэхэд зөв төлөвлөлттэй хот руу шилжих анхны санал санаачлагыг урагшлуулах талаар үр дүн байна уу гээд харахаар тун бага.

Лондоны их сургуулийн Коллежийн уран барилгын ангийг 1992 онд төгссөн Дэлхийн эдийн засгийн форумаас 2010 онд Дэлхийн залуу удирдагчаар шалгарсан Жэймс Ло манай Улаанбаатарын хот төлөвлөлтийг

http://www.mongolianeconomy.mn

гаднын бөгөөд мэргэжлийн хүний нүдээр харахад ямар байгааг товч бөгөөд тодорхой хэлээд өгчээ. Манай сэтгүүлд өгсөн түүний сонирхолтой ярилцлага хот төлөвлөлтийн талаар санаа сэтгэлээ чилээдэг хүмүүст нэгийг бодуулж, хоёрыг сэтгэхээр ухаан сэдлийг төрүүлэх биз ээ. Ялангуяа “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийг хоёр жилийн өмнө батлалцсан Засгийн газрын гишүүд, төрийн түшээдийг уг ярилцлагыг зориуд уншаад, үйл хөдлөлдөө дүгнэлт хийж, нийслэлийнхээ өнгө төрхийг өөд татах талаар нэгийг бодож, хоёрыг хийгээсэй гэж хүсэх байна. Тэрбээр ирэх жилүүдэд гарах эдийн засгийн өсөлтөд зориулж Улаанбаатар “ухаалаг” хотын сүлжээний суурийг тавих хэрэгтэй гэж зөвлөсөн байна. Товчхондоо ухаалаг хот нь ухаалаг төрийн удирдлага, ухаалаг иргэнээс л шалтгаалах болов уу.

Хөгжлийн банк эцсийн алтан найдвар

Газраа орон сууц болгоё гэсэн хүсэлтэй хүмүүс гэр хорооллоор дүүрэн. Тоос шороо, утаа униар ядаж л нүүрс, зөөврийн уснаас холдож, халуун ус, халаалттай сууцад амьдрахыг хүмүүс мөрөөдөж байхад төр орон сууцжуулах хөтөлбөртөө гар тэнийдэггүй ээ. Ил жорлон, угаадас, шавар шавхайнаас хөндийрэн, хотын соёлоор амьдрахыг хүссэн 200 мянган өрхийн ойрын зорилго нь орон сууц шүү дээ. Гэтэл орон сууцжуулах хөтөлбөр нь хөрөнгө мөнгөгүйн шалтгаанаас болоод хэрэгжиж чадахгүй байгааг ЗТБХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ учирлалаа. Алтан найдвар нь Хөгжлийн банкны 800 тэрбум төгрөгийн бонд гэнэ. Нийслэлд өөрт нь 100 мянган айлын орон сууцыг үе шаттайгаар санхүүжүүлээд явах боломж байхгүй юм уу гэдэг талаар Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяраас Агаарын бохирдлын Үндэсний хорооны саяхны хурал дээр асуухад “боломжгүй ээ” гэдэг хариултыг шуудхан хэлж байлаа.

Иргэддээ сар бүр 21 мянган төгрөг тарааж байгааг нь бодохоор төр халаасандаа мөнгөтэй мэт. Гэтэл өөрсдийн баталсан, агаарын бохирдлыг бууруулах том ажлаа ийн баллаж байгаа нь хачирхалтай. Жилийн зургаан хувийн хүүтэй, 25 хүртэлх жилийн хугацаатайгаар орон сууцны зээл хүртэл олгох тухай ярьсансан. Газартай, тодорхой эрхэлсэн ажилтай иргэдэд орон сууц гэдэг энүүхэн ойрын асуудал болсныг “100 мянган айлын орон сууц” төсөл бадраасан юм. 100 мянган айл орон сууцны 75 мянга нь Улаанбаатарт, үлдсэн нь орон нутагт хэмээн заагдсан боловч өнөөдөр зөвхөн төсөөлөл төдий л байна.

“Гэр хорооллын хамгийн их төвлөрөлтэй, утааны голомт хэсэг болох хотын хоймор хэсгээсээ барилгажуулах ажлаа яаравчлан эхлээчээ. Утааг бууруулах бодлогынхоо эсрэг хотын хамгийн цэвэр агаартай гэж хэлж болох Хан-Уул дүүрэгт тэр дундаа Зайсан руу шинээр орон сууц барих ажил түлхүү явж байгаа. Яармаг, Зурагт, Баянхошууны гэр хорооллыг орон сууцжуулах ажил яасан бэ” гэж Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж “Цэвэр агаар” төслийн талаар санал бодлоо хэлж байсан.

Утаагүй, замын түгжрэлгүй...

2010 оны зургадугаар сард Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн 0.3 хувь нь л өнөөдрийн байдлаар иргэдэд хүрээд байгаа аж. Гэм нь утааны голомтын бүс буюу орон сууцжуулах шинэ төлөвлөлтөд туссан Дэнжийн 1000, Яармаг, Буянт-Ухаа, Толгойтын гэр хорооолд барих 75 мянган айлын орон сууцны нэг нь ч баригдаагүй байна. Харин 12 мянган айлын орон сууцны барилгын ажил эхэлсэн хэмээн Ж.Бат-Эрдэнэ тэмдэглэсэн. Гэвч СХД-ийн нэг, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт 47 га талбайд барихаар төлөвлөгдсөн “Цэргийн хотхон”-ы эхний ээлжийн барилгуудыг ашиглалтад оруулсан нээлт болсныг эс тооцвол утааны голомт бүхий гэр хорооллын дунд боссон орон сууц одоогоор бараг алга. Харин Нямдорж сайдын хэлдгээр Улаанбаатарын харьцангуй утаа багатай бүс болох Хан-Уул дүүрэгт орон сууцны барилгын ажил түлхүү явагдаж буйг уншигч Та ч гэсэн ажигласан биз. Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр “Орон сууцжуулах хөтөлбөрийн хөрөнгө мөнгийг даруй шийдэж, тендер зарлах шаардлагатай”

Орон нутгийн хөгжил

Амьдрал бэлэглье

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга О.Машбат “Хөдөөнөөс хотыг чиглэсэн их нүүдлийг ойрын жилүүдэд зогсоох эрх зүйн орчин бүрдэхгүй байх. Үүнтэй тэмцэх гол арга бол сумдыг хөгжүүлэх” гэдгийг чухалчилсан юм.

Орон нутгийн иргэд дуртайдаа өсөж, төрсөн нутаг, ах дүүсээ орхин хот суурин газрыг бараадаг гэвэл том эндүүрэл. Зудад малаа барсан, ажилгүй, мэргэжилгүй хүмүүст өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ тэнгэрт хадсан хөдөөд амьдрах хэцүү гэдгийг хэн хүнгүй мэднэ. Амьдарч буй сум, багт нь ажлын байр, амьжиргааны эх үүсвэр, тогтмол цалин гээд хүн амьдрахад таатай орчинг нь бүрдүүлээд өгвөл хэн ч төрсөн нутаг усаа орхихыг хүсэхгүй. Тиймээс орон нутгийн иргэдийг хөдөөд нь тогтоож, шилжилт хөдөлгөөнийг багасгахын тулд сум, бүсийг хөгжүүлэх шаардлагатай тулгарч байна. Монгол Улсын Засгийн газраас 21 аймгийг таван бүсэд хуваж, хөгжлийг бүсүүдийн төвд төвлөрүүлэх бодлого боловсруулж, 2011-2016 онд хэрэгжүүлэхээр баталсан ч дорвитой зүйл хийгдээгүй л байна. “Шинэ сумын төв” хэмээх энэхүү бодлого хурдан биелэлээ олж, сумын төвийн сургууль, цэцэрлэг зэрэг хуучин барилгуудын өнгө төрхийг сэргээж, багш, боловсон хүчний мэдлэг, чадварыг сайжруулж, дэд бүтцийг хөгжүүлж, худалдааны төвүүд үүд хаалгаа нээж, түүнийг дагаад ажлын байр, тогтмол цалин бий болж, ядаж л засмал замаар аймгийн төвүүдтэй холбогдоод эхэлбэл ард иргэдийн хотыг зорих хүсэл бага багаар арилна. Жилд хийгддэг бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын 80-85 хувь нь зөвхөн нийслэлд төвлөрдөг гэдэг. Дан ганц нийслэлчүүдийн эрүүл мэнд, агаарын бохирдлыг бууруулахад биш хөгжлийг хөдөө, хот ялгалгүй жигд бүтээх цаг иржээ.

http://www.mongolianeconomy.mn

гэсэн ч хөрөнгийн гачигдал гацаах том шалтгаан болж байна. Саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг. Харин барилгын ажил ирэх хавартай уралдан эхлэх эсэхийг Хөгжлийн банкны санхүүжилтээс ихээхэн хамаарах нь. Хөгжлийн банкнаас хэзээ хөрөнгө гарна, тэр үед л утааны голомтод шав тавих нь гэж ойлгож болох юм. Монгол Улсын гал голомт, зүрх нь болсон Улаанбаатарыг орон сууцжуулах “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөр хэрэгжсэнээр ирэх онд хотын агаарын бохирдлыг 60 хувиар бууруулна” хэмээн нийслэлийн Агаарын чанарын албаны дарга Д.Мөнхцог тэмдэглэсэн. Ганцхан зуны дотор Улаанбаатарт 75 мянган айлын орон сууц сүндэрлэхгүй нь ойлгомжтой. Гэрлийн хурдаар ажиллаад ч нэлээд хэдэн өвлийг гэр хороллынхон нүүрстэйгээ хамт давах нь гашуун үнэн.

Одоогийн тооцоолсноор “100 мянган айлын орон сууц” төслийг барьж, ашиглалтад оруулахад 18.2 их наяд төгрөг зарцуулна гэсэн албаны тоо бий. Орон сууцыг дагаад эмнэлэг, сургууль, цэцэрлэг, спорт цогцолбор, ногоон байгууламжийг ч хамтаар нь шийдэх юм байна. “Улаанбаатар хотын ногоон байгууламжийн нэг хүнд ногдох хэмжээг нэмэгдүүлэх, утааны ялгаруулалтыг 30 хувь бууруулах, хорт хийн ялгарлыг 50 хувиар багасгахаар орон сууцны хөтөлбөрийг төлөвлөсөн” хэмээн Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын дарга Э.Хүрэлбаатар онцолсон. Үнэхээр ч нийслэлийн барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газраас гаргасан “Улаанбаатар хот-Шинэ бүтээн байгуулалт” сэтгүүлд Хүрэлбаатар даргын хэлсэн зүйл зураг болон маш тодорхой буусан байхыг хараад ийм гоё болох юм байх даа гэж гайхсанаа нуух юун. Гэр хороололд шинээр барих орон сууцны хороллуудыг дэд бүтцийг нь хүртэл хэзээ, хэрхэн шийдэхээ тодорхой тусгаж өгсөн байсан. Ийм сайхан том, тодорхой хөтөлбөр боловсруулж, олон хүний хөдөлмөр, оюун чадлыг нь чилээн байж зураг төсөл гаргуулчихаад эцэстээ хөрөнгө байхгүй гээд сууж болохгүй санагдана. Уг хөтөлбөр нь 2011-2016 он хүртэл үргэлжлэх хугацаатай.Монголын архитекторуудын холбооны ерөнхийлөгч Б.Батжав “Хот гэдэг иргэдийнхээ сайн сайхан ая тухтай аж амьдралын төлөө бүтээгдсэн зохиомол орчин. Иргэдийнхээ төлөө л хот оршиж, хөгжиж байх ёстой” гэв.

Цонхны цаана модод гөлөглөж, хотын амьдралд урин цаг айлчлах нь ээ. Улаанбаатарын саруулхан үдшийг мөрөөднөм. Мөрөөдөл минь утаагүй, замын түгжрэлгүй, өндөр өндөр орон сууцны хороололтой, өөрийн эзэмшлийн 0,07 га газар дээрээ амьдардаг иргэд нь нүүрс гэдгийг хэдийнэ умартсан тухлаг сууцтай, хүүхэд багачууд гадаа тоглоод ч гар, хувцас нь муухай болдоггүй тийм л сайхан хот болоосой. ■

Дэлхийн залуу удирдагч

Нялх хотын төрх



Х.Хулан

Жэймс Ло нь анх 2001 онд байгуулагдсан “Жэймс Ло Сайбертекчюр Интернэшнл” компанийн үүсгэн байгуулагч. Тэрбээр Лондоны их сургуулийн Коллежийн уран барилгын ангийг 1992 онд төгсжээ. Дэлхийн эдийн засгийн форумаас 2010 онд Дэлхийн залуу удирдагчаар шалгарсан бөгөөд одоо сайбер технологийг орчин үеийн барилгатай хослуулах зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Жэймс Ло нь алдартай архитектор. Английн уран барилгачдын Ройал Институтын гишүүн.

-Таныг Улаанбаатар хотын төлөвлөлт дээр хамтран ажиллах сонирхолтой гэж сонслоо. Та төлөвлөгөөгөө гаргасан уу?

-Юуны өмнө хот нь аливаа улсын маш чухал хэсэг мөн гэдгийг хэлмээр байна. Ялангуяа өөрчлөлт шинэчлэлтийг дагуулах Монгол Улсын хувьд амин чухал үүрэгтэй. Бид хотын төлөвлөлтийг өнгөрсөнд бус, ирээдүйдээ зориулж гаргах хэрэгтэй. Тэгэхлээр Улаанбаатар хотын төлөвлөлтийг 10, 20, 50 жилээр бус, харин ирэх хэдэн зуун жилийг урьдчилан харж хийх шаардлагатай. Танай нийслэлд ирж үзсэний

http://www.mongolianeconomy.mn

хувьд хэлэхэд, өнгөрсөн үеийн бүх бэрхшээлтэй асуудал ил харагдаж байна. Дотоод бүтэц тааруухан, мөн хот асар хурдацтай өсөн томрох хандлагатай байна.

Ирэх жилүүдэд гарах өсөлтөд зориулж “ухаалаг” хотын сүлжээний суурийг тавих хэрэгтэй. Үүний дизайн болон тогтолцоог үйл ажиллагаа тус бүрт зориулсан бүсээр эхлүүлж болно. Ингэснээр бизнесийн, оршин суугчдын, соёлын, эрдэм шинжилгээ технологийн, мэдээллийн, эрчим хүчний гэсэн дүүргүүдтэй болно. Дүүрэг бүр органик хэлбэрээр өсөж, цаг хугацаа өнгөрөх тусам сайжирна. Үүнийг компьютерийн программыг шинэчлэхтэй адил гэж зүйрлэж болно. Ийм шинэ ухаалаг хотуудыг бид сайбертекчюр хот гэж нэрлэдэг. Эдгээрийг улс үндэстэн, нийгэм хөгжих тутам компьютерийн программ шиг сайжруулан шинэчилж болдог.

Мөн хотыг илүү тогтвортой хөгжлийн замаар хөгжүүлэх хэрэгтэй. Эрчим хүч болон бусад нөөцийг шинэ маягаар дахин боловсруулж, хэрэглэснээр үндсээр нь шинэчилнэ. Тэгэхлээр өнөөдөр хотыг ирээдүйн цахилгаан машинд зориулж төлөвлөнө. Хотод амьдарч ажиллах хэдэн мянган хүмүүст зориулсан, агаар бохирдуулахгүй, түгжрэл үүсгэхгүй тийм олон нийтийн тээврийн хэрэгсэл болох дамжин суух галт тэргийг бодолцох хэрэгтэй. Гэр бүлээ өсөн нэмэгдүүлж, таатай бөгөөд ногоон орчинд амьдрах байшин барилга, олон улсын дээд зэрэглэлийн стандартат нийцсэн бизнесийн дүүргийг бодолцоно. Энэ бүх ажлыг өнөөдөр төлөвлөж эхэлнэ. Учир нь, эдгээр санааг хэрэгжүүлэхэд 10, 20, 30 жилийн хугацаа орно. Хуучин биш, шинэ “сайбертекчюр” концепц бидэнд хэрэгтэй. Бид хотыг зөвхөн бетон, төмөр, шилнээс бус харин эдгээрийг маргаашийн технологи, шинэчлэлтэй хослуулан барих хэрэгтэй. Тэгж чадваас энэ нь Монголд урт удаан наслах үндэслэлтэй болно.

-Та манай хотыг анх удаа хараад архитектор мэргэжилтэй хүний хувьд юу гэж бодсон бэ?

-Анх нийслэл Улаанбаатар хотыг хараад нялх хүүхэд шиг байна даа гэсэн сэтгэгдэл төрсөн. Онгоцноос харахад уулсын дунд олон жижиг чулуунуудыг талаар нэг тараасан мэт харагдсан. Ямар ч зохион байгуулалт, хил хязгаар, бүлэглэл, удирдлагагүй замбараагүй. Харин хот руу ороод ирэхээр хөгжил нэлээд хурдацтай явагдаж буйг мэдэрсэн. Шинэ барилга байшин баригдаж байгаа ч нэгдсэн бодлогын хүрээнд орж чадаагүй байна. Мөн орон сууцны байранд зориулсан загвар алга. Хүмүүс гэрт, хувийн байшинд, зарим нь нийтийн орон сууцанд амьдарч байна. Аливааг бүтээхдээ, мөн чанарыг хэрхэн бий болгох вэ гэдэг дээр тодорхой систем алга. Замын түгжрэлийн бэрхшээл нь зам биш, харин зохицуулалтдаа байна. Гэрлэн дохиог би анзаарч харсан. Зарим үед гэрэл асахгүй, дохио солигдох хугацаа буруу, эсхүл хүмүүс гэрлэн дохиог үл тоомсорлон гарч байсан.

Хотын замын хөдөлгөөнийг зохицуулна гэдэг нь ганц биш, хэдэн мянган уулзварыг удирдана гэсэн үг. Компьютер ийнхүү хөдөлгөөнийг хамгийн үр ашигтайгаар зохицуулж чадна. Орчин үеийн хотын цагийн тогтолцоо нягт нямбай байх ёстой. Нийслэл хотыг балчир хүүхдээр авч үзэхэд, энэ хүүхдийг өсгөж томруулахын тулд шинэ тоглоом, хэрэгсэл өгөх зайлшгүй хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, ур чадвар олгож, том хүн болгож авна гэсэн үг. Энэ бүхнийг яг одоо л хэрэгжүүлж эхлэхгүй юм бол, Улаанбаатар хотын ачаалал, бэрхшээл нь улам нэмэгдэнэ. Бид урьдчилан харагчдын хувьд Засгийн газарт хот төлөвлөлт дээр зөвлөж байж урт настай, тогтвортой, орчин үеийн, ухаалаг хот бий болно.

-Ухаалаг хот гэж Та ямар хотыг хэлэх вэ. Жишээ хэлж болох уу?

-Ухаалаг хот гэдгийг тайлбарлахаас өмнө, хот гэж чухам юу болохыг ойлгох хэрэгтэй. Нийгэм, эдийн засгийн шалтгааны улмаас нэг газар аж төрж, ажилладаг хүмүүсийн бүлэг хотыг бүрдүүлдэг. Тэнд том компани аж ахуйн нэгжүүд, Засгийн газар, сургууль, онгоцны буудал, аж үйлдвэр бүгд төвлөрдөг тул хүмүүс ч мөн адил тэнд төвлөрдөг. Гэхдээ эдгээр хүмүүсийг нэг дор бөөгнөрүүлэхэд тэд сайн зохицуулагч байж чадахгүй. Хүн хэдийгээр сайн сэтгэн боддог ч амиа хичээсэн байдаг. Эртний хотууд ухаалаг байгаагүй.

Ухаалаг хот гэдэг нь хотыг төлөвлөж, үр ашгийг өндөр түвшинд байлгахад чиглэгдсэн хүрээ юм. Эрсдэлтэй тулгарах чадамжтай байх ёстой. Жишээ нь хотод үр ашиггүй алдагдаж байгаа ус, эрчим хүчний хэмжээ асар их байна. Ухаалаг хотод нэг дүүрэг албан байгууллагын зориулалттай байх бөгөөд өдрийн цагт эрчим хүчийг түлхүү хэрэглэнэ. Өөр нэг дүүргээс тэр эрчим хүчийг хуваалцах боломжтой. Тэгээд бизнесийн хороололд амралтын өдрүүдэд эрчим хүчний зарцуулалт бага болохоор нь илүү их хэмнэлт гаргаж болно. Эрчим хүч, хүний нөөц, харилцаа холбоон дээр ч гэсэн ийм л аспектаар хандах шаардлагатай билээ. Бүсүүдийг бизнесийн болон оршин суугчдийнх гэж хуваана. Хүмүүс ажилдаа очих гэж хотын нэг захаас нөгөө рүү явж байна. Тэгвэл шинэ хотын оршин суугчид яагаад нэг л газраа ажиллаж амьдарч болохгүй гэж. Бид эрчим хүч, цагаа хэмнэн тэрхүү нөөцөө хүмүүсийн амьдралыг нь сайжруулахад зарцуулъя. Иргэдийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын стандартыг нь сайжруулж байж ухаалаг хот болно. Ийм хотыг бүтээн байгуулахын тулд шинэ дотоод бүтэц, шинэлэг санаа бидэнд шаардагдана.

-Улаанбаатар маань хээзээ таны ярьж байгаа шиг ийм ухаалаг хот болох бол?

-Нэг шөнийн дотор бүтээн байгуулагдах зүйл биш. Гэхдээ Монгол Улсын хувьд том давуу талтай. Лондон, Хонконг гэхчлэн томоохон хотуудын дотоод бүтэц аль хэдийнэ хийгдсэн учир шинэчлэхэд хэцүү. Өсөлтийнхөө дунд шатанд байгаа Шанхай, Бээжин хотууд ч мөн адил.

Харин Улаанбаатар залуу хот учраас хүмүүс ирээгүй, утасгүй холболт, шугам сүлжээ тавигдаж дуусаагүй байна. Иймд одооноос ухаалгаар ажлыг эхлүүлбэл хотын өсөлт хөгжил ч үүнтэй хамт эхэлнэ. Эхний үе шатанд таван жилийн хугацаа шаардлагатай байх гэж бодож байна. Гэхдээ маш ухаалгаар бодож хийх нь чухал. Тэрнээс биш, шил толь болсон гял цал өндөр барилгуудыг чухалчлах нь гол биш. Хойч үеэ бодож, урт хугацааны төлөвлөлтөд чиглүүлэх хэрэгтэй.

-Та залуучуудад хандаж юу хэлэх вэ?

-Монгол хүүхэд, оюутан залуустай уулзсан. Тэд өөдрөг үзлээр дүүрэн байгаа нь мэдэгдсэн. Мөн хүмүүс өнөөдрөөр биш, маргаашаа бодож амьдарч байгаа нь улс орны хувьд маш сайн юм. Монгол 15 жилийн дараа дэлхийд тэргүүлсэн манлайлагч орон болохыг үгүйсгэхгүй. Залуу удирдагчид бид өөрчлөлт шинэчлэлт, өөдрөг байдал, мөрөөдлийн эрч хүчийг олж хардаг. Монголд ирээд сая сая хүний амьдралыг өөрчлөх боломж байгааг мэдэрсэн. Тэр бол жинхэнэ боломж. Бид цаг алдалгүй боломжийг тэвэрч аван, ирээдүйд тохирсон бодит санаа, арга барил, алсын хараг гаргах хэрэгтэй байна. ■

http://www.mongolianeconomy.mn



Түүх

Манан дундах “Алуурчин”



Б.Энхцэцэг

Хүн төрөлхтний нэгэн цагт бүтээсэн гайхамшиг гамшиг болон хувирах нь цөөнгүй тохиолддогийг тэртээх 50 жилийн өмнө Лондон хотын олон мянган хүний амийг бүрэлгэсэн “Их утаат манан” гэрчлэх билээ. Хэдэн зуун жилийн турш утаа, манан Их Британи улсын томоохон хотууд тэр дундаа Лондон хотын амьдралын нэг хэсэг байсаар ирсэн. Үүний гол эх үүсвэр нь хэн бүхэнд нүүрс их хэмжээгээр түлэх явдал гэдэг нь илэрхий байсан юм. Манан гэгч үзэгдэл нь хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөс гадна нэг газраас нөгөөд хүрэх замдаа төөрөх, хулгайч дээрэмчдийн олз болох гэх мэт аюулыг дагуулдаг байв. Англий алдарт зохиолч Чарлез Диккенс хүртэл Лондон хотын саарал дүр төрхийг “Хүйтэн байшин” зохиолдоо зурмал зураг, өөрийн үгтэй хослуулан дүрсэлсэн байдаг билээ.

Ромын эзэнт гүрний үеэс манан татсан сүүмгэр төрхөөрөө зард гарсан Лондон хотын тэнгэр үргэлж хөмсөг зангидан бүдийх авч хэзээ ч тэдгээр өдөр шиг манан утаа хосолсон өтгөн хөшиг татаж байсан удаагүй. Тэр өвөл цаг агаар хэдэн долоо хоногийн турш олон жилийн дунджаас эрс хүйтэн байсан бөгөөд арваннэгдүгээр сард цас их хэмжээгээр унасан байжээ. Эхний өдөр буюу арванхоёрдугаар сарын 5-нд манан тэдийлэн өтгөн биш ч хуурай утаа ихтэй байжээ. Хүйтний эрч чангарах тусам лондончууд дулаацахын эрхэнд галаа улам өрдөхийг хэрээр тэдий чинээ их нүүрс шатна. Ойролцоогоор нэг сая гаруй айлын зуухнаас нүүгэлтсэн хар утаа тасралтгүй суунаглаж байлаа. Дайран дээр давс гэдгээр дотоодын үйлдвэрүүд жирийн өдрүүдийн адил жинтэй хувь нэмрээ агаарт өргөсөөр. Яг энэ үед Лондон хотын цахилгаан трамбай дизель хөдөлгүүртэй автобусаар солигдож утаа гаргах эх үүсвэр олон зуугаараа нэмэгдсэн юм.

Лондонд вандуйтай шөл мэт зузаан манан үргэлж татдаг тул ийнхүү “Вандуйтай шөл” хэмээн нэрлэгдэх болсон хотын иргэд жирийн үзэгдэл мэтсанан, тэдийлэн гайхаж хүлээж авсангүй. Гэвч энэ явдал Лондон хотыг 1952 оны арванхоёрдугаар сарын 5-9 хүртэл зогсонги, үхмэл байдалд оруулжээ. Шөнийн хүйтэн агаар утаат мананг өтгөрүүлж үзэгдэх орчныг улам багасгаж байлаа. Эхний өдөр үзэгдэх орчин 500 метрт байсан бол, дараагийн өдөр 50 метрт хүрч сүүлдээ хэдхэн метрийн зайд ч юмс үзэгдэхээ байжээ. Үүнээс үүдэн зарим газар хүмүүс хөл гараа ч олж харахгүй болсон байв. Зам талбай эзэнгүй машинаар дүүрч, кино театрт утаа орж, дэлгэц харагдахгүй болсон тул хүмүүс гэр гэрлүүгээ

http://www.mongolianeconomy.mn

яаран буцаж байсныг иргэд дурсан ярьдаг. Хаашаа ч явсан ямар ч зүг чигийн баримжаагүй болсон тул төмөр зам, агаарын болон нийтийн тээвэр зогсож ,сургууль цэцэрлэг хаагдахад хүрчээ. Утаат манан яг л урсгал ус мэт түрэмгийлэн үүд нээх төдийд давшлан орж ирч байсан тул дэлгүүр хоршоод хаалгаа барьж, ард иргэд гэртээ бүгэх болов. Агаарын өндөр даралт, хүйтэн хэмтэй нэгдэж дээр нь нам гүм салхигүй орчин утаат мананг хаашаа ч хөдөлгөлгүй тогтоочихсон нь яг л тогоон дээр таг тавчихсан мэт Лондон хотыг утаатай цуг хашчихсан аж.

Бүтэн дөрвөн өдөр үргэлжилсэ дотор хирдхийлгэм 1952 оны арванхоёрдугаар сарын утаат манан дөрвөн мянга гаруй хүний амь насыг авч одсон юм. Үүнээс хойш хоёр сар гаруй хугацаа өнгөрөхөд энэ тоо найман мянгаар нэмэгдэж 12000 болжээ. Ихэнх амь үрэгдэгсэд амьсгалын замын болон зүрх судасны өвчний улмаас нас барсан бөгөөд зөвхөн архаг хууч өвчтэй хүмүүст утаат манан үхлийн цохилт өгсөн байна. Энэ нь ужиг өвчинг сэдрээж хэвтэрт орсон тэдний уушгыг хорт утаа асар хурдацтай доройтуулсан байжээ. Хамгийн түрүүнд нийслэлийн төв эмнэлгийн эмч сувилагч болон цогцос хадгалах газрын ажилтнууд богино хугацаанд үхэлд хүргэх аюул заналхийлж байгааг мэджээ.Тэд бүх нас барагсдын уруул нь хөхөрсөн байсныг анзаарсан гэдэг.

Оршуулгын “хөтөч” Стан Криб болон түүний хөвгүүд Лондон хотын сааралтсан гудамжаар мянга мянган оршуулгын цуваг чиглүүлэн авч явж байжээ. Тэрээр хэлэхдээ “ Яг л нүд минь сохорсон юм шиг, юу ч харагдахгүй байсан” ажээ. Үнэхээр ч лондончууд дөрвөн өдрийн турш сохор мэт амьдарч, бие махбодь, оюун санаагаараа тарчилж байсан юм. 1952 оны арванхоёрдугаар сарын 9-нд салхи гарч, утаат мананг хөөн зайлуулсан авч аль хэдийнэ хэдэн мянган хүн нас барж, дахин хэдэн мянган хүний хувьд сэхэхэд дэндүү оройтсон байжээ. Тэдний ихэнх нь хөгшин настай, архаг өвчтэй болон биеийн эсэргүүцэл султай хүмүүс байсан байдаг. Өвчтөнүүдийг хүлээж авч байсан эмнэлгийн ажилчдын хэлснээр тухайн үед тун цөөхөн хүн юу болоод байгаа талаар ойлголттой байж. 1950 оны эхэн үед нийслэлийн “Сант Бартоломю” эмнэлэгт ажиллаж байсан Доктор Роберт Воллер “Маш олон хүний амь нас сүйдэж байгааг авсны хүрэлцээ муудаж, цэцэгний худалдаа эрс нэмэгдсэн нь тодхон харуулж байлаа” хэмээжээ. “Алуурчин” хэмээн нэрлэгддэг энэ утаат манан орчны бохирдлыг дэлхийн нийт өөр нүдээр харахад хүргэсэн юм.

Хүнтөрөлхтнийөөрийнгараартарьсан байгалийн гамшгийн нэгт тооцогддог энэхүү үйл явдал Лондон хотыг 1954 онд төрөлжсөн эрчим хүчний эх үүсвэртэй болох, мөн “Цэвэр агаар” хуулийн төслийг бодит биелэл болгоход хүчтэй түлхжээ. Шинэ хуулийн зохицуулалтаар утаа ихээр гаргадаг түлшийг хориглосон бөгөөд оршин суугчид болон үйлдвэр эрхлэгчид утаагүй түлш хэрэглэх ёстой болсон билээ. Цэвэр агаарын тухай хууль гарсан авч 1960 оныг хүртэл зузаан утаат манан оршсоор ирсэн гэдэг. 1956 болон 1968 онд “Цэвэр агаарын тухай” хоёр ч хуулийн төслийг Парламентаас баталснаар үйлдвэр, айл өрхийн нүүрсний хэрэглээг тодорхой хэмжээнд багасгаж чадсан юм. Өөрөөр хэлбэл, төр төмөр нүүрээ гаргасан хэд хэдэн хатуу шийдвэр гаргасны дүнд тодорхой үр дүн харагдаж эхэлсэн гэдэг.

Үйлдвэрлэл хөгжсөн орнууд хуулийн зохицуулалтаар агаарын бохирдолтой тэмцэж байгаа хэдий ч дэлхийн олон улс оронд Лондон хотын гашуун туршлагыг давтахад ойрхон ирээд байгаа юм. Лондончууд өнөөдөр ч хүний эрүүл мэндэд нөлөөлөхүйц хэмжээний агаарын бохирдолтой орчинд амьдарч байна. Гэхдээ тус хотын зам машинаар хахаж, тэр чинээгээр агаарын чанар өдөр ирэх тусам дордож байгаа нь тус улсад гамшигт 1952 оны үйл явдал давтагдахгүй гэх баталгаа байхгүйг харуулж байна.

Хоёр жил тутамд Иелийн их сургуулиас гаргадаг байгаль орчны үнэлгээнд Их Британи улс 2010 онд 14-р байрт зогсож байсан бол 2012 онд 9-р байр руу урагшилсан амжилт үзүүлжээ. Энэ нь тус улс хэдэн арван жил байгаль орчны асуудлаар хийсэн ажлын үр дүнтэй холбоотой гэх боловч олимпийн наадам зохиогдох болоход агаарын бохирдлын асуудал гамшгийн хэмжээнд босч ирсэн нь ихээхэн эргэлзээ төрүүлж байгаа юм. Монгол улс Иелийн их сургуулийн байгаль орчны үнэлгээгээр 2010 онд 142-т байсан бол энэ онд 107-р байранд жагсчээ. Олон сая хүний очиж үзэхийг мөрөөддөг энэ хот нөгөө талаас агаарын бохирдлын идэвхтэй бүс гэдгийг төдийлэн олон хүн мэддэггүй аж.

Энэ онд зуны Олимп Англи улсаар овоглогдох болсонтой холбогдуулан Лондон хотын хувьд агаарын бохирдол томоохон сорилт болоод байгаа юм. Олимпийн хөнгөн атлетикийн төрөлд өрсөлдөж буй тамирчин тус улсын хэвийн хэмжээнээс хэтэрсэн бохир агааараас үүдэн төдийлэн сайн оролцож чадахгүйгээс гадна өвчлөх ч магадлалтай байна. Цөөнгүй тамирчид энэ асуудлаас үүдэн оролцохоос татгалзсан хариу илгээжээ. Учир нь тэд жирийн хүмүүсээс хэд дахин илүү агаараар амьсгалах шаардлага тулгардаг учир төдий хэмжээнд эрүүл мэндийн хувьд эрсдэл үүрнэ гэсэн үг юм. Олимпийн үеэр манан татах, агаарын даралт ихсэх улмаар салхигүй байх гэх мэт цаг агаарын таагүй нөхцөл үүсвэл газар дээрх утааны хэмжээ ихсэх аюултай гэдгийг мэргэжилтнүүд анхааруулжээ. Европын холбооны тогтоосон хэмжээнээс хэтэрсэн агаарын чанарын үзүүлэлт Их Британи улсад 300 сая паундын торгууль авчрах магадлалтай байна.

2008 оны “Зуны Олимп” Бээжин хотод зохиогдсон билээ. Хятад улсын Засгийн газрын тогойн өвчин нь агаарын бохирдол болж байсан юм. Агаарын чанарын шаардлагыг хангахын тулд Бээжин хот машинуудаа тэгш сондгой дугаараар нь үндэслэн замын хөдөлгөөнд оролцох болон оролцохгүй өдрүүдийг зааж өгчээ. Томоохон үйлдвэрүүдийн бүтээмжийг багасгах болон түр хугацаанд бүр мөсөн зогсоох гэх мэт агаарын бохирдолд тодорхой хувь нэмрээ оруулдаг бүхий л үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээг авч байсан юм. Богино хугацаанд агаарын бохирдлыг амжилттай бууруулж чадсан тэдний амжилт ахархан байсан хэдий ч ирээдүйд “Цэнхэр тэнгэр” олж харахын тулд утааг хянахад ямар их хүчин чармайлт золиос хэрэгтэй болохыг харуулсан билээ. Хөгжиж буй орнуудын их өсөлтийг сүүдэр мэт дагадаг томоохон асуудал бол агаарын бохирдол юм. Хүмүүсийн хийсэн бүтээл нэгэн цагт дэвшил байсан бол хэзээ нэг цагт хорт зэвсэг болон хувирах нь олонтой.



http://www.mongolianeconomy.mn

Эрүүл мэнд

Хоол олдоно, ходоод олдохгүй


Х.Хулан

“Толгой өндийх завгүй сууж байна. Цайндаа гарч амжихгүй нь ээ, өнөөдөр бэлэн гоймон л идчихээс” гэдэг үг танд танил сонсогдож байна уу? Ажлын ойролцоох хүнсний дэлгүүрт орж, он сарыг нь ч сайн харалгүй бэлэн бүтээгдэхүүн хам хум авч гарах явдал хүн бүрт тохиолддог болов уу. Үдээс хойш мэйл бичиж, бичгийн ажил амжуулах зуур мөн л компьютерийн дэлгэцээ ширтсээр шоколад юм уу цайны жигнэмэг иднэ. Ингэж өдрийн хоолондоо цаг зав гаргахгүй, залгиж идсэн хоол идээгүйтэй адил үр дүнтэй бөгөөд хоолны чанарын талаар яриад ч хэрэггүй аж.

Зөв хооллолт, хүнсний аюулгүй байдал нь даяаршлын өнөө үед зөвхөн тухайн орны бус, харин дэлхий нийтийг хамарсан тулгамдсан асуудал болж байна. Дэлхийн банкны хүн амын орлогын тайлангийн дагуу, манай улс бага, дунд орлоготой орнуудын тоонд багтдаг. Гэтэл бага, дунд орлоготой орнуудын хүн амын нас баралтын шалтгааны 80 хувийг халдварт бус өвчин эзэлж байна гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/-аас мэдээлсэн байдаг. Халдварт бус өвчинд зүрх судасны өвчин, чихрийн шижин, хорт хавдар, амьсгалын замын архаг өвчлөл ордог билээ. Дээрх баримтыг сонссон хүн бүр бид яагаад ийм байдалд хүрчих вэ гэсэн бодол зурсхийх нь мэдээж. Тэгвэл монголчуудын зөв хоололтод төдийлэн анхаардаггүйн хар гай аюулын харанга дэгдээснийг дараагийн баримт илтгэх буй за.

Дэлхийн хавдар судлалын олон улсын сангаас гаргасан мэдээллийг сонирхуулъя. Учир нь, Монгол Улс улаан хоолой, элэгний хорт хавдрын өвчлөлөөр дэлхийд тэргүүлж харагдана. Түүгээр зогсохгүй ходоодны хорт хавдрын өвчлөлөөр БНСУ-ын дараа буюу удаалсан цохиж явна гээд бод доо.

Зүрх судасны өвчин, чихрийн шижин, ходоодны хорт хавдрын гол үндэс нь ерөөсөө л зохисгүй хооллолт юм байна.



Эх сурвалж: GLOBOCAN 2008 database (version 1.2) http://globocan.iarc.fr

Тэгвэл зөв бөгөөд зохистой хооллолт гэж чухам юуг хэлэх вэ? Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн “Хоол судлалын төв”-ийн ажилтан, их эмч Д.Отгонтуяагаас энэ талаар асуухад “Зохистой хооллолт гэдэг нь их энгийн. Хүн хоногт аль болох олон төрлийн, эрүүл хүнсний бүтээгдэхүүнийг өөрийн илчлэгийн хэмжээндээ тохируулж хэрэглэхийг хэлнэ. Мөн хоногийн хоолыг өглөө, өдөр, оройн гэсэн дэглэмээр хуваадаг. Өдрийн хоол нь хоногийн хоолны талаас илүү хувь нь, харин оройн хоол хамгийн бага хувийг нь эзэлнэ” гэж тайлбарлалаа. Өөрөөр хэлбэл, хүнсний бүтээгдэхүүний үндсэн таван бүлэг болох мах, гурил, сүү, цагаан идээ, жимс, хүнсний ногоо оролцсон эрүүл хүнсийг хүрэлцэхүйц хэмжээгээр хэрэглэхийг хэлж байна.

Гэтэл манай улсын хэмжээнд жимс, хүнсний ногооны хэрэглээ маш хангалтгүй байгааг 2010 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, манай улсын Эрүүл мэндийн яамны хамтарсан судалгааны тайлан харуулж байна.

- Монголын хүн ам хоногт дунджаар 1.8 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээнээс 3.2 нэгжээр доогуур байна.
- Монголын хүн амын 92.3 хувь нь хоногт таван нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байна. Тэгвэл хөдөөгийн хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээ хотынхоос хоёр дахин бага байна.

Жимс, хүнсний ногооны хүртээмж ийн тааруу байгаа нь хүмүүсийн орлогын түвшинтэй шууд холбоотойг судалгаа баталсан. Мөн хөдөө, орон нутагт жимс жимсгэнэ, хүнсний ногооны зах зээл, хүртээмж тун хангалтгүй байгаа аж. Ялангуяа жимсний хэрэглээний хувьд бүр ч таагүй үзүүлэлт гарна. Учир нь, Улаанбаатар хотод хүртэл тэнгэрт тулсан үнэтэй, ямар ч баталгаагүй жимс дэлгүүрүүдэд байдаг нь судалгаагаар тогтоогджээ. Жишээ нь, дундаж орлоготой иргэн 6500 төгрөгөөр нэг кг алим авах уу, хоолныхоо махыг авч, хоёр орой хоол хийж идэх үү гэдэг сонголтод тулж очдог. Тэгээд мэдээж монгол хүний хувьд мах нь чухал шүү дээ.

Судалгаанаас үзэхэд хүмүүсийн нас, хүйс, ажил хөдөлмөрийн онцлог зэргээс шалтгаалан хоногийн хэрэгцээт шимт бодис, илчлэг нь харилцан адилгүй байна.

Шимт бодис /нэг хоногт/

	уураг	өөх тос	нүүрс ус	илчлэг
0-1 нас	30 гр	20 гр	120 гр	890 ккал
1-4 нас	54 гр	56 гр	200 гр	1660 ккал
7-12 нас	80 гр	20 гр	300 гр	2300 ккал
14-18 нас	116 гр	100 гр	415 гр	3200 ккал

Насанд хүрэгчид, хөдөлмөрийн насны оюуны болон биеийн хүчний хүнд ажил эрхэлдэг хүмүүсийн шимт бодис, илчлэгийн харьцаа нь дунджаар хоногт 106-157 гр уураг,100-147 гр өөх тос, 374-555 гр нүүрс ус, 2900-4300 ккал илчлэг бүхий хоол хүнсийг хэрэглэх нь хүний физиологийн хэвийн хэрэгцээг хангана гэж үздэг байна.

Нүүдэлчин удамтай монголчууд мах, сүү цагаан идээ, гурил, байгалийн зэрлэг жимс хэрэглэж ирсэн. Саяхныг хүртэл хорт хавдраар өвчлөх нь харьцангуй бага байсан улс орны тоонд яахын аргагүй Монгол орж байв. Гэтэл өнөөдөр яагаад ийм гамшгийн хэмжээний өвчлөлттэй орон болсон бэ? Энэ нь нөлөөлөх олон хүчин зүйлтэй холбоотой аж. Амин чухал

http://www.mongolianeconomy.mn

бөгөөд түгээмэл шалтгаан нь суурин амьдралын хэв маяг, хүнсний аюулгүй байдал, хөдөлгөөний хомсдол юм. Одоогоос 100 жилийн өмнө дэлхийн 10 хүн тутмын хоёр нь хот суурин газар амьдарч байжээ. Тэгвэл энэ тоо 2030 он гэхэд зургаа, 2050 онд бүр 10 хүн тутмын долоо нь хот, суурин газрын оршин суугч болох урьдчилсан төлөвтэй байна. Суурин биш амьдралын хүмүүс хотжилтын нөхцөлд орж ирэхлээр тэдний хооллолт бие махбодийн хувьд зохицохгүй болдог аж.

Он	Хот, суурин газар оршин суугчдын тоо /тэрбум/
2009	3.4
2050	6.4

Эх сурвалж: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Нуугдмал хотууд” тайлан /WHO’s Hidden cities report/



Сүүлийн үед манай улсад өсөн нэмэгдэж байгаа зүрх судасны өвчин, бүх эрхтний хорт хавдар, дархлааны өвчний гол шалтгаан нь монголчуудын хоол хүнсний аюулгүй байдал, хоолны зөв зохицол харьцааны алдагдал, найрлага бүтэц нь тодорхой бус, байгалийн бус гаралтай хоол хүнс, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдолоос үүссэн таргалалт, байгаль орчны бохирдол зэрэг болж байгаа тухай УКТЭ-ийн Дотрын тасгийн ахлах зэргийн их эмч Н.Одонтунгалаг хэллээ.

Манай улсад импортын, чанаргүй хүнсний бүтээгдэхүүн ихээхэн хэмжээгээр орж ирдэг. Хүнсний дэлгүүрт ороод авах эрүүл бүтээгдэхүүн хайхад хэр олон байдаг билээ? Хугацаа хэтэрсэн махан бүтээгдэхүүн, уутан дотроо хөгцөрсөн мөөхий, гашилсан сүүтэй тааралдах нь энүүхэнд. Хүнсний аюулгүй байдлын асуудал хэдийгээр энэхүү бичиж буй сэдэвтэй уялдах ч тусгайд нь авч үзэх том сэдэв учраас түр орхиё.

Харин одоо бид дээрх дэлхийд тэргүүлээд буй өвчлөлтэй хэрхэн тэмцэх вэ гэдэг талаар хүн бүр зүтгэх, бодох хэрэгтэй болов уу. Өвчлөлтийн үндсэн шалтгаан нь зөв хооллолт, хот, суурин газрын хөдөлгөөний хомсдолтой холбоотой гэсэн мэргэжлийн байгууллагын бэлээхэн судалгаа байгаа учраас уншигч Та энэ цаг мөчөөс эхлээд өөрийнхөө буруу хооллолт, хөдөлгөөн багатай амьдралтай тэмцээрэй.

Үр дүн харах түлхүүр таны өөрийн чинь гарт буйг анхаараарай. Эх орныхоо хөрсөн дээр ургасан байгалийн баялаг болох зэрлэг жимс, хүнсний ногоо, сүү цагаан идээгээ түлхүү хэрэглэж хэвшицгээе. Эрүүл мэндийн асуудал тогтвортой хөгжлийн нэг хэсэг мөн. Гэхдээ энэ нь эдийн засгийн өсөлт бус, харин зөв хооллолтоос эхэлнэ. Зохистой хооллох эсэх нь тэгвэл Таны эрүүл мэнддээ хандах хандлага юм. “Хоол олдоно, ходоод олдохгүй” гэдэг үг байдаг бус уу. ■

http://www.mongolianeconomy.mn

Зөвлөгөө

Утаанаас эрүүл мэндээ хэрхэн хамгаалах вэ

Утааны асуудал үндэсний шинжтэй болоод байгаа энэ үед иргэд эрүүл мэндээ хэрхэн хамгаалах вэ гэдэг чухал болоод байна. Тэгвэл ахуйн хэмжээнд эрүүл мэндээ хэрхэн хамгаалж болох талаар танд Анагаах ухааны доктор, профессор, харшил дархлаа судлаач эмч Ж.Соёл-Эрдэнэ зөвлөж байна.

Хайртай гэдгээ зөв илэрхийл

Аав, ээжүүд гаднаас орж ирээд л гадуур хувцсаа ч тайлж амжилгүй угтан гүйж ирэх үрсээ дээр өргөн тэвэрч, үнсдэг. Энэ нь нэг талаар эцэг эхийн хайр энхрийллээ илэрхийлэх арга, халуун дотно уур амьсгал бүрдүүлж буй чухал хүчин зүйл боловч утааны асуудал гамшгийн хэмжээнд хүрчихсэн энэ үед “гаж” зуршил гэнэ. Учир нь, гадна орчны агаарт азот, хүхэр, метан, хар тугалга гээд эрүүл мэндэд хортой бодис хэвийн хэмжээнээс их байгаа талаар өдөр бүр л мэдээлж байна. Эдгээр нь хүнд бодисын тоонд ордог бөгөөд аливаа биет дээр наалддаг. Бага насны хүүхдийг тэвэрч явах талаар зөвлөмж гарсныг Та санаж байгаа байх. Энэ нь хүнд бодистой холбоотой юм. Учир нь, хүнд бодис газрын хөрснөөс нэг метр орчмын зайд байдаг. Эдгээр нь агаарын урсгалын хөдөлгөөний үед дээш дэгддэг. Тиймээс гаднаас орж ирэхэд хувцас, гар, нүүр гээд ил хэсгүүд дээр хортой бодис наалдсан байдаг байна. Ийм учраас ажлын хувцсаа сольж, гар нүүрээ угаасны дараа хүүхэдтэйгээ тоглож наадаж, хоол ундаа идэх хэрэгтэй.

Баяр ба дархлаа

Олон жил ажилласан эмч хүнд өвчтөнүүдийн дунд зарим нэг сонирхолтой зүйл цөөнгүй ажиглагддаг байна. Түүний нэг нь томоохон уламжлалт баярын өмнөх 14 хоног болоод баяр үргэлжилж, дуусах хүртэлх хугацаанд эмнэлэгт хандах хүний тоо огцом буурдаг. Үүнийг шинжлэх ухааны талаас тайлбарлавал, дархлааны системтэй холбоотой. Хүн ямар нэг зүйлд анхаарлаа хэт төвлөрүүлэхээр дархлаа тэр зүгт ажиллаад эхэлдэг. Тухайлбал, төгсөх шалгалтад бэлдэж байгаа оюутан зөвхөн шалгалтдаа санаа зовж, онц сайн өгөхийн төлөө мэрийдэг. Яг тухайн үед хамрын ханиад ч хүрэх нь ховор. Харин шалгалтаа өгчихөөд санаа амарсны дараа ханиад хүрэх, нүүрэн дээр юм гарах зэрэг тохиолдол гарах нь элбэг. Яг л үүнтэй адил бид үндэсний хэмжээний томоохон баярын өдрүүдэд хэдэн төгрөг хаанаас олох вэ, түүнийгээ хэрхэн хүргэх вэ гэсэн олон асуултад дарагдаад эрүүл мэндээ умартдаг. Энэ үед дархлааны систем хэт ачааллана. Харин дараа нь таны эсэргүүцэл “нойл” зааж хууч өвчин сэдэрч эсвэл ямар нэг байдлаар эрүүл мэндийн сөрөг үр дагавар илэрдэг. Агаарын бохирдолтой энэ үед амьсгалын замаар дамжин хортой бодис эсэргүүцэл суларсан эс дээр очоод үрэвсүүлэх нь бий. Тиймээс Та ганцхан зүйл дээр хэт төвлөрч стресст оролгүй зарим тохиолдолд тархи болоод бие мах бодио амраж байх нь чухал. Хэт их ажилладаг бол долоо хоногтоо ядаж ганц удаа агаарт гарах, найз нөхөдтэйгөө ярилцах гээд цагийг үр бүтээлтэй өнгөрөөх нь эрүүл мэндэд тустай.

Цагаан сар ба ханиад

Удахгүй Цагаан сар болох нь ээ. Хүн бүр айл хэсч, “алт мөнгө” цуглуулах нь энэ баярын утга учир гэхэд хэлсдэхгүй. Гэхдээ агаарын бохирдол аюултай түвшинд очсон энэ үед гадуур явах нь тийм ч таатай зүйл биш. Дээр хэлсэнчлэн доор байгаа хортой, хүнд бодисууд эрчимтэй хөдөлгөөний үед агаарт дэгддэг. Энэ үед хэн илүү их хорддог вэ гэхээр хүүхдүүд. Хортой бодис агаарт дэгдэхдээ хамгийн ойр байгаа амьсгалын замаар их хэмжээгээр нэвтрэх нь мэдээж.

Мөн авто машины дутуу шаталтын хөдөлгүүрээс гарах утаа хамгийн аюултай. Ер нь Цагаан сар гэлтгүй агаарын бохирдолтой өнөө үед гадуур алхах нь тийм ч сайн биш. Урд нь хотоор зугаалах нь эрүүл мэндэд эм болдог байсан бол одоо хор болдог болсон. Харин долоо хоногтоо хотоос зайдуу агаарт гарч байх нь хамгийн чухал юм.

Хамгийн зөв хувилбар

Бид гэртээ өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийж, агааараа ямар нэг аргаар цэвэршүүлж байх хэрэгтэй. Гэхдээ манай эзэгтэй нар цэвэрлэгээ хийхдээ хлорамин, белизна гээд цэвэрлэх бодис ихээр хэрэглэдэг. Агааараа цэвэрлэхийн тулд агаар цэвэршүүлэгч бодис цацдаг. Эдгээр нь буруу юм. Учир нь, гадаах агаарт байгаа хортой бодисууд эдгээр цэвэрлэх бодистой нэгдсэнээр урвалд орж эрүүл мэндэд илүү хортой нөхцөлийг бий болгож болно. Тиймээс цэвэр усаар угаасан алчуураар цэвэрлэгээ хийх нь зөв. Агаар цэвэршүүлэхдээ ч мөн адил аль болох химийн ямар нэгэн бодис ашиглахаас зайлсхийх хэрэгтэй.


“Нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох” вий

Сүүлийн үед хүмүүс ханиад тусах нь их болсон. Гэтэл өнөөдрийн ханиад бидний мэддэг нян, вирусын гаралтай биш. Ихэвчлэн дархлаа суларсан эсийг агаарт байгаа хортой бодис өрөвсүүлж, өрөвслийн шинж тэмдэгтэй байгаа юм. Гэтэл манайхан вирусын гаралтай антебиотек уугаад л эдгэрчихдэг ханиадтай зүйрлээд дур мэдэн эмээр бөмбөгддөг. Энэ нь “нуухыг нь авах гээд нүдийг нь сохолж” байгаа хэрэг юм. Хамгийн наад зах нь буруу эм хэрэглээд байвал тухайн өвчнийг үүсгэгч улам “хүчирхэгжиж” хэр баргийн эмчилгээнд дийлдэхээргүй болчихдог. Тэгээд л өвчин хүндэрч зарим тохиолдолд өөр төрлийн өвчлөл бий болох үндсийг ч тавьж болно. Тиймээс Та ямар нэг өвчин туссан бол даруй мэргэжлийн эмчид хандах нь зүйтэй. Эмийн зохисгүй хэрэглээ хэзээ ч сайн үр дагавар авчирдаггүйг сана.

Изинис Эйрвэйз



Цагаан сарын урамшуулал



Азай буурлуудаа амжиж очоод золгоорой.

"8 Зовхис" билдинг, 1-р давхар, Сөүлийн гудамж
Улаанбаатар хот-14251, Монгол улс, Ш/х-2757
Утас: (976-11)-333311, Факс: (976-11)-331514
И-мэйл: info@eznis.com

Туулах тэнгэр цэлмэг
Тухлах зорчигч амгалан

333311
www.eznisairways.com



Packaging quantity of Pure water:
0.35 L /bottled/
0.6 L /bottled/
1 L /bottled/
19 L /ballon/

Маркетинг: 99071655
Захиалга авах утас: 70173386
Факс: 976-11-70174494

Produced and bottled by " Welmon Trade " Co.,Ltd of Mongolia

ТОД ТАМГА

БИШИРТҮГЭЙ! АЮУТУГАЙ!



ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРТ!

Утас: 91919499, 323454 www.todtamga.mn
Хаяг: ЧД, Татварын Ерөнхий газрын ард
“ТОД ТАУЭР” оффис, 101 тоот
Утас: 98907234

САЛБАРУУД:

Баруун 4 зам	**Утас: 98626587 todtamga2@yahoo.com**
Зуун айл	**Ута: 98907912 todtamga1@yahoo.com**
Түгээмэл	**Утас: 98630499 todtamga3@yahoo.com**

http://www.mongolianeconomy.mn



Сурталчилгаа

Банк санхүүгийн академитай танилц

Монголд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкууд болон банк бус санхүүгийн компаниуд нь зах зээлд нийцтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахын тулд банк санхүүгийн мэргэжилтнүүдийнхээ ур чадварыг дээшлүүлэх сургалтын хэрэгцээ нэмэгдэж байна. Мэргэжилтнүүд нь олон улсын стандартыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлдэг ур чадвартай болох хэрэгтэй байна. Ингэснээр Монгол Улсад энэ чиглэлийн сургалт, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны эрэлт ихэслээ.

Монголын банкны холбоо болон Банк бус санхүүгийн байгууллагын холбоо нь 2009 онд USAID-ийн “Эдийн засгийн шинэчлэл” төслийн санхүүжилтээр санхүүгийн зах зээлийн сургалтын эрэлтийн судалгаа хийсэн билээ. Энэхүү судалгаанд гарсан үр дүн дээр үндэслэн Банк санхүүгийн академийг 2010 оны арванхоёрдугаар сард Монголын арилжааны банкууд хувь нийлүүлэн байгуулсан бөгөөд 2012 ны нэгдүгээр сард бөгөөд 2012 оны нэгдүгээр сарын 1-нээс Монголбанкны дэргэд үйл ажиллагаа явуулж байсан Банкны сургалтын төв албан ёсоор Банк санхүүгийн академид нэгдсэн билээ.

USAID-ийн санхүүжилттэй “Бизнесийн санаачлагыг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд “Зээлийн эдийн засагчийг хөгжүүлэх 25 модуль хөтөлбөрийн боловсруулсан болно.

Банк санхүүгийн академи нь бие даасан, Монголын банк санхүүгийн салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, техник ур чадварыг сайжруулах үйлчилгээ үзүүлэх зорилготой, сургалт, зөвлөгөө өгөх байгууллага билээ. Банк санхүүгийн салбарын мэргэжилтэн, удирдах ажилтнууд сургалтын хөтөлбөрийг хүргэж мэргэшсэн гэрчилгээ олгож ажиллана.

Банк санхүүгийн академи нь Монголын санхүүгийн салбарын мэргэжилтнүүдийг мэргэжлийн стандарт шаардлагыг хангасан ур чадвартай болгон мэргэшүүлж дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай болгох зорилготой байгууллага билээ.

Зээлийн эдийн засагчийг хөгжүүлэх хөтөлбөр” нь Банк санхүүгийн академийн үндсэн хөтөлбөрүүдийн нэг бөгөөд “Суурь хичээлүүд”, “ Ахисан түвшин”, “Гүнзгийрүүлсэн түвшин”, “Сонголт хийх мэргэшсэн” гэсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй, 10 долоо хоногийн туршид хагас цагаар үргэлжлэх юм. Энэхүү хөтөлбөр нь Банк санхүүгийн академи дээр 2012 оны гуравдугаар сараас эхлэх гэж байна.

Банк санхүүгийн академи нь санхүүгийн салбарын төлөөлөл болсон долоон хүний бүрэлдэхүүнтэй удирдах зөвлөлтэй бөгөөд удирдах зөвлөлд гурван жилийн хугацаагаар сонгогддог. Тус байгууллагын гүйцэтгэх захирлаар бичил санхүү, сургалт судалгааны чиглэлээр олон жил ажилласан ажлын туршлагатай С.Нэргүй томилогдон ажиллаж байна.

Байгууллагын тухай илүү тодорхой мэдээлэлийг www.bfa.mn цахим хуудаснаас авч болно.

Зээлийн эдийн засагчийг хөгжүүлэх хөтөлбөрийн онцлогууд

- Хөтөлбөрийг олон улсын банк санхүүгийн стандарт жишигт нийцүүлэн боловсруулсан
- Банк санхүүгийн мэргэшсэн ажилтан болоход шаардлагатай мэргэжлийн суурь ойлголтуудыг бүгдийг нэг дороос авах боломжтой.
- Хөтөлбөрийг амжилттай суралцаж төгссөнөөр Монголын банк санхүүгийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн “Мэргэшсэн санхүүгийн ажилтан” / Certified Financial Professional/ болох боломжтой.
- Хөтөлбөрийн хуваарь нь оройн цагаар болон амралтын нэг өдөрт явагдахаар хийсэн тул ажилламгаа сурах боломжийг бүрдүүлж байгаа болно. 40 кредит цагийг бүрдүүлэхийн тулд долоо хоногт 24 цаг хичээллэн 240 танхимын цагийн сургалтад хамрагдана.
- Хөтөлбөрийн үндсэн мэдээлэл, мэдлэг дээрээ үндэслэн Accredited Valuation Analyst (AVA), Certified Bank Auditor (CBA), Certified Financial Examiner (CFEx), or Certified Financial Services Auditor (CFSA) гэх мэт олон улсын санхүүгийн мэргэшсэн ажилтны шалгалтуудыг өгөх боломжтой.
- Сургалтыг банк санхүүгийн мэргэшсэн ур чадвартай багш оролцооны аргаар, жишээ баримтад тулгуурлан заана. ■

http://www.mongolianeconomy.mn



Хуримтлал

Аадар бороо ган тайлдаггүй

Нэгэн өсөлтөөс өөр нэг бууралт руу

АНУ яагаад Иракаас гарсан бэ?

Гэрэл зөөгч

Б.Баяртогтох

Улс орны амьдралд урин цаг наашилж байна. Ханзрах цас, анхны яргуйтай уралдан говийн бүтээн байгуулалт эрчимжинэ. Энэ хэрээр эдийн засаг хурдасна. Баялгийн шимийг энэ тэнцүүхэн хүртэж, хөгжлийн галт тэргийг урагш зүтгүүлэх таатай боломж монголчуудад ирээд байгаа нь хаврын дохио буй за. Оюутолгой, Тавантолгойгоос олох хэтийн ашгийг хэрхэн зөв зарцуулахыг Монгол толгой л мэдэх учиртай. Тэгвэл бидэнд ямар эрсдэл, ямар боломж байна вэ?

МУИС-ийн ЭЗС-ийн багш, судлаач, эдийн засагч Б.Эрдэнэбат “Гадаадын хөрөнгө оруулалт манайд хувин хувингаар цутгаж байгаа нь сайн боловч эдийн засагт сөрөг нөлөө дагуулж байна. Энэ л ирээдүйд бидэнд толгойны өвчин болж мэдэх юм” хэмээн дүгнэсэн. Нэг үгээр хэлбэл, аадар бороо ган тайлдаггүй болохыг тэрбээр ийнхүү тайлбарласан хэрэг.

Дуутай тэнгэр хургүй гэдэг шиг цуутай хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгоогүй тохиолдолд түүнийг хөрөнгө оруулалт гэж үзэхэд бэрх аж. Тиймээс уул уурхайн салбараас олсон орлогоо Тогтворжуулалтын сандаа нэмэрлээд байх нь эдийн засгаа хамгаалах зөв санаа гэдгийг эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарын учир мэдэх хүмүүс хэлж байгааг энд тэмдэглэе. Эдийн засагч Эрдэнэбатын хэлснээс үзэхэд аадар адил асгарах хөрөнгө оруулалт эргээд эрсдэл бий болгох аж. Тиймээс өнөөдрийн хөрөнгийг хэрхэн чулуу болгох вэ? Хөрөнгө оруулалт гэсэн хүндлэм нэрний дор эдийн засгийн албин чөтгөрүүд байдгийг Жон Перкинсийн “Эдийн засгийн алуурчны наминчлал” номонд өгүүлжээ. “Гадаадын хөрөнгө оруулалт өсөж байгаа нь сайн үзэгдэл боловч зөвхөн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт давамгайлж байна. Гэтэл дэд бүтэц, боловсрол, шинжлэх ухааны салбарт дорвитой хөрөнгө оруулалт алга” хэмээн Монголбанкны Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны

http://www.mongolianeconomy.mn

хэлтсийн дарга С.Болд тэмдэглэсэн юм. Хөрөнгө оруулалтын чанарыг шалгах тухай шинэ санааг эдийн засагчид хэлж байсан. Товчхондоо манай улс руу цутгаж буй хөрөнгийн урсгалыг алга тосоод суух нь таатай үзэгдэл хэдий ч цаана нь цөөнгүй асуудал оршиж байна. Латин Америк, Ангол, Нигер, Судан, Боливи ч гэсэн манайхаас дутахгүй асар их баялагтай. Гэтэл тэнд амьдрал улам л дордсоор.

Төвбанкны мэдээгээр манай улсын гадаад худалдааны эргэлт өнгөрсөн оны жилийн эцэст 11.3 тэрбум ам.доллар хүрч, 2010 оныхоос 83.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Монголын эдийн засаг туйлын өрөөсгөл, харахад ч зүрхшээмээр ” гэж хэлсэн нь бий. Статистик тоо харахаар экспорт, импортын хэмжээ үнэхээр гайхмаар өндөр өсөлтийг үзүүлж байна. Харин хөрөнгө оруулалт дагасан Голланд өвчин, баялгийн хараалтай бид нөхөрлөж явна уу. Үүнд бол тийм л гэсэн хариултыг эдийн засгийн сургуулийн багш нар өгч байлаа. Учир нь нөөцийн хараал бол маш энгийн өвүүхэн зүйлээс эхэлдэг аж. Чухамхүү ядуу эдийн засагтай орнууд л баялгийн хараалд ихэнхдээ өртдөг байна. Харин Чили, Ботсван, Норвегийн амжилт нь сангийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэнд байна.

Манай улсын баялгийн сангийн хүлээгдэж буй үнэлгээ нь 2043 онд 30 тэрбум ам.доллар буюу 40 их наяд төгрөг байна хэмээн “Оюутолгой зэсийн ордын ашиглалт, Монголын макро эдийн засгийн үр дагаврын үнэлгээ” судалгааны бүтээлд тамаглажээ. Нэг үгээр хэлбэл, өнөөдрийн эдийн засагт цутгаж буй “мөнгөний цунами”-г сангийн бодлогоор л бодит баялаг болгон хувиргах учиртай юм байна. Тэгж чадвал засаглал тунгалаг, эдийн засагт ямар нэгэн өвчний шинж тэмдэггүй байх ажээ. Одоогийн хөрөнгө оруулалтын хэмжээ “Монголын тогооноос хэтэрчихсэн болов уу гэж бодогдох юм” хэмээн УИХ-ын гишүүн Р.Амаржаргал хэлжээ. Гэхдээ бүтээн байгуулалт, хөгжил далласан Оюутолгой шиг төсөл хөтөлбөрүүдээс сайн мэдээ сонсоно гэдэгт эдийн засагчид эргэлзэхгүй байна. Тогоогоо томруулж, тос өөх багатай хоол хэрэглэхийг эмч нар ч зөвлөж байгаа шүү дээ.

Хөрөнгө оруулалт нэмэгдэж буй өнөө үед сангийн бодлого чухал болохыг СЭЗДС-ийн багш, доктор, профессор Ц.Батсүх онцлоод, ихэнх улс орнууд аль нэг ашигтай салбараасаа хөрөнгө саахын зэрэгцээ Сангийн бодлогыг давхар хэлэлцүүлдэг. Энэ нь хэт их хөрөнгө оруулалтаар эдийн засагтаа эмх цэгцгүй байдал үүсгэхээс болгоомжилдог гэлээ. Санхүүжилт, хуримтлал, тогтворжуулалтын сангийн аль нэг нь улс оронд заавал байх шаардлагатай болохыг тэрбээр нэмж хэлсэн. Сангууд нь дотроо эрүүл мэнд, боловсрол гээд мод мэт мөчирлөх шинэ тогтолцоо манайд үгүйлэгдэж байгааг ч хэлсэн.

Засгийн газраас Тогторжуулалтын санг байгуулсан хэдий ч Тогтвортой байдлын тухай хууль ирэх онд хэрэгжих учраас сангийн бодлогод саад мундахгүй нь. Шавхагдаагүй баялгийн үнэ жил ирэх тусам өсөж байна, бас дэлхийн эдийн засгийн хямралыг дагаад унаж байна. Тэгвэл Оюутолгой хэмээн том төслөөс монголчууд олон зүйлийг хүлээж байгаа билээ. Цаашид Оюутолгойн бүтээн байгуулалт эрчимжиж, Тавантолгой нүргэлнэ. Уул уурхайн салбарт авч хэрэгжүүлж буй бодлогоо эргэж харах ёстой хэмээн эдийн засагч Түвшинтөгсийн ярьсныг уламжилъя. Бүгдийг зэрэг олборлож эхлэх нь зөв үү гэсэн асуултыг улстөрчдөд тэрбээр тавьж байв.

Манайд бий болгосон хуримтлал тун хомсхон. Тиймээс хөрөнгө оруулалт орж ирэхдээ Монголын шилдэг сор нь болсон бүхнийг түүж авч байгаа нь харамсалтай. Хэдий эдийн засагт хамгаалалт далан байлаа гээд хавтгай дэлхийд орж ирсэн хөрөнгийг алдах эрсдэл энүүхэнд. Учир нь, манай эдийн засаг хэтэрхий жижиг байгаад бас учир байгаа ажээ. Үйлдвэржилт, импортод гаргах эцсийн бүтээгдэхүүн тун ядмаг байгаа нь улам бүр эдийн засагчдын итгэлийг гонсойлгож байгаа нь харамсалтай. Хөрөнгө мөнгөний урсгал нь тогтоол ус биш юм байна. Хөрөнгө оруулагчид Улаанбаатарт уван цуван ирцгээх болов. Үр дүнд нь манайх руу татсан хөрөнгө оруулалтын суваг шуудуу улам өргөсөж буй билээ. Аадар бороонд ус урсаад л өнгөрнө шүү дээ. ■

Монгол Улсын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал

Монгол Улсын нийт хөрөнгө оруулалт сүүлийн 10-аад жилийн хугацаанд харьцангуй тогтвортой өсөж, ДНБ-ий 30-40 хувьтай тэнцэх түвшинд хэлбэлзэж байна. Нийт хөрөнгө оруулалтад дотоодын хөрөнгө оруулалт 40 хувийг, гадаадын хөрөнгө оруулалт 60 хувийг эзэлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг дотор нь гадаадын шууд хөрөнгө оруулалт ба бусад, дотоодын хөрөнгө оруулалтыг дотор нь улсын төсвийн хөрөнгийн зардал ба бусад гэж ангилдаг. Хөрөнгө оруулалтын 50-55 орчим хувийг тоног төхөөрөмж, 25-30 хувийг барилга угсралт, 15-20 хувийг бусад зүйлд зарцуулж байгаа аж.

Дотоодын хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байна. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн зардлын хэмжээ 2010 онд 664,3 тэрбум төгрөгөөр батлагдсан нь өмнөх онтой харьцуулахад 38 хувиар өсчээ. Харин 2011 онд хөрөнгийн зардлын хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад бага зэрэг буурсан буюу 627,7 тэрбум төгрөгөөр батлагджээ.

Эх сурвалж Сангийн яам, www.iltod.gov.mn

http://www.mongolianeconomy.mn



Ч.Отгочулуугийн булан

Нэгэн өсөлтөөс өөр нэг бууралт руу

Монгол Улсын эдийн засаг өнгөрөгч онд 17.3 хувиар өссөн нь дэлхийд гайхуулахаар өндөр үзүүлэлт болов. Харин 2012 онд эдийн засаг бодитоор 25 хувиар өсөх магадлалтай байна. Уул уурхай хүчээ авч, барилгын ажил ундарч, гудамж талбайд автомашин түгжрээд л. Гэвч суурь дэд бүтэц маань зогсонги хэвээрээ.


Нэгэн жишээ нь бензиний асуудал. Сүүлийн 10 жил суудлын машины тоо Улаанбаатарт хэдэн хувиар өсөв. Үүний адилаар, уул уурхайн салбар дахь хүнд машин механизмын тоо хэд дахин нэмэгдэв. Тэгвэл эдгээр төмөр хөлгүүдийн “хоол” буюу шатахуун импортлох, тээвэрлэх боломж хэр нэмэгдэв. Сүүлийн жилүүдэд төмөр зам, хил, боомт дээр дорвитой хөрөнгө оруулалт хийгдэв үү? Үгүй. Нийлүүлэлт буюу гаднаас л импортолдог сувгийн боломж зогсонги байхад эрэлт эрс хүчтэй нэмэгдэж байна. Үүний үр дүнд бензиний үнэ гаарлаа. Улстөрчид ч яахав хэдэн агентлагийн даргыг сольсноор, эсвэл сонгууль уггаж үнийг хүчээр барих оролдлого хийснээ их юманд бодож тайвширч байх шиг байна. Ард түмэн ч үнийн өсөлтөд хэсэг бухимдаад одоо эвлэрч эхлэх шиг.


Өөр нэг жишээ буюу Орон сууц. Орон сууцны үнэ гаарлаа гэх. Уг нь бол шинээр ашиглалтад орж буй орон сууцны хорооллууд өдөр ирэх тусам нэмэгдэж байна. Зах зээл дээр үнэ тогтох хуулиар бол байрны үнэ унамаар. Гэвч үгүй. Улам бүр нэмэгдсээр. Нэг талаас гадаад, дотоодын бэл бэнчинтэй иргэд орон сууцыг мөнгөө өсгөх хөрөнгө оруулалт гэж хараад байх шиг. Тэд бүр орц орцоор нь худалдаж аваад байргүй иргэдэд өндөр үнээр түрээсэлж ашиг олдог гэх. Эднээс татвар авдаг механизм гэж алга нь амар ч юм шиг. Эсвэл зарим нэг улстөрчдийн үзэж байгаагаар, мэргэн, өгөөмрөөрөө алдартай төр маань бэлэн мөнгө тараагаад иргэд маань баяжсан учир эрэлт нэмэгдээд ч байх шиг. Харин эдийн засагчийн нүдээр харахад, орон сууцны үнийн хөөрөгдөлд яг ямар хүчин зүйл нөлөөлөөд буйг хэлэхэд улам бүр түвэгтэй болсоор байна. Мэдээж хамгийн бодитой нэг шалтгаан бол барилгын материалыг татах, нэвтрүүлэн өнгөрүүлэх дэд бүтцийн хөгжил сул байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, мөнгөтэй хүмүүсийн тоо өсөөд, эсвэл цөөхөн мөнгөлөг хүмүүсийн бэл бэнчин зузаараад байдаг, гэтэл нөгөө талд нийлүүлэлтийн маань боломж хэвэндээ үлддэг.

Дээрх хоёр жишээнд нэг нийтлэг төрх байна. Энэ нь нийлүүлэлтийг дотоодоос эсвэл гадаадаас хангахад дэмжлэг болдог суурь дэд бүтэц хөгжихгүй байгаагаас инфляци өсч ард иргэд хохирч байна. Баян хоосны ялгаа ч улам гаарах нь.

Гэвч энэ хоёроос ч дутуугүй нэгэн гамшиг, эдийн засгийг элгээр нь хэвтүүлэх нэгэн аюул чимээгүйхэн өсч томорч байна. Энэ аюулыг улстөрчдын олонх нь мэднэ. Гэвч тэд энэ асуудлыг хөндсөнөөрөө түрүүлж дуугарсан хөхөөний ам хөлдөхийн үлгэрээр сонгогдох боломжоо булшилна гэдгээ сайн мэдэх учир амаа хамхидаг юм. Магадгүй ард түмний төлөө, хөгжлийн төлөө гэх улстөрчид бэлэн мөнгө амлах хялбар замаар ялах гэж л шүлэнгэтдэг учир тэднээс эдийн засгийн ирээдүйн төлөө өөрсдийн улс төрийн нэр нүүрээ золиослох (“кариерээ жертв хийх”) эр зоригийг хүлээх нь гэнэн хэрэг байж болох юм.

Энэ аюул юу вэ? Энэ бол Эрчим хүч буюу цахилгаан, тог, дулаан. Монголчуудын хувьд эрчим хүч буюу хамгийн чухал дэд бүтэц хэмээх энэ салбарт гурван том бэрхшээл нэгэн зэрэг учирч байна. Нэгдүгээрт, ирэх он жилүүдэд Улаанбаатарын иргэд нэгэн жигд тогтой, дулаантай байж чадах уу? Хоёрдугаарт, нүүрс хүчлийн хий болон утааны асуудлыг хэрхэн шийдэх вэ?





http://www.mongolianeconomy.mn

Гуравдугаарт, төр үйлдвэрлэгч юм уу, зохицуулагч юм уу гэдгийг таньж мэдэх болно.


Төвийн эрчим хүчний системд холбогдсон Дулааны цахилгаан станцуудын маань тог үйлдвэрлэх даац нь 800 орчим мегаВатт гэж тооцогддог. Улаанбаатарыг оруулаад эрчим хүчний хэрэглэгч нарын хэрэглээ ч энэ орчим. Гэвч уул уурхайг дагасан эдийн засгийн эрчимтэй өсөлт энэ хэвээр үргэлжилбэл, ирэх таван жилд эрчим хүчний эрэлт хоёр дахин өсөх нь. Ойрын жишээ татахад л ашиглалтад шинээр орж буй орон сууцны хорооллуудаа харахад хангалттай. Үр дүнд нь дулааны цахилгаан станцууд илүү их нүүрс шатааж, импортлогчид хойд хөршөөс илүү их түлш, шатахуун худалдаж авах болох нь. V цахилгаан станц, 300 мегаВатаас дээш хүчин чадал бүхий усан цахилгаан станц гэж төр олон жил ярилаа. Гэвч төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу, чадавх сул зарим үед улс төр-бизнесийн бүлгүүдийн зөрчил тэмцлээс болж томоохон бүтээн байгуулалтууд хоосон яриа болж үлдсээр байгаа юм.

Монгол Улсын өрсөлдөх чадварын төвөөс хийсэн асуулгад оролцогчид агаарын бохирдол эдийн засагт асар муу нөлөө үзүүлж буйг онцолсон байсан. Жилд хэдэн тонн хүлэмжийн хий ялгаруулж байна вэ гэдэг үзүүлэлтээрээ Монгол Улс гайгүй юм шиг харагддаг. Ердөө 2.7 сая хүн амтай улс юм чинь аргагүй. Харин нэг хүнд ногдох хүлэмжийн хийн хэмжээгээр бол хэдийнэ SOS зарлах түвшинд хүрчээ. Нэг сая ам.долларын ДНБ үйлдвэрлэхэд ялгаруулж буй нүүрсхүчлийн хий гэх ойлголт байдаг. Үүгээр Монгол Улс 2,168 тонн гэсэн үзүүлэлтээр мөн л хамгийн сүүлийн байрт орчихсон явна. Манайхтай ижил шилжилтийн үеийг даван туулсан Украин, Казахстан, ОХУ хүртэл нэг сая ам.долларын ДНБ үйлдвэрлэхдээ Монголоос даруй 450-1,000 тонн бага хүлэмжийн хий ялгаруулдаг аж.

Улаанбаатар хот агаарын бохирдлоороо дэлхийд “манлайлах” болов. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар нэг шоо метр агаар дахь бохирдлын хэмжээ 20 миллиграммаас дээш гарах нь хүний эрүүл мэндэд хортой байдаг бол Монголын нийслэлд энэ хэмжээ 279 миллиграмм буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэдийнэ 14 дахин давжээ. Тэгэхээр эдийн засгийн өсөлт иргэдийн эрүүл мэндэд заналхийлээд ч байгаа юм шиг.



ДНБ-ийн нэг сая ам.доллар бүрд ногдох нүүрс хүчлийн хийн ялгарал /тонноор/



Нүүрс хүчлийн давхар исэл /тонноор/

Эх сурвалж: Өрсөлдөх чадварын төв

Монголчуудын хувьд эдийн засгийн өсөлтөөс хорт хий буюу нүүрс хүчлийн хийн бууралт руу шилжих зайлшгүй шаардлага нэмж тулгараад байна. Дулаантай, тогтой байхаас гадна эрүүл агаар гэсэн шинэ бэрхшээл нэмэгдсэн нь аанай л дэд бүтцийн сул хөгжлийн гор гарч байгаагийнх билээ.

Энэ нь юуны түрүүнд манай эрчим хүчний хэрэгцээний 80 гаруй хувийг хангаж байгаа “социализмын үеийн” цахилгаан станцуудын элэгдэж хуучирсан, үр ашиг багатай техник, технологийн гай. Шинэ бүтээн байгуулалт болж, бүх асуудлыг шийдэх учиртай V цахилгаан станцын сураг дуулдсаар л байна. Улстөрчдийн үл ойлголцол, төр, засгийн тогтворгүй байдал, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу, бие биедээ гох дэгээ тавьдаг “сайхан” уламжлал нь ч “үр дүнгээ өгсөөр” байгаа юм. Гэтэл гаднын нэг компани Чандганы талд “дугаар 5”-аас дутуугүй станц барина гэдгээ зарлачихлаа.

Энэ үйл явц төрд том дохио болсон гэдэгт найдна. Төр эрчим хүчний салбарт гол тоглогч бас гол зохицуулагч байсаар ирсэн. Гэвч хэрэглэгчид айдастай байна. Тэд Монголынхоо эрчим хүчний салбарт итгэхгүй байна. Энэ итгэлийг төр хэрхэн сэргээх вэ? Магадгүй хувийн хэвшлийхэнд боломж олгох хэрэгтэй бус уу? Түүхий нүүрс экспортлон олж буй мөнгөнөөс тодорхой хувийг эрчим хүчний салбарыг зах зээлийнх нь голдиролд шилжүүлэхэд зарцуулах учиртай.

Мэдээж энд цаг үеийн онцлог гэж байна. Эдүгээ Монгол Улс гурван ч шилжилтийг нэгэн зэрэг хийж байгаа онцгой үе юм. Нэгдүгээрт, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос чөлөөт зах зээлд, хоёрдугаарт, импортоос хараат байдлаас экспортод чиглэсэн бүтцэд, хүлэмжийн хий ихтэй нийгмээс хүлэмжийн хий багатай “эрүүл” нийгэм рүү шилжиж байна.

Иймд, зөвлөлт маягийн зохицуулалтын системээ хадгалж үлдсэн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх салбарт либеральчлалыг цаг алдалгүй яаралтай эхлүүлэх шаардлагатай байна. Дээр нь хэрэв төр чаддагүй юм бол, чаддагт нь эрхийг нь өгөөд, хамгийн гол нь найдвартай, “итгэл даах” эрчим хүчний зах зээлийг цогцлоох нь зүйтэй. Харин нүүрс хүчлийн хийг бууруулах гарц бол дэвшилт технологи. Энэ технологи үнэтэй бас эрсдэл ихтэй. Энэ эрсдэлийг бууруулах санхүүгийн хөшүүргийг түүхий нүүрсний экспортын орлогын багахан хувиар бүрдүүлэх боломжтой.

Эдийн засгийн өсөлтөөс хүлэмжийн хийн бууралт руу шилжих талаар санал бодлоо хуваалцахад ийм байна. ■



Улаанбаатар хот. Сонгинохайрхан дүүрэг

Фоторг Б.Бямба-Очир

http://www.mongolianeconomy.mn

Үзэл бодол

АНУ яагаад Иракаас гарсан бэ?



С.Одонтуяа /Эдийн засагч/

Нефтийг тойрсон том улс төр

Хүн ам өсөхийн хэрээр эрчим хүчий хэрэглээ геометрийн прогрессоор өсдөг гэдэг. Жишээ нь: Хүн ам хоёр дахин өсөхөд эрчим хүчний хэрэглээ дөрөв дахин нэмэгдэнэ гэсэн үг. Иймээс дэлхийн эрчим хүчний том бодлого руу анхаарлаа хандуулцгаая.

Дэлхий ертөнц цоо шинэ эрчим хүчний нөөцтэй, шинэ технологитой болж, дэвшлийн эргэлтийн цэг дээр ирээд байна. Бид нүүрстэй болсон нь үүлэн чөлөөний нар шиг үзэгдэх аз, алдаж болохгүй атгаж авах үе юм. Гэвч шинэ технологи дэлхийн эрчим хүчний газрын зургийг дахин өөрөөр зурах боллоо. Норвегийн хойд хэсэг Арктикийн хүйтэн далайгаас Аргентины Патагони хүртэл, өрнөд Канадаас Анголын эрэг хүртэл нефть болон байгалийн хийн асар том шинэ ордуудыг шинэ технологиор ухаж, шахаж, өремдөж байна.

АНУ хөрш Канадаас нефть, байгалийн хийн ордын асар их нөөц олсон болохоор холын Ирак, Афганистанд тэнэгтэх хэрэггүй болж, цэргээ татаж дуусч байна.“Нефть олно гэдэг чухал, харин Канад шиг амгалан тайван, найдвартай хөрш нефтьтэй болно гэдэг шал өөр хэрэг” гэж АНУ-ын “Эксон Мобил”-ийн тэргүүн Колтон хэллээ. Канад 20 жилийн турш өдөр бүр 200,000 баррель нефть гаргах юм.

Манай гол хэрэглэгч

Өрөмдлөгийн шинэ технологийн ачаар АНУ өөрөө ч өмнө нь илрүүлээд олборлож чаддаггүй байсан асар их нөөцтэй болсон. Энэ хямдхан, эдийн засгийн үр өгөөжтэй өрөмдлөгийн шинэ технологийн хойноос хятадууд амиа өгөхөд бэлэн гүйж байна.Сэтгэл нь хөөрүү Обама 2009 онд Хятадын дарга нартай уулзахдаа БНХАУ-д шинэ технологио өгөхөөр амлачихаж.

Хятадын “Синопек” 2017 онд Канадаас Хятадад импортлох нефтийг танкераар зөөхөд зориулж Альбертаас Китимат хүртэл нефть дамжуулах хоолой татах төслийг 5.5 тэрбум ам.долларааp санхүүжүүлж байна. Ойрын жилүүдэд 15-аас 20 тэрбум баррель газрын тосны хэрэгцээ тулчихаад байгаа Хятад Венесуэль улсын зүүн хойт нутагт Оринокогийн бүсийг эзлэхээр хөөцөлдөж байгаа. Хятад улс өөрөө ч баруун ба төв нутгаараа чулуужсан занарын хийн асар их нөөцтэй юм билээ. Удахгүй үүнийгээ олборлох технологитой болох гэж байна.

БНХАУ 2020 он гэхэд эрчим хүчний 10 хувийг занарын хийгээр хангах бөгөөд энэ оны зургадугаар сард чулуужсан занарын хийн анхны дуудлага худалдаа хийх гэж байна. Хятадууд ч бас хүн болохоор нүүрсний утаанд хахаж байхыг хүсэхгүй, хотуудынхаа агаарыг цэвэршүүлэхийн тулд нүүрснээс татгалзаж, байгалийн хийгээр орлуулахаар төлөвлөн занарын хийн технологийг дэмжиж мөнгө хаяж байна. Тэд нефтиэс илүү байгалийн хий олборлох технологид шунаж байна.

Нефтийг тойрсон жижиг улс төр

Манай нүүрс хэдийгээр төмөрлөгийн үйлдвэрт зориулагдсан өндөр чанарын коксжсон нүүрс боловч тайвширч сууж болохгүй, түүхий эдүүдээ аль болох боловсруулж гарган дэлхийн зах зээл дээр үнэ цэнийг нь нэмэгдүүлэх тал дээр шаргуу ажиллахгүй бол ядуугаасаа хэзээ ч салахгүй.

Бид Өмнөговиос нүүрс, Дорнодын Матадаас нефть олборлож гадагш нь экспортолж, оронд нь нефть импортолж, машиндаа бензин авдаг. Яг л кофе ургуулж тариад таван ам. долларааp экспортлоод дэлгүүрээс “Нескафе” 15 ам. долларааp авч уудаг кеничүүд шиг чөтгөрийн тойрогт амьдарч байна. Нэг, хоёр агентлагийн даргыг солиод ч бид энэ тойргоос гарахгүй нь бүр тодорхой. Ард түмний бухимдлыг түрхэн зуур дарсан заль юм уу? Эсвэл аргаа ядарсан арга юм уу? Ядаж салбарын сайдад нь хариуцлага тооцчихгүй дээ. Манай нефтийн бодлого дэндүү жижиг.

Өрөмдлөгийн шинэ технологи

Энэхүү шинээр илэрсэн хэдэн зуун сая баррель нөөц ирэх арван жилд зах зээлд нэвтэрч байгаа нь дэлхийн геополитикийн болон эдийн засгийн тооцоог өөрчилж байна. Түлшний хэрэглээний өсөлт АНУ, Европоос Хятад, Энэтхэгт болон бусад хөгжиж байгаа улсуудад шилжиж байгаатай адил өрөмдлөгийн шинэ буум нь Ойрхи Дорнодоос эрчим хүчний »



http://www.mongolianeconomy.mn



глобал нөөц гэсэн тодорхойлолтоос холдуулж байна.

АНУ хагас зууны турш гинжлэгдсэн Ойрхи Дорнодоос хамаарах хэрэггүй болов. Хятад, Энэтхэг улсууд өргөжиж байгаа дунд ангиа цэнэглэх түлштэй болов. Япон, Европын улсууд цөмийн эрчим хүчнээс татгалзах боломжтой болов. Түлшний үнэ өсөхөөс хэн хэн нь айх хэрэггүй боллоо. Энэ боломжийг өрөмдлөгийн шинэ технологи өгчээ. Чулуужсан занараас гидрокарбон олж үйлдвэрлэдэг болж, Пенсилвань, Техас, Луизана зэрэг зарим муж сүүлийн таван жилд өөрсдийгөө байгалийн хийгээр хангаж ирсэн нь АНУ-ын Засгийн газар болон корпорациудын үзэл бодлыг огцом өөрчилжээ.

Энэхүү шинэ өрөмдлөгийн технологи нь шинэ ба хуучин технологийн холимог юм. Өндөр даралттай ус, элс, химийн бодисоор чулууг буудаж зүсдэг байсан хуучин аргыг газрын гүн рүү босоо өрөмдөөд зогсохгүй хөндлөн өрөмдлөгийн аргатай хослуулж хэрэглэх болжээ. Гүнд байгаа нефть хийн ордод нэвтрэхийн тулд олон босоо нүх өрөмдөж шахаж гаргадаг байсан хуучин аргын дэргэд нэг нүх босоо өрөмдөөд, түүнээсээ нефть хийн судлаа дагаж хөндлөн өрөмдөх болсон нь эдийн засгийн хувьд тун хэмнэлттэй юм. Нэг хөндлөнгөөр зогсохгүй олон нүх чанх хөндлөн салбарлан өрөмдөж олборлох болжээ. Энэ арга газрын гүний халуун, хатуу чулуулгийг нэвтлэхийн сацуу жижиг болохоор эдийн засгийн ашиггүй гэж орхигддог байсан олон ордуудыг олборлох боломжийг нефтийн компаниудад олгов.

Этгээд чулуужсан түлшний шинэ үе

Шинэ технологи ашигласнаар чулуужсан занарын хий олборлолт 2006 оноос тав дахин өсч, АНУ байгалийн хий олборлолтоороо дэлхийн тэргүүлэгч үйлдвэрлэгч ОХУ-ыг 2009 онд гүйцэж түрүүлжээ.

Харин бусад улсад энэ дэвшлийг чимээгүй харж байна. Франц, Герман, Өмнөд Африк, Британи, Украйн улсууд энэ талын технологийг зогсолтгүй судалж байна. 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний 14 хувийг занарын хийгээр хангаж, 32 улс үүнд тэргүүлж оролцох болно гэж америкчууд тооцоолж байна. Польш, Герман, Швед, Франц, Украйнд занарын нөөц байгаа юм. Европ хийн 60 хувийг импортолдог бөгөөд үүнийхээ тал хувийг ОХУ-аас авч байна.

Түүнчлэн АНУ сүүлийн үеийн инженерийн дэвшилт технологиор занарын хийгээс (shale gas) гадна газрын тос (oil) гаргаж авч байна. Хойт Дакота, Монтана мужуудын Баккены ордоос 400,000 баррель ийм газрын тос олборлож байгаа бөгөөд 2015 он гэхэд нэг сая баррельд хүргэнэ гэжээ. Эдгээртэй төстэй ахиад 20 орд бэлэн байгаа юм байна.

Арктик

Өрөмдлөгийн шинэ технологи өмнө нь хүрэх боломжгүй, хэтэрхий үнэтэй байсан далайн гүнээс нефть, байгалийн хий олборлох болов. АНУ-ын геологийн судалгаагаар хойт туйлын Арктикт дэлхийн газрын тос, байгалийн хийн дөрөвний нэг байгаагаас 80 хувь нь далайн эрэг хавьд байна гэж зарлажээ. 1960-аад онд Орос ба Аляскад том ордууд нээснээс хойш өдгөө Орос, Аляска, Канад, Норвегид 40 гаруй ордод олборлолт явуулж байна.

Далайн гүний нефть ба хийн нөөц

2000 онд далайн гүнээс нефть олборлож байсан 20 байгууламж л дэлхий дээр байсан бол одоо 200 хүрч, тоо нь өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Эдгээр цооног дэлхийн газрын тосны нөөцийн найман хувийг хангаж байгаа бөгөөд ирэх 2020 он гэхэд олборлолтын хэмжээ хоёр дахин өсөх болно. Мексикийн булан, Бразилийн эрэг, Австрали, Энэтхэг ба Африкийн баруун эргийн дагуу дээрх цооногууд байрлаж байна.

Сүүлийн жилүүдэд геологичид хүчирхэг компьютер технологийн тусламжтайгаар сейсмик тооцоонд үндэслэж далайн ёроолоос доош 15 мянган футын гүнд нефть олж байна. Зузаан давсан давхаргын доорх ашиглаагүй ордуудыг гурван ээлхүүнт дүрслэлээр сейсмик зураглалыг гаргаж чаддаг болсон.

Хүчний тэнцвэр шилжив

Шинэ эрчим хүчний эх үүсвэрээс хамгийн их хожиж байгаа улс нь АНУ юм. 1960 оноос өмнө Персийн булан болон Хойт Африкийн ордуудыг тус улсын компаниуд эзэмшиж автократ эрх баригчидтай эвсэж байсан боловч 1970 оноос ОПЕК дэлхийн газрын тосны удирдлагыг авч АНУ бараг л дайсан болсон билээ. Одоо байдал эсрэгээр эргэж байна. АНУ нь Канад, Бразил ба Хойт Африкийн нөхөрсөг улсуудаас эрчим хүчний эх үүсвэрээ бүрэн хангаж эхэлж байгаа болохоор Ойрхи Дорнод өөрийнх нь эсрэг газрын тосыг зэвсэг болгон хэрэглэхээс нэгэнт айхгүй болжээ. Иймээс л АНУ Афганистан, Ираакаас цэргээ гаргаж, Ойрхи Дорнодыг орхиж байна. Гэтэл нөгөө талд БНХАУ, Энэтхэгийн газрын тос олборлодог улсын компаниудыг Өмнөд Хятадын тэнгист өрөмдөхийг хориглож, шинэ ордуудаас болж сөргөлдөх болов. Яг адил шалтгаанаар Турк Киприйг дарамтлах болжээ. 2035 онд дэлхийн эрчим хүчний эрэлт 50 хувь өсөх бөгөөд үүний ихэнх нь Хятад, Энэтхэг болон бусад хөгжиж байгаа улсад ногдох юм.

Харин Европт нефть, байгалийн хий экспортолдог гол улс ОХУ-ын хувьд шинэ технологийн улмаас ихээхэн алдагдал амсч, ирээдүй нь бүүдийгээд байна. Саяхан Казахстан, Туркменистанд нефть байгалийн хийн маш том ордууд илэрч, шинэ өрсөлдөгчид тодорчээ.

Харин энэ шинэ ертөнцөд бидний эзлэх байр суурь хаана байх вэ? Бидний өмнөөс Монголын ямар компани тоглох вэ? Монголд томдож, дэлхийд жижигдэхийн зовлонг яаж гэтлэх вэ? Дээрх асуултууд эдийн засагч миний толгойд хариулт нэхэж байгааг Та бүхэнтэй хуваалцлаа. ■

http://www.mongolianeconomy.mn

Эрчим хүч

Гэрэл зөөгч



“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” хувьцаат компанийн төлөвлөлт, Эдийн засгийн хэлтсийн дарга Х.Эрдэнэчулуунтай ярилцлаа.

-Хоёулаа манай гэрт гэрэл, цахилгаан хэрхэн өртөөлөн хүрдэг талаар ярилцлагаа эхлэх үү?

-Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ компани айл гэрт гэрэл, цахилгаан хүргэж өгөөд өдгөө 80 жил болжээ. Манай компани Монгол Улсын нийт хүн амын 50 орчим хувийг цахилгаанаар хангаж байна. Цахилгаан эрчим хүчийг түгээх, хангах гэсэн хоёр үндсэн зөвшөөрлийг хуулийн дагуу эзэмшдэг. Түгээх тусгай зөвшөөрөл гэдэг нь эрчим хүчийг хэрэглэгчдэд хүргэж байгаа техник технологийн өргөтгөл шинэтгэл, засвар үйлчилгээний ажлуудыг хамааруулж үздэг. Харин хангах тусгай зөвшөөрөл нь хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч борлуулах, тэрхүү орлогыг цуглуулж, үйлдвэрлэгчдэд хуваарилах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Ерөнхийдөө ийм хоёр чиглэлээр үйл ажиллагаа явагдаж хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч очих нөхцөлийг бүрдүүлдэг.

Харин эрчим хүч айлд очих хүртэлх дэс дарааллыг яривал ихээхэн ярвигтай. Эхлээд цахилгаан станцууд том, том зуухандаа гал түлж эрчим хүчээ гаргаж авна. Тэр гаргаж авсан эрчим хүчийг манай компани худалдаж аваад эргүүлэн хэрэглэгчдийн гарт худалдана гэдэг ч юм уу. За тэгээд эрчим хүчийг хувиргахаас аваад нарийн ширийн зүйл их бий.

-Ер нь цахилгаан эрчим хүч түгээж байгаа компанийн үр ашигтай ажиллагааг дүгнэх хамгийн гол үнэлгээний зарчим юу байдаг вэ?

-Эдийн засгийн хувьд компанийн үр ашгийг хэмждэг гол үзүүлэлт бол үйл ажиллагаанаас олж байгаа орлогын хэмжээнээс шууд хамааралтай. 2011 оны хувьд манай хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэн. Борлуулалт нэмэгдээд ирэхээр мэдээж түүнээс олох орлогын хэмжээ өснө гэсэн үг. Тухайлбал, 2011 оны тухайд борлуулсан нийт цахилгаан эрчим хүч 36,4 сая квт/цагаар нэмэгдсэн байна.

Орлогын хувьд төлөвлөж байснаас 4,7 тэрбум төгрөгөөр өссөн гэдэг нааштай үзүүлэлт өнгөрөгч онд гарчээ. Энэ мэт орлогоос гадна бидний хувьд үр ашигтай ажиллагааг дүгнэх бас нэг гол хүчин зүйл бол алдагдлын тухай асуудал юм. Энэ талын үзүүлэлт сүүлийн есөн жил тасралтгүй буурч байна. 2003 онд нийт эрчим хүчнийхээ 34 хувийг алдагдал болгоод үргүй хаячихдаг байсан бол 2011 оны байдлаар 20,45 хувь хүртэл бууруулж чадсан гэдэг судалгааны дүн бий. Бас нэг чухал үр ашгийн талаарх ойлголт бол хэрэглэгчийн хэрэглэсэн эрчим хүчний хэрэглээний төлбөрийг хураах явдал.

2011 оны байдлаар бид төлбөрийг 100 хувь хураасан гэдэг дүн гарсан. Энэ нь нэг талаар иргэдийн амьжиргаатай шууд холбоотой. 2005 оноос өмнө цахилгааны төлбөр дээр иргэд өр үүсгэх, түүнээсээ булталх зэрэг сөрөг үр дагавар их гаргадаг байсан. Харин одоо тийм асуудлаар толгой өвтгөхөө байсан. Энэ бүгдээс харахад бид амжилттай ажиллажээ гэж дүгнэж болох юм.

-Та эрчим хүчний алдагдлын талаар хэллээ. Энэ талаар хэрэглэгчид ч мөн ярьдаг. Алдагдлаа алга болгож чадахгүй байж төлбөр нэмэх талаар ярих хэрэггүй гээд л. Энэ тухайд та тайлбарлаж өгөхгүй юу?

-Эрчим хүчний алдагдал үндсэн хоёр шинжтэй байдаг. Эхнийх нь техникийн алдагдал. Бид хэрэглэгчдэд эрчим хүч хүргэж өгөхийн тулд шугам сүлжээ ашиглана. Энэ сүлжээний технологи нь эрчим хүч түгээхийн тулд бас эрчим хүч хэрэглэдэг. Товчхондоо техник ажиллахын тулд ашиглаж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг бид техникийн алдагдал гэдэг юм. Энэ бол гарах ёстой алдагдал. Гэхдээ бид үүнийг багасгахын тулд техникийн шинэчлэл байнга хийсээр байгаа. Дараагийнх нь арилжааны алдагдал. Хэрэглэгчдийн зүгээс үзүүлж буй зохисгүй хэрэглээ, тоолуурын үйл ажиллагааг алдагдуулах, эрчим хүчийг хулгайгаар хэрэглэх гэх мэт арилжааны

http://www.mongolianeconomy.mn

шинж чанартай юм. Тиймээс эрчим хүчний алдагдлыг бууруулахын тулд бид арилжааны алдагдлыг бууруулах нь нэн тэргүүний ажил гэж ойлгож болно. Энэ бол хэрэглэгч болоод түгээгчийн хамтын ажиллагааны үндсэн дээр бий болох ёстой ажил. Мөн цахилгааны үнийн дүн энэ асуудалтай шууд хамааралтай. Зарлагаасаа бага орлого олно гэдэг мөн арилжааны алдагдал болдог. Техникийн алдагдал бол байх нь зайлшгүй.

-Эрчим хүчний үнийн хувьд манайд дэлхийн жишгээс нэлээн доогуур байдаг. Энэ талаар таны бодол ямар байна вэ?

-Эрчим хүчний үнэ тарифыг "Эрчим хүчний зохицуулах газар" гаргадаг. Тухайн байгууллага нь эрчим хүчийг үйлдвэрлэгчээс гараад түгээх төвөөр дамжаад өрх гэрт хүрэх хүртэлх зардал тооцоог гаргаад үнийг тогтоож байгаа. Эндээс харахад үнэ тогтоох үйл явцын ердөө л нэг хэсэг дээр манай компани ажиллаж буй юм. Тиймээс компанийнхаа хувьд л ярьж болж байна.

Эдийн засгийн өнөөгийн бодит үнэ гэвэл манай компанийн хувьд тийм ч хангалттай биш. Тухайлбал, сүлжээний өргөтгөлийн ажил төлөвлөгөөт хуга-цаанд хийгдэж чадахгүй байна. Энэ нь хөрөнгө мөнгөтэй шууд хамааралтай. Үүнтэй холбоотой хэрэглэгчийг бүрэн дүүрэн эрчим хүчээр хангаж чадахгүйд хүрдэг. Эрчим хүчний хэрэглээ гэдэг ер нь байнга өсөн нэмэгдэж байдаг л даа. Үүнийг хангахын тулд бид ч байнга өсч дэвжиж байх хэрэгтэй. Хэрвээ цахилгааны үнэ бодит байсан бол сүлжээний өргөтгөлийн ажил бидний хувьд тулгамдсан асуудал болохгүй байсан. Дэлхийн стандартаар нэг кВт цахилгааны үнэ 108 төгрөг байдаг юм билээ. Харин манайд нэг квт/ цаг цахилгааны үнэ 88 төгрөг байгаа. Хэрвээ үнэ нэмэгдвэл хэрэглэгчдийн дунд эрчим хүчний хэмнэлтийн талаарх ойлголт ч мөн хэрэгжиж эхлэх байх. Эрчим хүчээ хэмнээд ирэхээр бидний гэрлийн мөнгө урдын л адил хэмжээтэй гарч болно гэдгийг ойлгох хэрэгтэй.

-Эрчим хүчний хэмнэлтийн талаар бид их ярьдаг боловч хэрэгжүүлж чаддаггүй. Энэ талаар зөвлөмж зөвлөгөө ч ховорхон байдаг. Тэгвэл танай компани ямар арга хэмжээ авч байгаа вэ?

-Манай компанийн хувьд "Хэрэглэгчдэд үйлчлэх төв" гэж бий. Энэ төвд хэрэглэгчид хандвал мэргэжлийн талын бүх л зөвлөгөөг өгдөг. Эрчим хүчээ хэрхэн хэмнэх талаар асуувал хэлээд л өгчихнө. Гэхдээ албадах эрх бидэнд байхгүй. Харин санал болгож болно. Тухайлбал, сүүн гэрэл хэрэглэх нь таны эрчим хүчний хэрэглээг 50 хүртэл хувиар хэмнэх боломжтой талаар байнга хэлдэг. Цахилгаан эрчим хүчний тоноглолыг ямар үзүүлэлттэйг нь худалдан авч болох талаар зөвлөгөө өгч байгаа. Мөн хамгийн их хэлдэг зүйл бол цагийн ялгавартай тоолуур хэрэглэх. Өнөөдөр хэрэгжиж байгаа үнийн хувьд шөнийн тариф нэг квт/ цаг цахилгааны үнэ 40 төгрөг. Тэгвэл та шөнийн цагаар зарим нэг илүүдэл цахилгааны хэрэглээгээ ашиглаж болох талаар ч юм уу. За тэгээд хүн байхгүй өрөөнийхөө гэрлийг унтраах гээд эрчим хүч хэрхэн гамнах талаар олон боломж бий. Манай компаниас гарын авлага гаргах ажил төлөвлөсөн байгаа.

-"Хэрэглэгчдэд үйлчлэх төв"-ийн талаар иргэд сайн мэддэггүй. Гэрэл тасарлаа гэхэд ямар шалтгааны улмаас тасарсан гэдгийг ч мэдэх учраа олдоггүй шүү дээ. Энэ талаар та тайлбарлаж болох уу?

-Дүүрэг бүрт "Хэрэглэгчдэд үйлчлэх төв" гэж бий. Энэ талын мэдээллийг www.ubedn.mn сайтаар орж авах боломжтой. Мөн 343048 дугаараас эрчим хүчний тасалдал гарахад шууд холбогдоод шалтгааныг асууж болно.

-Хэрэглэгчдийн зүгээс хүчдэл дутуу ирлээ гэх гомдол байдаг. Тэр дундаа гэр хорооллын иргэдийн дунд ийм гомдол их бий. Энэ нь юунаас шалтгаалдаг юм бол?

-Хэрэглэгчдэд хүрч байгаа хүчдэлийн стандарт түвшин 220 вольт. Техникийн шинэчлэл хийгдээгүй байсан үед энэ бол асуудал байсан. Хэрэглэгчид "шонгийн мод"-ноос шууд цахилгаан авдаг байсан үед хүчдэл хэрэглэгчдийн гар дээр багасч очих нь элбэг байсан л даа. Харин одоо өөр болсон. Гэхдээ хөдөө орон нутгаас хот руу шилжин ирэгсдийн тоо өдөр ирэх бүр л нэмэгдэж үүнтэй холбоотой эрчим хүчний хэрэглээ маш их нэмэгдэж байна.

Дээр хэлсэнчлэн эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг дагаад техник технологи ч мөн адил сайжрах шаардлагатай. Хэдийгээр манайх хөгжлийнхөө зорилтод Европ стандартыг нэвтрүүлэх тухай тусгаж, олон ажил хийж байгаа боловч хэрэглээний тэр их өсөлтийг гүйцэж чадахгүй байна. Тиймээс ачаалал хэт авахаар хүчдэлийн түвшин багасах тохиолдол байдаг. Гэхдээ технологийн төсөл хэрэгжсэн гэр хороололд энэ талын асуудал байхгүй болсон. Нэг жишээ дурьдахад 2010 оны байдлаар трансформатор буюу хүчдэл хувиргаад дамжуулах гол төхөөрөмжид хэрэглэгчдийн хэт ачаалалтай холбоотой 116 удаа гэмтэл гарч байсан. Харин 2011 оны тухайд 48 болтлоо буурсан. Цаашдаа энэ тоог улам бууруулах нь бидний зорилго. Нийслэлийн зуслангийн тухайд хүчдэл хамгийн хүндрэлтэй. Шинэчлэл хийгдээгүйн улмаас иргэд хулгайгаар цахилгаан авах, хүчин чадлаа даахгүй

Хэрвээ цахилгааны үнэ бодит байсан бол сүлжээний өргөтгөлийн ажил бидний хувьд тулгамдсан асуудал болохгүй байсан. Дэлхийн стандартаар нэг кВт цахилгааны үнэ 108 төгрөг байдаг юм билээ. Харин манайд нэг квт/ цаг цахилгааны үнэ 88 төгрөг байгаа. Хэрвээ үнэ нэмэгдвэл хэрэглэгчдийн дунд эрчим хүчний хэмнэлтийн талаарх ойлголт ч мөн хэрэгжиж эхлэх байх.

байх гээд асуудал их гардаг. Тиймээс зуслангийн айл өрхөд эрчим хүч түгээх, хүргэх асуудлыг шийдэх л ёстой.

-Өнөөдөр танай компанид хамгийн их тулгамдаад байгаа асуудал юу байна вэ?

-Тулгамдаж байгаа асуудлын талаар тоочоод байвал барагдахгүй. Тиймээс манай 1600 гаруй ажилтан санаа сэтгэл нэгтэй зүтгэж чадвал бүх саад бэрхшээлийг даван туулж чадна гэж боддог. Энэ л бодлоор ахмадууд маань болоод бид жигүүрлэн ажилласаар өдгөө 80 жилийн түүхийг бүтээчихсэн байна. Тиймээс компанийнхаа бүх ажилтандаа 80 жилийн ойн баярын мэнд хүргэхийн ялдамд "Бид хамтдаа чадна" гэж хэлмээр байна. ■

http://www.mongolianeconomy.mn



Хууль

Зээлээ аваарай

Б.Уганбаяр

Их хүлээлт тээсэн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг энэ сарын 9-нд УИХ-аар хэлэлцэж баталлаа. Хуулийн хүрээнд зээлийн батлан даалтын шинэ санг байгуулж буй нь гол онцлог аж. Тус сан нь төр, хувийн хэвшлийн хамтарсан байгууллага байх бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 20 хүртэлх сая төгрөгийн зээлийг 60 хүртэл хувиар батлан даах байдлаар тооцжээ. Дээр нь Зээлийн батлан даалтын санг давхар ХХААХҮЯ-ны дэргэдэх Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан/ЖДҮХС/-гаас мөн батлан даахаараа онцлогтой.

Хуулийн дагуу удирдах зөвлөл нь сангийнхаа гол ажлыг зангидаж, ямар шалгууруур, хэчнээн аж ахуйн нэгжид, хэдий хэмжээний зээлийг ямар хэлбэрээр өгөх, үүрэг хариуцлагын системийг тогтоох, эрсдэл хэрхэн үүрэх болон сангийн үйл ажиллагааны тогтвортой байдал зэрэгт санаа тавьж ажиллах юм байна. “Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, засаглал нь эрүүл, өмнө нь бизнес эрхэлж байсан туршлагатай, банкны зээлийн эрсдэлд орж байгаагүй аж ахуйн нэгжид тус зээлийг олгох нь илүү зүйтэй” гэдгийг ЖДҮГ-ын дарга Ц.Ням-Осор сануулсан. Мөн шинээр бизнес эрхэлж байгаа хүмүүсийн бизнесийг хөл дээр нь босгох боломж өгөх нь чухал гэдгийг ч тэрбээр хэлсэн.

Зээлийн батлан даалтын сан нь удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, Зээлийн батлан даалтын хороо болон зохион байгууллалтын бусад бүтэцтэй байхаар хуулиндаа тусгажээ. Ингэхдээ Удирдах зөвлөл 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байх аж. Үүнд төсөв мөнгө мэддэгээрээ Сангийн яам, ЖДҮХС-гаас тус бүр нэг, МҮХАҮТ, Монголын банкуудын холбоо, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон салбарын бие даасан мэргэжилтнүүд гэх мэт есөн төлөөллөөс бүрдэнэ.


Түүнчлэн хувь нийлүүлж, хөрөнгө босгож оролцох боломжтой бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүдийн тоог ижил тэнцүү байлгаж ашиг сонирхлын зөрчлийг бага байлгах нь зүйтэй гэдгийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн дэд дарга С.Байгальмаа хэлсэн. Ер нь дэлхийн жишигт Зээлийн батлан даалтын санг хөл дээрээ босоход төрийн зүгээс хөрөнгө санхүүгээр нь дэмжиж, оролцдогүйг тэрбээр тэмдэглэж байлаа.

“Цуутай хүүхэн хуримтай байг”

Зээлийн батлан даалтын сан нь эхний ээлжинд 3-5 тэрбум төгрөгийн дүрмийн сан буюу гарааны хөрөнгөтэй байхаар төлөвлөж байгаа аж. Гэхдээ сан нь өөрийн хөрөнгийг 20 дахин нэмэгдүүлэх хүртэл хэмжээний хөрөнгөөр аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн зээлийг батлан даах боломжтой гэдгээрээ нэлээд давуу талтай.

“ЖДҮГ 285 тэрбум төгрөгийн зээлийг 4572 аж, ахуйн нэгж, хувь хүнд өнгөрсөн хугацаанд хөнгөлөлттэй зээлээр олгосон бол Зээлийн батлан даалтын сан гурван тэрбумаар эхлэхэд л таван жилийн дотор 1600 орчим бизнес эрхлэгчийг зээлд хамруулах боломжтой гэсэн тоог Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс гаргажээ. Хэрэв хуулийг зүй зохистой хэрэгжүүлбэл бага хөрөнгөөр их үр дүнд хүрнэ гэсэн үг. Гэхдээ нөгөө талд нь Засгийн газар ихээхэн эрсдэлд унах аюултайг ч Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал Д.Дэмбэрэлдорж сануулж байлаа.

2009-2011 оны Хөнгөлөлттэй зээл /улсын хэмжээнд/



Эх сурвалж: ЖДҮГ

http://www.mongolianeconomy.mn

Хуулийн өөр нэг том давуу тал нь эрсдэлийг хуваарилж буй зарчим аж. Бизнес эрхлэгчийн зээлийн эрсдэлийг арилжааны банк 40 хувь, батлан даалтын сан 60 хувь хариуцна. Зээлийн сан зах зээл нь тогтворжсон орнуудад зээлийн 80 хүртэлх хувийг дааж, Засгийн газар давхар 60-70 хувь батлан даадаг жишигтэй байдаг байна. Цаашдаа дэлхийн нийтийн жишигт нийцүүлж, Зээлийн батлан даалтын сан нь илүү эрсдэлийг даах тусам жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн таатай орчин бүрдэж, олон хүнд өгөөжөө өгнө гэдгийг ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Баярмагнай хэлсэн. Манай улсын 6000 орчим хүний амьдрал ахуйг нуруундаа үүрч яваа жижиг, дунд үйлдвэрийн салбарынхны чихийг мялааж, магнайг тэнийлгэх хууль гарсныг дуулгахад таатай байна. Гэхдээ хуулийн хэрэгжилт үр өгөөжтэй, эзнээ олсон байгаасай гэдгийг сануулж, хаширлах хүн цөөнгүй байна. Тийм болохоор Цуутай батлагдсан тус хуулийг “хуримтай” байгаасай гэж ерөөе.

Герман улсад зээлийн батлан даалтын банк ажиллаж ЖДҮ эрхлэгчид, ялангуяа шинэ бизнес эрхлэх гэж буй иргэдээ дэмжин ажилладаг байна. Ийм банкийг байгуулж ажилласнаараа жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжээд зогсохгүй ДНБ-ээ 3,6 тэрбум еврогоор нэмэгдүүлж, 23000 гаруй ажлын байрыг шинээр бий болгон улсынхаа төсөвт 830 сая еврог татвар хэлбэрээр эргэн төвлөрүүлсэн үр дүнтэй жишээ байдаг аж.

Дараагийн иш татах сайн жишээ гэвэл Италид түгээмэл байдаг хоршоо хэлбэрээр зээлийн батлан даалт хийх явц гэнэ. Ингэхдээ хэд хэдэн бизнес эрхлэгч нэгдэн сан байгуулж дундын хөрөнгө бий болгон түүгээрээ батлан даалт хийн банкнаас зээл авдаг ажээ. Сүүлд Индонез, Филипин, Япон гэх мэт Азийн орнуудад төрийн батлан даалтын сан байгуулагдаж эхэлсэн байна. Төр дангаараа өөрийн хөрөнгөөр ЖДҮ-ийн зээлийг батлан дааж, банкуудаар дамжуулан зээл олгох боломжийг бүрдүүлдэг. Гэхдээ хэт үнэтэй байсан, танил талдаа өгсөн зэргээр ашиг сонирхлын зөрчил үүсэж, зээл авсан иргэдэд ч төр хөрөнгийг нь төлөхөөс цааргалах зэрэг муу үр дүнг дагуулж, дампууралд хүргэжээ. Тиймээс донор байгууллагууд энэ тогтолцоог төдийлөн дэмжихээ больсон аж. Харин 20-иод жилийн өмнөөс төр, хувийн хэвшлийн хамтарсан батлан даалтын сан нь хамгийн зүй зохистой, үр өгөөжтэй, тогтвортойгоор зээлүүдэд батлан даалт хийх хэлбэр гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа юм. Энэ нь Зүүн хойд Азийн орнуудад ихээхэн түгсэн байна. Энэ нь төр, иргэний нийгмийн байгууллагууд, банкууд, олон улсын байгууллагууд хамтарч хөрөнгөө нийлүүлэн сан байгуулан, ЖДҮ эрхлэгчдэдээ Зээлийн батлан даалт хийдэг явц гэнэ. Манай улсын сонгож буй уг хувилбар дэлхийн 70 орчим улс оронд амжилттай хэрэгжиж буй гэдгийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс онцолжээ. Дэлхийн өндөр хөгжилтэй, эдийн засаг нь тогтворжсон орнуудад эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийнх нь өнгө төрхийг жижиг дунд, бичил бизнес эрхлэгчид тодорхойлдог аж. Энгийн жишээ татахад дэлхийн улсуудын нийт аж ахуйн нэгжийн 70-90 хувийг жижиг, дунд үйлдвэрлэгчид эзэлдэг байна. Тэгвэл бага дунд орлоготойд тооцогддог манай улсын энэ салбарт 559 мянган хүнийг нэгтгэсэн 66500 гаруй аж ахуйн нэгж бий.

“ЖДҮ-ийн салбар манайд дөнгөж эхийн хэвлийгээс төрсөн нялх хүүхэд шиг л арчилгаа шаардлагатай байна. Хууль эрх зүй, бодлого, санхүүжилтэд тулгарч байгаа асуудал олон бий” хэмээн Д.Дэмбэрэлдорж захирал онцолсон. Үүний нэг нь иргэд банкнаас зээл авахад зээлийн эрсдэл хэт өндөр, барьцаа хөрөнгө хүрдэггүй, хүрсэн ч зах зээлийн үнэлгээнээс маш доогуур тооцдогоос олон хүн зээлд хамрагдаж чаддаггүй байна. Энэ талаар Өвөрхангай аймгийн Жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Ц.Ариунаагаас сонирхоход “Манай аймгийн хувьд зээл хүсэж ирсэн иргэдийн 70-80 хувь барьцаа хөрөнгийн баталгаагүйгээс зээлд хамрагдах боломжгүй болдог. Тиймээс зээлийн батлан даалтын сангийн тухай хууль гарснаар олон хүнд үр өгөөжөө өгч, амьдрал ахуйгаа өөд татах боломж гарна” хэмээв.

Манай улсад 2006 оноос хойш жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 5000 орчим иргэн, аж ахуйн нэгжид зээл олгожээ. Гэхдээ хүсэлт ирүүлсэн нийт зээлийн дунджаар 25 орчим хувь нь барьцаа хөрөнгө хүрэхгүй гэсэн шалтгаанаар буцаагддаг гэсэн статистик тоог ЖДҮГ-аас гаргажээ.

2009-2011 оны Хөнгөлөлттэй зээл -орон нутаг /тоогоор/

д/д	Аймаг	Төсөл	Санхүүжилт	Шинэ үйлдвэр /сая төгрөгөөр	Өргөтгөсөн үйлдвэр
1	Архангай	201	3073	45	156
2	Баян-Өлгий	327	3367	79	248
3	Баянхонгор	180	3149	65	115
4	Булган	132	2303	53	79
5	Говь-Алтай	192	2267	57	135
6	Говьсүмбэр	653	2148	41	612
7	Дархан-Уул	209	4190	27	182
8	Дорноговь	135	2171	22	113
9	Дорнод	228	3077	39	189
10	Дундговь	118	2570	35	83
11	Завхан	208	2716	84	124
12	Орхон	112	2907	38	74
13	Өвөрхангай	199	3286	38	161
14	Өмнөговь	106	2246	62	44
15	Сүхбаатар	124	2018	66	58
16	Сэлэнгэ	130	1600	50	80
17	Төв	168	1839	30	138
18	Увс	224	4392	47	177
19	Ховд	245	3145	59	186
20	Хөвсгөл	202	2521	46	156
21	Хэнтий	108	2269	21	87

Эх сурвалж: ЖДҮГ

http://www.mongolianeconomy.mn

Манай нийтлэлийн дараа

Ангамал дэлхийн цангамал Монгол болох гэж үү



Баяртогтох та:
Баяртогтох шиг зөв судалгаа тооцоотой материалыг олон хүнтэй уулзаж, харьцуулан асуудал дэвшүүлсэн нийтлэл бичсэн сэтгүүлч ойрд харсангүй, уншсангүй. Монголын сэтгүүл зүйд үнэнийг бичих оюунлаг байх, асуудал дэвшүүлэх зарчим бараг үгүй болж сенсаац хөөсөн хов жив гүтгэлэг дүүрсэн хэвлэл харахаар дотор муухайрдаг юм. Таныг усны талаар дахин судалгаатай материал бичнэ гэж найдаж байна. Ялангуяа Монгол Улсын нутагт унасан тундас, цас, хөлдсөн мөс цэвдгийг хэнээс ч асуухгүй тогоондоо хуримтлуулж авах нэмэгдүүлэх төслийг унагадаг зарим төрийн түшээдийн битүү толгойд сүв нээж ухааруулахад чухал хэрэг болох юм. Танд тун их талархаж байна.

Усны газар Сосорбарам

Иргэн:
Зөв сэдэв хөнджээ. Гэвч одоо усны үнийг нь нэмбэл баячуудаас бусад нь авч чадахгүй үхнэ биз дээ. Цаг нь болохоор нэмэх хэрэгтэй.

Ус агаар шиг:
Монголчууд амин чухал зүйлсээ ус агаартай зүйрлэж, хайрлан хамгаалдаг уламжлалтай. Гэтэл одоо ус агаараа авах юмгүй бохирдуулсан. Алт, алт гэсээр 2000 голоо ширгээсэн нь үнэхээр үндэсний тэнэглэл газар авсан гэдгийг нотолж байна.

Уншигч:
Үнэхээр алж байна. Усныхаа үнийг нэмэх хэрэгтэй. Тэгвэл энд тэндгүй цоргоор гоожиж байгаа ус хаагдана. Аль ч байгууллагаар орсон “00”-ын өрөөнд нь цэвэр ус ямар ч хяналтгүйгээр урсаж л байдаг. Манай байгууллага дээр хүртэл тийм л байгаа. Дарга болон слесарь нарт хэлэхэд авч хэлэлцдэггүй юм билээ. Хэрвээ үнэтэй болох юм бол үргэлж хянана биз дээ. Сэтгүүлч нар энэ талаар тусгай сурвалжлага хийх хэрэгтэй. Мөн бүгдээрээ мод таръя л даа.

Уншигч:
Эдийн засагтай нь л ярихгүй бол угаасаа баахан хэвлэмэл материал тараагаад ямар ч нэмэргүй. Усны үнийг огцом нэмэх хэрэгтэй. Хамгийн үнэтэй байх ёстой зүйл маань хамгийн хямд байгаа шүү.

Зочин:
Байрны айлуудад тоолуур тавихад л болно. Хэрвээ тэгэх юм бол ус алдаад байгаа крантаа янзлуулах, шүдээ угааж байхдаа усаа хааж сурах гэх мэт олон хэмнэлтийг ухамсраараа хийдэг болно. Усаа хэмнээд, хэрэглээ нь багасаад, төлөх мөнгө нь бага гарахаар хүн урамшаад илүү их хэмнэхийг хичээдэг юм.

Рамзай:
100 дахин зөв. Хэн их хэрэглэнэ тэр хэмжээгээрээ мөнгөө төлдөг байя. Хэрэглээг нь дагаад үнэ нь өсдөг байвал яадаг юм бэ.

Зочин:
Бүх байрны усны хэрэглээг тоолуужуулах хэлбэрээр багасгаж болно. Ард түмний хэрэглээн дээр үнэ нэмж бас нэг дарамт болох нь дэмий. Харин усыг гол шиг хэрэглэдэг алт, зэс олборлох үйлдвэрүүдэд усны үнийг нэмэх хэрэгтэй.

Зочин:
Байрныхан ус замбараагүй хэрэглэдэг, би усаа хаа гэж үглэхээр. хар усанд юундаа ингээд байгаа юм ч гэх шиг. Тиймээс усны үнийг одоогийнхоос огцом нэмж байж хүмүүс хэмнэдэг болно.

Зочин:
Гэр хорооллынхон ус болон усны орчинг илүү бохирдуулж байгаагаараа илүү үнэ төлөх ёстой юм. Энд зохицуулалт хийх хэрэгтэй.

Зочин:
Уул уурхай хэр зэрэг ус хэрэглэж байгааг бичээч. Тэгвэл бидний хэрэглэж байгаагаас хамаагүй илүү бүр хүн итгэмээргүй тоо гарна даа. Яах вэ байрны хүмүүс 75 мөнгөөр бага л байгаа биз. Энэ бол асуудал биш ээ. Асуудал нь уул уурхайн хэрэглээ л байна. Аймаар тоо гарах байх даа.

Ус чандмань эрдэнэ:
Үнийг нэмэх хэрэгтэй. Ялангуяа ус ашиглаж ашиг олдог байгууллагын үнийг нэмэх хэрэгтэй. Усыг үнэд оруулах цаг нь болсон. Хар ус харамладаггүй гэдэг үг бий. Харин одоо хар усаа харамлаад, хайрладаг цаг ирсэн монголчууд аа.

Зочин:
Дэмжиж байна. Байрны айлууд литр тутамд 10 төгрөг төлөхөд болно ш дээ. Өдөрт 100 литр ус хэрэглэхэд 1000 төгрөг. Хэмнэвэл 500 төгрөг.

Зочин:
Усны үнийг нэмэх нь маш зөв, гэхдээ орон сууцанд амьдардгаас нь эхлээд 100 дахин нэмэх хэрэгтэй, ямбатай хүмүүс өдөр болгон хоёр цаг усаа гоожуулж шүршүүрт орохоо болих байлгүй, гэр хорооллын ядарсан ардууд дээр зовлон нэмээд хэрэггүй ээ.

Зочин:
Эхлээд уул уурхай, гадаад дотоодын хүмүүсийн тэр зохисгүй хэрэглээний тухай ярихгүй юу. Талх, байрныхаа мөнгийг арай гэж хүргэж байгаа ард олныг шулахыг л бодох юм аа.

Уншигч:
Үнэхээр усгүй бол яана гэж бодож байна. Өнөөдөр чи их идэж, их бие засах чинь хүртэл ирээдүйд болох усны хомсдолд нөлөө үзүүлж байна. Хүн ямар усыг үйлдвэрлэх биш хэрэглэгч учраас усаа зохистой хэрэглэж, их идэхгүй, их уухгүй өөртөө байгаа бүх зохисгүй хэрэглээнээсээ татгалзах хэрэгтэй. Ингэж байж л хүн бүр усаа чанд манаж, чадах бөлгөө. Иргэн та нэгийг бодогтун би ч бас одооноос усаа хэмнэнэ ээ.

gogo.1:
Гэр хорооллын иргэд юм угаасан үедээ л өдөрт 50 орчим литр ус хэрэглэдэг. Тэгэхэд орон сууцны айл 100-200 литрийг зөвхөн нэг өдөр энгийн хэрэглээндээ зарцуулдаг. Ингээд бодохоор хөөрхий муу гэр хорооллынхон ч хэцүү байгаа биз.

Нэн ядуугийн ангал руу нийтээрээ гулсах вий



Зочин:
Гэр хороололд амьдарч байгаа битгий хэл байр сууцтай ч гэсэн нэн ядуу амьдарч байгаа гэр бүл их байна аа. Нүд хальтирмаар….

Японоос:
Ёстой үнэнийг бичжээ. Сайн байна. Ингээд бичээд байгаарай. Монголын амьдрал ийм байхад дээд хэдэн баячууд нь эдийн засаг өсөж байна, улсын хөрөнгө нэмэгдэж байна ч гэх шиг. Хэлэх ч үг алга.

Иргэн:
Манай улс аль эрт нэн ядуугийн ангал руу гулсаад орсон шүү дээ. Статистик тоо дандаа худлаа гарч, эрх мэдэлтнүүдийн талд үйлчилж хувь, процентийг худлаа гаргадаг. Африктай адилхан болчихсон. Манайд үнэн зүйл гэж байхгүй. Нийгэм маань мөхлийн ирмэгт ирчихээд байна.

Баагий:
Тэмцэх л хэрэгтэй…

Зочин:
Одоохондоо 21000 төгрөгөөр өл залгуулж байгаа айлууд олон шүү.

Ялангуяа хөдөөд энэ мөнгөөр л амь зогоож байгаа. Тэгэхээр ядуурал ямар байгаа нь тодорхой биз дээ.

Зочин:
Төрийн түшээдийг өөрсдийг нь дагуулж явж үзүүлэх хэрэгтэй.

Уншигч:
Их хурал, Засгийн газрын гишүүдэд харуулах хэрэгтэй.

Зочин:
Баян хүн уншаад итгэх болов уу. Захын хорооллын дэлгүүрт байцааг дөрөв хувааж авдаг юм билээ. Хүмүүс ойлгохгүй байх аа. Тийм ядуу байгааг нүдээр хараагүй бол үнэмшихгүй байх.

Зочин:
Гадаадад байгаа монголчуудаа бүгдээрээ нэг дансанд мөнгө хийж Монголд байгаа хүмүүстээ зөв сонголт хийхэд нь тусалж сурталчилъя. Худал ярьдаг хүмүүсийг огцруулах сурталчилгаа явуулъя. Тэгэхгүй бол Монголд байгаа хүмүүсийг хэдхэн төгрөгөөр худалдаад л саналыг нь авчихна.

Зочин:
Энэ үнэн нийтлэл бичсэн байна. Та нар гэр хорооллын энэ олон нэн ядуу өрхийн амьдралыг дөнгөж захаас нь харж бичиж байна. Цаана чинь хогийн цэг дээр өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа Монголын ирээдүй болсон нялх хүүхдүүдийг хараарай. Монголын ард түмэн өдрөөс өдөрт уруудан доройтож байна. Өөдлөхөд санах сэрэх, уруудахад унтаж идэх гэж өвгөдийн сургаал алга болоод байна. Та нар энэ олон ядуу ард түмнээ бүгдийг нь энэ байдлаар газарт булах уу. Төрийн бодлогыг яалтай билээ. Ард түмнээ хараач ирээдүй болсон үр хүүхдээ хайрлаачээ.

Уншигч:
Уншаад зүгээр л өөрийн эрхгүй нулимс минь дусалж байна. Хүний нутагт хар ажил хийж хэдэн төгрөгтэй болчихоод Монголдоо очиж сайхан амьдарна гэж бодож байтал эх орон маань улам ядуураад байна. Бид ингэж амьдрах хувьтай гэж үү.

Франц:
Монгол ядуу болохоор залуучууд гадагшаа гарч байна.

Уншигч:
Монголын тухай бодохоос л дур гутах юм даа, авлигач луйварчид нь хэзээ нэг уутныхаа амыг хамхиж манийгаа нэг харах юм бол. Монгол мөхөж сүйрч байна.

Зочин:
Бид хөдөө хотын ялгааг арилгах талаар их ярьдаг болж. Яг үнэндээ Улаанбаатарт хөдөөнөөс дор усгүй, гэрэлгүй, замгүй, хашаагүй, “00”-гүй, хоолгүй айл их байна. Үүнийгээ арилгачихаад ялгаа ярих хэрэгтэй.

Зочин:
Улаанбаатарт ч бус бүр аймгийн төв Монгол даяар ийм айл өрх олон байна.

Дэлгэрмаа:
Энэ хүмүүст бэлэн мөнгө тараасаар амьдрал нь сайжрах уу. Сайжирч дээшилсэн нь хэд байна. Үүний оронд ажлын байр бий болгох, үр хүүхдийг нь цэцэрлэг, сургуультай болгох нь чухал. ■





www.mongolianeconomy.mn



MONGOLIAN
ECONOMY

Эдийн